



11. 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Демпингийн эсрэг татварын тухай Хэлэлцээр)

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Implementation of Article VI of the GATT 1994 (The WTO Agreement on Anti-Dumping Duties)
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по применению статьи VI Генерального соглашения по тарифам и торговле 1994 года (Соглашение об антидемпинговых пошлинах)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан «Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол» (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол; - Ерөнхий сайдын захирамж -1997, №6.

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

1. Худалдааны гажуудлыг арилгах арга хэрэгсэл (Trade Remedies):

- Чөлөөт худалдаа үргэлж шударга явагдаггүй.
- Олон улсын худалдаан дахь гажуудал (distortions in international trade):
 - Демпингийн шинжтэй (экспортлогч орны дотоодын зах зээлийн үнээс бага үнэтэй) экспортын бараа (dumped exports) импортоор орж ирэх;
 - Экспортоор гаргахад нь татаас (дэмжлэг) үзүүлсэн экспортын бараа (subsidized exports) импортоор орж ирэх.

- Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах дараах 3 арга хэрэгсэл байна (ДХБ байгуулах тухай хэлэлцээрийн “Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл”-ийн “З.Дэлхийн худалдааны байгууллага” гэсэн хэсгийн “Худалдааны бодлогын тоглоомын дүрэм”-ийг үзнэ үү):
 - Импортын барааны хувьд демпингийн шинжтэй болох нь тогтоогдсон бол (Dumping): Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ;
 - Импортын барааны хувьд түүнийг экспортлоход татаас (дэмжлэг) олгосон нь тогтоогдсон бол (Subsidization): Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ;
 - Тодорхой нэг барааны импорт огцом өссөн бол (Import surge): Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ.

2. Хэлэлцээрийн бүтэц:

I ХЭСЭГ:
1 дүгээр зүйл. Мөрдөх зарчим (Principles)
2 дугаар зүйл. Демпингийн тодорхойлолт (Determination of Dumping)
3 дугаар зүйл. Хохирлыг тодорхойлох (Determination of Injury)
4 дүгээр зүйл. Үндэсний үйлдвэрлэл (үйлдвэрлэгч)-ийн тодорхойлолт (Definition of Domestic Industry)
5 дугаар зүйл. Тандан судлах ажлыг санаачлах/эхлүүлэх ба явуулах (Initiation and Subsequent Investigation)
6 дугаар зүйл. Нотлох баримт (Evidence)
7 дугаар зүйл. Түр арга хэмжээ авах (Provisional Measures)
8 дугаар зүйл. Үнээ нэмэх талаар үүрэг амлалт авах (Price Undertakings)
9 дүгээр зүйл. Демпингийн эсрэг татвар ногдуулах, хураан авах (Imposition and Collection of Anti-Dumping Duties)
10 дугаар зүйл. Хэлэлцээрийн заалтыг буцаан хэрэглэх (Retroactivity)
11 дүгээр зүйл. Демпингийн эсрэг татвар төлөх болон үнийн талаарх үүрэг амлалтаа биелүүлэх хугацаа, хэрэгжилтийг хянан үзэх (Duration and Review of Anti-Dumping Duties and Price Undertakings)
12 дугаар зүйл. Тандалт судалгааны ажлын эхлэл, үр дүн, шийдвэрийн талаар нийтэд мэдээлэх, тайлбарлах (Public Notice and Explanation of Determinations)
13 дугаар зүйл. Захиргааны байгууллагын шийдвэрийг шүүхийн журмаар хянах (Judicial Review)
14 дүгээр зүйл. Гуравдагч улсын нэрийн өмнөөс демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Anti-Dumping Action on Behalf of a Third Country)
15 дугаар зүйл. Хөгжиж буй Гишүүн орнууд (Developing Member Countries)
II ХЭСЭГ:
16 дугаар зүйл. Демпингийн эсрэг арга хэмжээ хэрэгжүүлэх асуудал хариуцсан Хороо (Committee on Anti-Dumping Practices)
17 дугаар зүйл. Зөвлөлдөх ба маргаан шийдвэрлэх (Consultation and Dispute Settlement)
III ХЭСЭГ:
18 дугаар зүйл. Төгсгөлийн заалт (Final Provisions)
ХАВСРАЛТ I: Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 7-д зааснаар, тандалт судалгааг газар дээр нь явуулах журам (PROCEDURES FOR ON-THE-SPOT INVESTIGATIONS PURSUANT TO PARAGRPH 7 OF ARTICLE 6)
ХАВСРАЛТ II: Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 8-д заасан утгаар өөрт байгаа боломжийн мэдээлэл (BEST INFORMATION AVAILABLE IN TERMS OF PARAGRPH 8 OF ARTICLE 6)

3. ОХУ-ын мэргэжилтнүүдийн дүгнэлтээс:

Энэ Хэлэлцээрээр импортын барааг демпинг (dumping)-ийн шинжтэй гэж үзэх шалгуурыг маш тодорхой зааж өгсөн. Хэрэв экспортын барааны үнэ түүнтэй ижил төстэй барааны тухайн экспортлогч улс дахь дотоодын зах зээлийн үнээс доогуур бол холбогдох экспортын барааг демпингийн шинжтэй гэж үзнэ (2.1 заалт). Гэхдээ, Хэлэлцээрт зааснаар, дараах тохиолдолд уг шалгуурыг мөрдөхгүй (2.2 заалт):

- тухайн экспортлогч орны дотоодын зах зээл дэх худалдааны нөхцөл ердийн худалдааны нөхцлөөс өөр байх (жишээ нь: барааг дотоодын зах зээлд үйлдвэрлэлийн өртгөөс доогуур үнээр худалддаг);
- тухайн барааны дотоодын зах зээл дэх борлуулалтын хэмжээ бага байх.
- Энэ тохиолдолд экспортын үнийг дараах үнэтэй харьцуулан демпингийг тодорхойлох боломжийг уг Хэлэлцээрээр олгосон (2.2 заалт):
- ижил төстэй барааг гуравдагч улс руу экспортолсон гэрээний үнэ; эсхүл
- тухайн барааг холбогдох гарал үүслийн улсад үйлдвэрлэсэн зардал (the cost of production), түүнтэй холбогдон гарсан захиргааны зардал (administrative costs), тухайн барааг экспортоор худалдахад зарцуулсан болон нийт зардал (selling and general costs), мөн ашиг (profits).

Хэрэв аль нэг барааны дотоодын зах зээл дэх борлуулалтын хэмжээ тухайн барааг импортлогч улсад нийлүүлсэн хэмжээний 5% -тай тэнцүү буюу түүнээс дээш байвал дээрх аргуудыг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд экспортлогч орны дотоодын зах зээл дэх барааны хэвийн үнийг тогтоож болно гэж үздэг. Зарим тохиолдолд борлуулалтын хэмжээ 5%-иас бага байж болох боловч харьцуулалт хийх боломжтой гэдгийг нотлох ёстой.

Демпингийн эсрэг арга хэмжээг зөвхөн 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлд заасан тохиолдолд, мөн энэ Хэлэлцээрийн дагуу явуулсан тандалт судалгааны үр дүнг харгалзан авч хэрэгжүүлнэ (1

дүгээр зүйл). Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд тандалт судалгааны ажил хийгдэж, үндэсний үйлдвэрлэлд учирсан бодит хохирол, тийм хохирол учирч болзошгүй аюулыг олж тогтоосон, мөн уг хохирол, демпингийн шинжтэй импорт хоёр хоорондоо шууд холбоотой болохыг олж тогтоосон байх ёстой. Демпингийн тандалт судалгааны ажлыг Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд үндэсний үйлдвэрлэгчдийн зүгээс, эсхүл тэдний нэрийн өмнөөс бичгээр гаргасан албан ёсны өргөдөл/хүсэлтийг үндэслэн эхлүүлнэ/санаачилна (5.1 заалт). Онцгой тохиолдолд Засгийн газар өөрийн санаачилгаар эхлүүлж болно. Тандалт судалгааг эхлүүлэхдээ дараах шалгуурыг мөрдөнө:

- дээрх өргөдөл/хүсэлтийг дэмжиж буй үйлдвэрлэгчид нийт үйлдвэрлэгчдийн 50-иас дээш хувийг төлөөлж байх;
- дээрх өргөдөл/хүсэлтийг дэмжиж буй үйлдвэрлэгчид тухайн салбарын үйлдвэрлэлийн 25-аас доошгүй хувийг үйлдвэрлэдэг байх.

Үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах нэрийдлээр демпингийн эсрэг татвар ногдуулах тохиолдол дэлхийн түвшинд аажмаар нэмэгдсээр байна. Ийм арга хэмжээг ОХУ-ын экспортын зарим бараанд хэрэглэх тохиолдол идэвхтэй өрнөж байна.

4. Демпингийн эсрэг татварын хэлбэр

Демпингийн эсрэг татварыг дараах хэлбэрийн аль нэгээр, эсхүл хосолсон байдлаар тогтоосон байдаг:

- Барааны үнээс хувиар тогтоосон байх (Ad Valorem Duty);
- Барааны нэгжид мөнгөн илэрхийллээр тогтоосон байх (Fixed/Specific Duty);
- Импортын барааны хамгийн доод үнээр тогтоосон байх (Variable Duty - Minimum Import Price (MIP)).

5. Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал


Хүснэгт 18. ДХБ-ын зарим Гишүүдээс авч хэрэгжүүлсэн демпингийн эсрэг арга хэмжээ (1995.01.01-2016.12.31)

Улс	Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо	Улс	Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо
Энэтхэг	609	Авсртали	137
АНУ	395	Өмнөд Африк	137
Аргентин	241	Канад	135
Европын холбоо	314	Мексик	120
Бразил	241	Өмнөд Солонгос	88
Хятад	192	Индонези	60
Турк	179	Египт	59

Тайлбар: Демпингийн эсрэг нийт 3405 арга хэмжээ авч хэрэгжүүлсний 866 нь Хятадын эсрэг, 124 нь Энэтхэгийн эсрэг байна.

Хүснэгт 19. Демпингийн эсрэг 3058 арга хэмжээг бүтээгдэхүүнээр авч үзвэл (1995.01.01-2014.12.31)

Салбар	Демпингийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн тоо
Үндсэн металл болон түүгээр хийсэн эд зүйл	918
Химийн үйлдвэр болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	640
Хуванцар, резин, хаймар (каучук)-аар хийсэн эд зүйл	389
Оёмол, нэхмэл, сүлжмэл эд материал болон эд зүйл	253
Машин техник болон цахилгаан тоног төхөөрөмж	252
Цаас, цаасан хавтан болон эд зүйл	126
Чулуу, гипс, шил, шаазан бүтээгдэхүүн	123



Зураг 13. Демпингийн эсрэг арга хэмжээний үргэлжилсэн хугацаа



12. 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (ДХБ-ын Үнэлгээний Хэлэлцээр)

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Implementation of Article VII of the GATT 1994 (The WTO Valuation Agreement)
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по применению статьи VII Генерального соглашения по тарифам и торговле 1994 года (Соглашение об оценке таможенной стоимости)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан "Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол" (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол - Ерөнхий сайдын захирамж -1997, №6

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Зах зээлийн дундаж үнэ хэрэглэдэг, 1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр байгуулагдсан бөгөөд 1953 оны 7 дугаар сарын 28-ны өдөр хүчин төгөлдөр болсон “Барааг гаалийн зорилгоор үнэлэх тухай” Брюсселийн Конвенц (Convention on the Valuation of Goods for Customs Purposes - BDV - Brussels Definition of Value)-ийн Хэлэлцэн тохирогч талууд бараг бүгдээрээ энэ Хэлэлцээрт нэгдэн орсон байгаа. Энэ хэлэлцээрт гаалийн үнэлгээний дараах 6 аргыг заасан байдаг:

1. хэлцлийн үнийн арга (transaction value method, 1 дүгээр зүйл) - тухайн импортын бараанд төлсөн буюу төлбөл зохих бодит үнэ;
2. нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга (transaction value of identical goods, 2 дугаар зүйл);
3. ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга (transaction value of similar goods, 3 дугаар зүйл);
4. ялгавар үнийн арга (deductive value method, 5 дугаар зүйл);
5. нийлбэр үнийн арга (computed value method, 6 дугаар зүйл);
6. дээрх аргуудыг уялдуулан хэрэглэх арга (derivative/fall-back/residual method, 7 дугаар зүйл).

Эдгээр аргыг зөвхөн дээрх дэс дарааллын дагуу хэрэглэнэ. Гаалийн үнийг хамгийн эхлээд тухайн импортын барааны хэлцлийн үнээр тодорхойлохыг эрмэлзэнэ. Хэрэв боломжгүй бол дараа дараагийн аргыг хэрэглэнэ. Харин 4, 5 дугаар аргын дэс дарааллыг импортлогчийн хүсэлтээр сольж болно.

Энэ Хэлэлцээрт заасан гаалийн үнийн анхдагч суурь (the primary basis for customs value) нь 1 дүгээр зүйлд тодорхойлсон “хэлцлийн үнэ” болно. 1 дүгээр зүйлийг 8 дугаар зүйлийн хамт авч үзнэ. Өөрөөр хэлбэл, импортын барааны гаалийн үнэ нь тухайн барааг импортлогч орон руу экспортоор худалдахад бодитоор төлсөн буюу төлбөл зохих үнэ байх бөгөөд түүнд 8 дугаар зүйлийн дагуу зардлын тодотгол хийсэн (adjusted) байна.

Гаалийн үнийг хэлцлийн үнээр тодорхойлоход худалдан авагч тухайн барааг захиран зарцуулах, эсхүл ашиглахтай холбогдуулан дор дурдсанаас өөр хязгаарлалт байхгүй байна:

- (i) тухайн импортлогч орны хуулиар, эсхүл төрийн байгууллагын шийдвэрээр тогтоосон буюу шаардсан хязгаарлалт;
- (ii) тухайн барааг цааш нь худалдан борлуулах газар зүйн бүс нутгийг зааглан тогтоосон хязгаарлалт; эсхүл
- (iii) тухайн барааны үнэд мэдэгдэхүйц (substantially) нөлөөлөхгүй хязгаарлалт.

Энэ Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд зааснаар, гаалийн үнийг 1 дүгээр зүйлийн дагуу тодорхойлоход тухайн импортын бараанд төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд дараах зүйлийг нэмнэ:

- (a) худалдан авагч хариуцан гүйцэтгэсэн (incurred) боловч тухайн бараанд төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд ороогүй дараах зүйлийг:
 - (i) худалдан авахаас бусад комиссын шимтгэл болон зуучлагчийн хөлс;
 - (ii) гаалийн зорилгоор тухайн бараатай нэгдмэл байдлаар тооцогдох хайрцаг савны зардал;
 - (iii) материалын, эсхүл ажилбарын зардлын аль нь болохыг үл харгалзсан баглаа боодлын зардал;
- (b) тухайн импортын барааг үйлдвэрлэх болон экспортоор худалдахтай холбогдуулан ашиглуулахаар холбогдох худалдан авагчаас үнэ төлбөргүй, эсхүл хямдруулсан үнээр шууд, эсхүл шууд бус хэлбэрээр нийлүүлсэн дараах бараа, үйлчилгээнд ногдох, төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд ороогүй өртгийн хувь хэмжээ:
 - (i) тухайн импортын бараанд бүрэлдэхүүн болсон материал, бүрдэл хэсэг, эд анги, тэдгээртэй адилтгах зүйлс;
 - (ii) тухайн импортын барааг үйлдвэрлэхэд ашигласан багаж хэрэгсэл, цутгуур, хэв, тэдгээртэй адилтгах зүйлс;
 - (iii) тухайн импортын барааг үйлдвэрлэхэд зарцуулсан материал;
 - (iv) тухайн импортын барааг үйлдвэрлэхэд шаардлагатай бөгөөд импортлогч орны гадна хийж гүйцэтгэсэн инженерийн болон өөрчлөн шинэчлэх шийдэл, урлал чимэглэлийн болон дизайны ажил, ерөнхий бүдүүвч болон техникийн зураг төсөл;

- (c) үнэлж буй бараанд хамааралтай бөгөөд түүнийг худалдан борлуулах нөхцөл болгож худалдан авагчаас шууд, эсхүл шууд бус хэлбэрээр төлөх ёстой, төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд ороогүй оюуны өмчийн эрх ашигласны төлбөр (роялти) болон лицензийн (зөвшөөрлийн) хураамж;
- (d) тухайн импортын барааг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, ашигласнаас олсон орлогоос шууд, эсхүл шууд бус хэлбэрээр худалдагчид төлсөн хувь хэмжээ.

Гишүүн орон бүр, өөрийн хууль тогтоомжийг боловсруулахад, гаалийн үнэд дараах зүйлийг бүрэн, эсхүл хэсэгчлэн оруулах, эсхүл тийнхүү оруулахгүй байх талаар зааж өгнө:

- (a) тухайн импортын барааг импортын боомт буюу импортлох газар хүртэл тээвэрлэх тээврийн зардал;
- (b) тухайн импортын барааг импортын боомт буюу импортлох газар хүртэл тээвэрлэхтэй холбогдсон ачих, буулгах, арчлан хамгаалах зардал; болон
- (c) даатгалын хураамж.

Төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд энэ зүйлийн дагуу нэмэлт оруулахдаа зөвхөн тоон үзүүлэлтээр илэрхийлэгдэх, бодит тоо баримтыг үндэслэнэ.

Энэ Хэлэлцээрт заасан импортын барааны үнэлгээний аргуудыг 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр бүлэг (Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох)-т заасан байгаа. Уг хуулийн дагуу барааг Монгол Улсын хил хүртэл тээвэрлэхэд төлсөн буюу төлбөл зохих үнэ, зардал нь импортын барааны гаалийн үнэ болно. Импортлогч (эсхүл зуучлагч) дээрх аргуудын дэс дарааллыг үл алдагдуулан, аль тохирох аргаар нь гаалийн үнийг өөрөө тодорхойлж (self-assessment), гаалийн байгууллагад мэдүүлнэ. Гаалийн байгууллага импортын барааны гаалийн үнийг үнэн зөв мэдүүлсэн гэдэгт эргэлзэж байвал импортлогчоос нэмэлт мэдээлэл шаардах эрхтэй. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлалыг Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 63 тоот тогтоолоор баталсан байдаг.



13. Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Pre-Shipment Inspection
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по предотгрузочной инспекции товаров
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол” (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол - Ерөнхий сайдын захирамж -1997, №6

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Урагвайн раундын хэлэлцээний үеэр ТХЕХ-ийн Хэлэлцэн тохирогч хэд хэдэн орон ачуулалтын өмнөх шалгалт (АӨШ) хийдэг компаниуд төрийн хяналт шалгалтын ажлыг давхар хийх замаар олон улсын худалдаанд нэмэлт хүндрэл учруулж байгаа асуудлыг хурцаар тавьж, шүүмжилж байсан боловч 1992 онд АӨШ-ын тухай тусгай Хэлэлцээр байгуулагджээ. Энэ Хэлэлцээрт дараах зүйл тусгагджээ:

- АӨШ-ын үйл ажиллагаа гэдэг нь хэрэглэгч улс (АӨШ хийхийг гэрээний үндсэн дээр, эсхүл төрөөс зөвшөөрсөн улс орон) руу экспортлох барааг шалгахтай холбогдсон

дараах бүх үйл ажиллагаа болно (1 дүгээр зүйл):

- барааны чанарыг шалгах;
- барааны тоо хэмжээг шалгах;
- барааны үнийг шалгах, үүнд валютын ханш, санхүүжилтийн нөхцлүүд хамаарна; мөн/эсхүл
- барааны гаалийн ангиллыг шалгах;
- Хэрэглэгч улсын үүрэг (2 дугаар зүйл):
 - АӨШ хийлгэж буй аль ч экспортлогчийг үл ялгаварлах (2.1 заалт);
 - АӨШ болон дүгнэлт (Clean Report of Findings)-ийг бараа экспортлогч

орны гаалийн нутаг дэвсгэрт хийлгэх, хэрэв тухайн бараа нь АӨШ-ыг тэнд хийлгэх боломжгүй нарийн бүтэц зохион байгуулалттай бөгөөд гэрээний талууд зөвшөөрсөн бол тухайн барааг үйлдвэрлэсэн гаалийн нутаг дэвсгэрт хийлгэх (2.3 заалт);

- АӨШ-ыг гэрээнд тохиролцсон стандартын дагуу хийлгэх, хэрэв тийнхүү тохиролцоогүй бол олон улсын холбогдох стандартыг мөрдөх (2.4 заалт);
- АӨШ-ын үйл ажиллагаа нь ил тод байх (2.5-2.8 заалт);
- Бизнесийн мэдээллийн нууцыг хамгаалах (2.9-2.13 заалт);
- Холбогдох талуудын ашиг сонирхол зөрчилдөөс зайлсхийх(2.14 заалт);
- АӨШ-ыг шуурхай хийж гүйцэтгэх (2.15-2.19 заалт);
- Үнэ шалгахад анхаарах зүйлс (2.20 заалт);
- Давж заалдах журам (2.21 заалт);
- 2 дугаар зүйлийн заалтыг мөрдөхгүй байх тохиолдол (Derogation) - хэрэглэгч улс ижил төстэй ачилтанд мөрддөг хамгийн бага үнэ (a minimum value)-ээс доогуур үнэтэй ачилтыг ердийн тохиолдолд АӨШ-д хамруулахгүй байх (2.22 заалт);
- Экспортлогч улсын үүрэг (3 дугаар зүйл):
 - АӨШ-тай холбогдсон хууль тогтоомж, дүрэм журам нь үл ялгаварлсан, ил тод байх. Тэдгээрийг шуурхай хэвлэн нийтлэх (3.1, 3.2 заалт);
 - Энэ Хэлэлцээрийн зорилгод хүрэх үүднээс, харилцан тохиролцсон нөхцлөөр, хэрэглэгч улсад техникийн туслалцаа үзүүлэх (3.3 заалт);
- Хөндлөнгийн хяналтын систем/журам (4 дүгээр зүйл);
- АӨШ-тай холбогдсон хууль тогтоомж, дүрэм журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар ДХБ-ын Нарийн бичгийн даргын газарт мэдэгдэх (5 дугаар зүйл);
- Хэлэлцээрийн хэрэгжилтийг хянан үзэх (6 дугаар зүйл);
- Зөвлөлдөх (7 дугаар зүйл);
- Маргаан шийдвэрлэх (8 дугаар зүйл);

- Төгсгөлийн заалт (9 дүгээр зүйл).

ДГБ-ын баримт бичгээс:

Дэлхийн гаалийн байгууллагын Бодлогын комисс 1993 оны 12 дугаар сард хуралдсан хурадаанаараа АӨШ-ын асуудал газар авч байгаа байдлыг хэлэлцээд, санаа зовоож буй асуудлуудыг судалж, ямар ажил зохион байгуулах талаар санал боловсруулж, танилцуулахыг ДГБ-ын Нарийн бичгийн даргын газраас хүсчээ. ДГБ-ын Нарийн бичгийн даргын газар уг асуудлыг бүх талаас нь нарийвчлан судалж, дараах зарчмын дүгнэлт хийсэн байна. Үүнд:

АӨШ нь шинэ үзэгдэл биш. Бүр дээр үеэс худалдагч, худалданавагчнарбараанийлүүлэхдээ, түүнийг ачуулахаас нь өмнө шалгах тухай заалтыг гэрээний нэг хэсэг болгон тохиролцсоор иржээ. Ингэж, тухайн бараа гэрээнд заасан тоо, чанартай нийцэж буй эсэхийг баталгаажуулж байжээ. Гэвч зээл туслалцаа үзүүлдэг олон улсын байгууллагууд (Олон улсын валютын сан, Дэлхийн банк, г.м.) сүүлийн үед АӨШ хийдэг компаниудад түшиглэн гаалийн ажлыг сайжруулах гэж оролдож байгаа нь хэрэг дээрээ гаалийн ажлыг доголдолтой болгох буруу практикийг бий болгоод буй талаар нэлээд шүүмжлэл гарч байна. Мөн эдгээр байгууллага засгийн газрын зүгээс АӨШ-г хэрэгжүүлэх тохиолдолд тэдэнд зээл олгоно гэсэн маягаар хандах тохиолдол байна. Учир нь, эдгээр байгууллага дараах гомдлыг тавьсаар ирсэн:

- АӨШ-г нэвтүүлж байгаа орнуудад гаалийн байгууллага хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байсан (бусад орнуудад одоо тийм байгаа);
- Гаалийн байгууллага үүргээ ийнхүү биелүүлж чадахгүй байгаагийн шалтгаан нь гаалийн зөрчил, хээл хахууль газар авсан, гаалийн ажилтан нарыг зохих ёсоор сургах асуудал дутагдаж байгаа, гаалийн ажилчдыг шагнаж урамшуулах ажил зохих ёсоор хийгдэхгүй байгаа, гаалийн арга ажиллагаа хоцрогдсон, гаалийн хяналт шалгалтын ажил үр дүнтэй байдлаар хийгдэхгүй байгаа, материал техникийн хангамж муу байгаа (үүнд мэдээдлэл солилцох явдал орно)-д оршино.

Одоогоор (1995 оны байдлаар) АӨШ хийдэг 25 компани байгаа бөгөөд хамгийн анхных бөгөөд том гэгдэх, нэлээд нэрд гарсан нь SGS гэдэг Швейцарийн компани байна. Энэ компани нь дэлхий даяар 140 оронд өөрийн төлөөлөл болох 251 салбартай, 265 лабораторитой, 27 мянган ажилтантай. Өөр Веритас /Франц/, Инспекторат

/Швейцарь/, Сокотек /Франц/, Инчекейп /Их Британи/, Котекна /Франц/ гэх мэт томоохон компаниуд байна. Эдгээр хувийн компаниуд нь засгийн газартай гэрээ байгуулан ажилладаг. АӨШ хийдэг ихэнх компани нь Мэргэжлийн хяналтын албадын олон улсын Холбоо (The International Federation of Inspection Agencies)-ны гишүүн байна. АӨШ-ыг орчин үед гаалийн ажилд тус дэм үзүүлэх зорилгоор анх 1965 оноос нэвтрүүлж эхэлжээ. Өнөөдөр ачуулалтын өмнөх шалгалтыг Ази, Африк, Латин Америкийн 30 улс (Бангладеш, Бенин, Буркино, Фасо, Бурунди, Камерун, Төв Африкийн бүгд найрамдах улс, Зааны ясан эрэг, Гана, Гвиней, Гайти, Индонезия, Кения, Мадагаскар, Малави, Марли, Мексик, Мозамбик, Нигерия, Перу, Филиппин, Рванда, Сенегал, Сьер Леон, Танзани, Уганда, Замбия, Занзибар, Зимбабве)-ын засгийн газар дээрх зорилгоор хэрэгжүүлж байна. АӨШ-нд барааг ачуулахаас өмнө түүний тоо, чанарыг шалгахаас гадна барааны ангилал (импортлогч орны хууль тогтоомжийн дагуу), гаалийн үнэ зэргийг шалгах явдал хамаарч байна.

Мэргэжлийн хяналтын албадын олон улсын Холбооны үзэж байгаагаар, ДХБ-ын энэ Хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр АӨШ нь худалдаанд бэрхшээл учруулсан томоохон асуудал болж яригдахгүй болох юм. Энэ нь тийм байж болох боловч АӨШ нь гаалийн байгууллагын хувьд нилээд зөрчилтэй асуудал хэвээр үлдэнэ гэдэг үзэл баримтлал нилээд түгээмэл байна. АӨШ-г хэрэгжүүлснээр улсын төсвийн орлого өсөх, гаалийн зөрчил, хэзээ хахууль багасах, импортын бүрдүүлэлт түргэсэх, зардал хэмнэгдэх, чанаргүй бүтээгдэхүүнийг олж илрүүлэх зэрэг олон талын ашиг гарна үздэг. Энд маргаангүй зарим талын ашиг байх боловч тэдгээрийг үнэлж дүгнэхэд хэцүү, бас үл мэдрэгдэх юм.

АӨШ нь дараах сөрөг хүчин зүйлсийг агуулж байна:

1. Зээл туслалцаа үзүүлдэг олон улсын байгууллагууд АӨШ-ыг нилээд хэдэн жилийн өмнөөс сонирхож ирсэн боловч АӨШ хийдэг компаниудтай гэрээ байгуулан ажиллаж буй засгийн газарт тэр нь ямар үр ашигтай болох талаар 1995 оны 5 дугаар сар хүртэл ямар ч бодитой тооцоо судалгаа хийгээгүй байна. Дэлхийн банк 1993 оны 5 дугаар сард ганц удаа тооцоо судалгаа хийсний үр дүн одоо болтол (1995 оны байдлаар) тодорхойгүй байна;
2. АӨШ-ыг засгийн газрын нэрийн өмнөөс

хийлгэснээр улсын орлогыг бүрдүүлдэг байгууллагууд (гааль, татварын албад)-ын ажил үнэн хэрэг дээр сайжраагүй байна. Гаалийн зөрчил, хэзээ хахууль арилахгүй хэвээр байна. АӨШ хийдэг компаниуд барааг шалгасны дараа түүнийг лацдаж ломбодох эрхгүй бөгөөд энэ хооронд бараа солигдох, тоо өөрчлөгдөх, өөр зүйл хийх боломж хэвээр байна. АӨШ нь жинхэнэ өвчнийг нь биш харин зөвхөн шинж тэмдэг (симптом)-ийг нь эмчлэх хэрэгсэл болж байна;

3. АӨШ хийдэг компаниуд нь гаалийн зарим үүрэгт ажлыг шүүрэн авч хийж байгаагаас олон улсын худалдаанд ямар ч шаардлагагүйгээр, мөн ямар нэгэн үндэслэлгүйгээр илүү саад тотгор учруулж, улмаар экспортын зардлыг нэмэгдүүлэх, ингэснээр бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бууруулах нөхцлийг бүрдүүлж, эцсийн хэрэглэгчдэд илүү дарамт учруулж байна;
4. АӨШ-г хэрэгжүүлснээр улсын төсвийн орлого нэмэгдэнэ гэж ярьдаг боловч хэрэг дээрээ АӨШ-ыг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардал нөхөж барашгүй их хэмжээтэй байгаа болно. АӨШ хийдэг компаниуд барааны ФОБ үнийн 1-2%-тай тэнцэх хэмжээний үйлчилгээний хөлсийг (зөвхөн 1 жилд) хатуу валютаар шууд тооцон авдаг журамтай байна. АӨШ хэрэглэж буй олон оронд улсын төсвийн орлого нэмэгдсэн хэдий ч тийм үйлчилгээ үзүүлсэн зардлыг нөхөж чадахгүй байна;
5. АӨШ хийдэг компаниуд засгийн газартай байгуулах гэрээнд газрыг үнэ төлбөргүйгээр ашиглуулах тухай заасан байдаг байна. Мөн өндөр үнэтэй даатгал хийлгэж байгаа бөгөөд энэ даатгалын зардлыг эцсийн дүнд засгийн газар, эсхүл үйлчлүүлэгч байгуулага төлдөг;
6. Засгийн газар АӨШ хийдэг компаниудыг ажлын бусад нөхцөл бололцоогоор хангах, техник хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглуулах зэрэг нэмэгдэл үүрэг хүлээнэ;
7. АӨШ-ыг хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын засгийн газар зөвшөөрч байгаа нь тэд ДГБ болон хөгжингүй орнуудын гаалийн албадын туслалцаатайгаар сургалт явуулах, техник технологийн шинчлэл хийх боломжийг үгүйсгэж байна.

Эцэст нь дурдахад, АӨШ нь гаалийн асуудлыг ердөө л буруугаар шийдсэн арга учир үүнийг ДГБ-ын Нарийн бичгийн даргын газар дэмжих боломжгүй. Гаалийн асуудлыг үр дүнтэй шийдэх цорын ганц зам нь ДГБ-аас Гаалийн байгууллагыг өөрчилж, шинэчлэх, Гаалийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулан ажиллах явдал болно.

Дээрх үндэслэлээр, тэр цагаас эхлэн, өнөөг хүртэл ДГБ хөгжиж буй Гишүүн орнуудын гаалийн байгууллагуудад зориулан гаалийн өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөр (Customs Reform and Modernization Programme), чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр (Capacity Building Programme)-ийг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

ОХУ-ын мэргэжилтнүүдийн дүгнэлтээс:

АӨШ-ын тухай Хэлэлцээр нь бараа экспортлогч нар АӨШ хэрэглэгч улсууд (импортлогч улсууд)-тай хэлцэл хийх явцад гардаг хүндрэлтэй асуудлуудыг багасгахад чиглэсэн. Үүнээс гадна, АӨШ явуулдаг компаниуд экспортлогч нарын барааны тогтсон үнийг дураараа хянан өөрчилдөг зэрэг асуудлаар гомдол гаргах механизмыг бий болгосон. Гомдлыг эхлээд АӨШ хийдэг компанийн ахлах ажилтанд тавина. Тэр нь үр дүнгүй болбол энэ Хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан байгууллагад тавина.

Зарим улс орнууд импортын барааны тоо, чанарыг баталгаажуулах үүднээс хөндлөнгийн бие даасан ажиллагаатай компанийн үйлчилгээг хүсдэг. Энэ шалгалт гол төлөв экспортлогч улсад хийгддэг. Уг шалгалтын явцад барааны техникийн стандарт, чанарын шаардлага, түүнчлэн тоо хэмжээ гэрээнд заасантай тохирч буй эсэхийг шалгадаг. Тийм үйл ажиллагаа эрхэлдэг компанийн үйлчилгээг зөвхөн хувийн компаниуд төдийгүй төрийн байгууллагын хангамжийн асуудал хариуцсан компаниуд хүртэл авдаг. АӨШ-ын өөр нэг зорилго нь импортын барааны үнэ хэт өндөр, эсхүл хэт бага эсэхэд хяналт тавих, луйвар буюу өөр бусад буруу зөрүү үйлдлийг таслан зогсооход оршиж болох юм. Тэгэхээр АӨШ-ын зорилгыг дараах байдлаар тодорхойлж болно:

- барааны үнийг баталгаажуулах;
- экспортлогч бараагаа импортлогч орны барааны ангиллын дагуу ангилсныг баталгаажуулах;
- барааны тоохэмжээбиетхэмжигдэхүүнийхээ хувьд гэрээний заалттай тохирч байгааг баталгаажуулах.

Тэгэхээр барааг ачуулахаас өмнө заавал АӨШ хийлгэсэн байх ёстой гэсэн заалттай гэрээг тийм шалгалт хийлгэх зорилгынх нь үүднээс дараах

хоёр бүлэгт хуваан авч үзэж болно:

1. Барааны гаалийн үнийг хөөрөгдөх замаар гадагш хөрөнгө урсгахгүй байх гэсэн үндсэн зорилготой гэрээ
2. Барааны гаалийн үнийг бууруулах, эсхүл барааны ангиллыг гажуутгах замаар гаалийн болон бусад татвараас зайлсхийх гэсэн оролдлогыг таслан зогсоож, төсвийн алдаглыг багасгах үндсэн зорилготой гэрээ.

Түүнээс гадна, АӨШ ашигласнаар стандартын янз бүрийн системийн хооронд зөрчил үүсэхээс сэргийлэх ач холбогдолтой юм байна.

Бусад эх сурвалжаас:

Transparency International-ээс гаргадаг судалгаагаар АӨШ нэвтрүүлж буй буурай хөгжилтэй орнууд сүүлийн жилүүдэд авилгын рейтингээрээ эхний байруудыг эзэлж байгаа.

Энэ үйл ажиллагааны салбарт голлон тоглогчид нь жил бүрийн 800 сая долларын эргэлтийн хөрөнгөтэй бөгөөд буурай орнуудад АӨШ хэрэгжүүлэх гэрээнээс жилд 150-200 сая долларын орлого олдог байна. Үүнд 5 гол өрсөлдөгч компани байдаг бөгөөд эзэд нь Женев, Лондон, Париж, Миланд амьдардаг, түүнчлэн Швейцарт шилтгээнтэй, Тосканд XII зууны зуслангийн харштай зарим баячууд байдаг.

40 жил өнгөрсний дараа тогтвортой хөгжлийн мэргэжилтнүүд энэ үйл ажиллагаа нь жинхэндээ хүнд суртлын эсрэг өөрчлөлт хийх болон худалдааг хөгжүүлэхэд саад тотгор болохын хамт авилгын төрөл бүрийн илрэлийг хаах биш, харин дэмждэг гэдгийг гүйцэд ойлгосон байна. Буурай хөгжилтэй улс орнуудад авилга даамжирч байгаа шалтгаанаар өөрсдийн гаалийн байгууллага, экспортын агентлагуудад итгэхээ больж, өндөр төлбөртэй гадаадын компаниудыг хөлслөхийг эрмэлздэг болсон нь мөн чанартаа татвар, хураамж хураан авах явдлыг үндсэндээ хувийн гарт өгч байгаа гэсэн үг юм.

Дэлхийн худалдаанд хяналт тавьж, авилгал мөрдөх хүсэл сонирхол бүхий олон улсын байгууллагууд 1960 оноос хөгжиж буй орнуудад үйл ажиллагаагаа эхэлсэн SGS компанийг гар дахь хэрэгслээ болгосноор түүний дэлхийн тавцанд гарах эхлэл тавигдсан байна. Жишээлбэл, 1980-д оны эхээр Дэлхийн банк, Олон улсын валютын сан тэднээс санхүүгийн тусламж авч байгаа хөгжиж буй орнууд SGS зэрэг АӨШ хийдэг компаниудтай заавал гэрээ байгуулахыг шаардаж эхэлсэн. 1996 онд Дэлхийн банкны Ерөнхийлөгч Джеймс Вулфенсон Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй цогц хөтөлбөр, түүн дотор хөгжиж буй орнуудын

коррупцийн түвшинд мониторинг хийх зорилготой түүвэр аудитын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол аудиторроор SGS компани шалгарсныг зарласан.

SGS зэрэг үндсэн үйл ажиллагаа нь коррупцтэй тэмцэхэд чиглэсэн, нэр хүндтэй, томоохон гэх компаниуд хуулийг ноцтой зөрчдөг явдал цөөнгүй байна. 1997 оны 9 дүгээр сард, Дэлхийн банктэй Хэлэлцээр байгуулснаас хойш 1 жилийн дараа SGS компани Пакистаны экс Ерөнхий сайд Беназир Бхутто, түүний нөхөр, хүргэн, мөн нэлээд хэдэн зуучлагч нарт хахууль өгсөн баримтууд илэрсэн. Ойролцоогоор 15 сая долларын хөрөнгийг Швейцарь банк, UBS-ийн женев дэх салбар, Barclays Bank, Banque Parcsche зэргээр дамжуулан Пакистаны Засгийн газартай ачилтын өмнөх шалгалт хийх ашигтай гэрээ байгуулах хөлсөнд төлсөн нь илэрсэн байна.

SGS-ийг 1997 оны 10 дугаар сард Бхутто, түүний нөхөрт хахууль өгсөн хэргээр буруутгасны дараа SGS Cotecna компани зарж, 1989 оноос энэ албыг хашиж ирсэн захирлуудын зөвлөлийн дарга нь огцорсон байна.

SGS-ын шинэ удирдлага компанийхаа нүүр царайг аврах зоригор хэд хэдэн арга хэмжээ авсны дотор Ёс зүйн хороог байгуулж, Ёс зүйн хуулийг баталсан нь 25 улсын хэл дээр орчуулагдсан байна. Авагдсан мэдээллээр энэ нь Дэлхийн банк зэрэг байгууллагуудын өмнө нэр төрөө сэргээх алхам болсон байна.

Пакистанд үүссэн асуудлын дараа Филиппин, Ангол, Зааны ясан эвэр, Эфиопи, Индонези, Парагвайтай байгуулсан хэд хэдэн гол гэрээнүүд цуцлагдсан нь Пакистаны үйл явдлаас гадна зарим тохиолдолд гэрээний үүрэг зөрчигдсэн болон хууран мэхлэх үйл ажиллагаатай холбоотой юм байна.

Дээр дурдсан азгүй явдлуудаас үл хамааран 2003 он гэхэд SGS дахин хөл дээрээ босч компанийн жилийн орлого нь 1.7 тэрбум ам. доллар хүрсний 12 орчим хувь АӨШ-ын гэрээний дүнд олсон орлого байна.

АӨШ-ын шууд болон шууд бус зарлага (хахуулийг оролцуулан) нийт импортын 1-1,5 %-ийг эзэлдэг. АӨШ хийдэг компаний цуглуулдаг мэдээлэл нь үр ашиггүй өнгөрдөг бөгөөд ихэнхдээ АӨШ хийх гэрээ байгуулсан орнуудын эрх мэдэлтнүүд түүнийг бүхэлд нь хэрэгсдэггүй байна.

ОХУ-д:

“Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах үндэс” нэртэй 2003 оны эцсээр батлагдсан хуульд эрсдэлтэй барааны чанар, тоо хэмжээ, үнэ, ангиллыг экспортлогч орны нутаг

дэвсгэр дээр шалгах үүрэг тусгагдсан. 2005 оны үед ОХУ-ын Эдийн засаг, худалдааны яам ӨШ нэвтрүүлэхийг нэлээд хүчилж байсан бөгөөд үүнийг хэрэгжүүлэгчээр SGS тодрох магадлал өндөр байсан байна. ЭЗХЯ-ны урьдчилан тооцоолсноор, нэмэлт шалгалтын хөлсөнд нийт барааны үнийн 1%-ийг гадаадын импортлогчид төлөхөд бизнесийн алдагдал жилд 800 орчим сая ам. доллар болно гэж үзэж байсан. Энэ мэт сөрөг талуудыг Ерөнхий сайд Фрадков зэрэг хүмүүс ойлгож, АӨШ нэвтрүүлэх шийдвэрийг сонирхол бүхий хэдэн байгууллага, бизнес эрхлэгчид хүсч байгааг цохон тэмдэглээд, ийм шалгалт нэвтрүүлэхийг зогсоосон байна.

Оюуны өмчийг хамгаалах хамтын нийгэмлэгийн хорооны дарга А.Поповичев хэлэхдээ, жинхэндээ үндэсний гаалийн байгууллагын зарим үйл ажиллагааг АӨШ хийдэг компаниар хийлгэх бус, харин гаалийн албанд хөрөнгө оруулалт хийж, автоматжуулан, ажиллагсдыг нь мэргэшүүлэх замаар гаалийн үйл ажиллагааг боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн санааг дэмжиж байгаагаа илэрхийлж байсан байна.

Молдав Улсад:

Молдав Улсын Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах тухай хуулийн дагуу 1999 онд Засгийн газар тусгай тогтоолоор АӨШ-ыг нэвтрүүлэх шийдвэр гаргаж, улмаар АӨШ хийх тендерт Швейцарийн SGS компани ялсан боловч Үндсэн хуулийн цэцийн шүүх Засгийн газрын үүргийг гадаадын арилжааны компанид шилжүүлсэн нь үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгосон байна.

Засгийн газрын хуралдаанаар АӨШ-ыг нэвтрүүлснээс үүдэн гарах хор уршигийн талаар хэлэлцэж, АӨШ хийдэг компанид үйлчилгээ үзүүлсний төлбөрийн хэмжээгээр гаалийн байгууллагыг мэдээллийн технологиор хангах боломжтой гэж үзсэн байна. АӨШ хийсний хөлсөнд барааны үнийн дүнгийн 0,96 хувьтай тэнцэх, гэхдээ нэг ачилтад 275 ам. доллараас багагүй хэмжээний төлбөр төлөх тооцоо хийгдсэн бөгөөд SGS-ийн төлөөлөгчийн газар нь албан татвараас чөлөөлөгдөх нь Татварын хуульд харшлахын зэрэгцээ импортлогчийг өөрийн улсад төлбөртэй үйлчилгээ авахад түлхэж, харин SGS татвар төлөлгүй мөнгөө Швейцарт, эсхүл бусад газарт гаргах боломж нээгдэнэ гэж үзсэн байна.



14. Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Rules of Origin
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по правилам происхождения (Соглашение о правилах определения страны происхождения товаров)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан «Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол» (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол - Ерөнхий сайдын захирамж -1997, №6 - 2008 оны Гаалийн тухай болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиуд - Барааны гарал үүслийн дүрэм батлах тухай (ЗГТ2009-4-1, №88)

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Уг Хэлэлцээрийн I хэсэгт “гарал үүслийн дүрэм”-ийн тодорхойлолтыг өгч, хамрах хүрээ (Definitions and Coverage)-г заасан. Уг Хэлэлцээрийн зорилгоор, “гарал үүслийн дүрэм” гэдэг нь ДХБ-ын аливаа Гишүүн оронд барааны гарал үүслийн улсыг тодорхойлох зорилгоор мөрддөг хууль тогтоомж, дүрэм журам, мөн нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэр болно. Гэхдээ, гарал үүслийн энэ дүрэм нь тусгай гэрээ, Хэлэлцээрээр тогтоосон бөгөөд 1994 оны ТХЕХ-ийн I зүйлийн 1 дэх заалт (үндэсний нэн тааламжтай нөхцөл - the most favoured nation treatment)-д зааснаас давсан (илүү хөнгөлөлттэй) худалдааны дэглэм (trade regimes)-д хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, тарифын преференц (tariff preferences)-д хамаарахгүй (1.1 дэх заалт). Гарал үүслийн энэ дүрэмд зөвхөн преференцээс бусад худалдааны бодлогын асуудал зохицуулсан баримт бичгүүд (non-preferential commercial policy instruments)-д заасан гарал үүслийн дүрмүүд хамаарна. Тухайлбал, дараах тохиолдолд мөрддөг гарал үүслийн дүрмүүд хамаарна (1.2 дахь заалт):

- 1994 оны ТХЕХ-ийн I, II, III, XI, XIII зүйлийн дагуу үндэсний нэн тааламжтай нөхцөл (the most favoured nation treatment) олгох;
- 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийн дагуу демпингийн эсрэг болон нөхөн төлөөсийн/саармагжуулах татвар (anti-dumping and countervailing duties) ногдуулах;
- 1994 оны ТХЕХ-ийн XIX зүйлийн дагуу хамгаалалтын арга хэмжээ (safeguard measures) авах;
- 1994 оны ТХЕХ-ийн IX зүйлийн дагуу гарал үүслийн тэмдэг тавих (гарал үүслийг тэмдэглэх) шаардлага (origin marking requirements)-ыг мөрдөх;
- тоо хэмжээгээр ялгаварлан тогтоосон хязгаарлалт буюу тарифын квот (discriminatory quantitative restrictions or tariff quotas) хэрэгжүүлэх;
- төр, засгийн байгууллагын хангамж (government procurement)-ийн хүрээнд бараа нийлүүлэх;
- худалдааны статистик (trade statistics) гаргах.

Уг Хэлэлцээрийн II хэсэгт гарал үүслийн дүрмийг IV хэсэгт зааснаар бүрэн төгс уялдуулах хүртэлх шилжилтийн хугацаанд, мөн шилжилтийн хугацаа дууссаны дараа мөрдөх зүйлийн талаар заасан. Шилжилтийн хугацаанд ДХБ-ын Гишүүн

орнууд дараах нөхцлийг бүрдүүлэх ёстой (2 дугаар зүйл):

- (a) нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэр гаргахдаа, биелүүлэх ёстой шаардлагуудыг тодорхой заах. Ялангуяа дараах зүйлсийг тодорхой заах:
 - (i) тарифын ангилал өөрчлөгдөх шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн дүрэмд хамаарах, эсхүл үл хамаарах БТКУС-ийн зүйл, мөрийг тодорхой зааж өгөх;
 - (ii) үнийн дүнгээс хувиар тооцох шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн дүрэмд уг хувийг тооцох аргачлалыг зааж өгөх;
 - (iii) үйлдвэрлэл буюу боловсруулалтын түвшингийн шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн дүрэмд үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын шат дамжлагыг нарийвчлан зааж өгөх;
- (b) гарал үүслийн дүрмийг худалдааны зорилгод хүрэх шууд буюу шууд бус арга хэрэгсэл болгон ашиглахгүй байх;
- (c) гарал үүслийн дүрэм нь өөрөө олон улсын худалдааг хязгаарлах, гажуудуулах, эсхүл тасалдуулах үр нөлөөгүй байх. Гарал үүслийн улсыг тодорхойлох угтвар нөхцөл болгон үндэслэл муутай хатуу шаардлага тавихгүй байх, эсхүл үйлвэрлэл, боловсруулалтад хамааралгүй болзол нөхцөл тулган биелүүлэхийг шаардахгүй байх. Гэхдээ, үйлдвэрлэл, боловсруулалтанд шууд хамааралгүй зардлыг энэ зүйлийн (a)-д зааснаар үнийн дүнгээс хувиар тооцох шалгуур мөрдөх зорилгоор тусгаж болно;
- (d) импорт, экспортын бараанд мөрдөх гарал үүслийн дүрэм нь аливаа бараа дотоодын бараа мөн эсэхийг тодорхойлоход мөрддөг гарал үүслийн дүрмээс илүү хатуу биш бөгөөд холбогдох барааны үйлдвэрлэгч аль улсын харъяат болохыг үл харгалзан, Гишүүн орнуудыг алагчлаагүй байх;
- (e) гарал үүслийн дүрмийг зөрчилдөөнгүй, нэгдмэл, шударга (хэн нэгний талыг барихгүйгээр) болон ухаалаг байдлаар (in a consistent, uniform, impartial and reasonable manner) хэрэгжүүлэх;
- (f) гарал үүслийн дүрэм гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох стандарт (a positive standard - эерэг стандарт)-т үндэслэгдсэн байх. Эерэг стандартыг тодотгох

зорилгоор, эсхүл гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох шаардлагагүй онцгой тохиолдолд, тодорхой нэг улсын гарал үүсэлтэй гэж үзэхгүй байх тохиолдлууд (negative standard - сөрөг стандарт буюу гарал үүслийг сөрөг талаас нь тодорхойлох явдал) байж болно;

- (g) гарал үүслийн дүрэмтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, шүүхийн шийдвэр болон нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрийг 1994 оны ТХЕХ-ийн Х зүйлийн 1 дэх хэсэг (Худалдааны зохицуулалтын арга хэмжээг шуурхай хэвлэн нийтлэх)-т хамааруулан, түүний дагуу хэвлэн нийтлэх;
- (h) тодорхой барааны гарал үүслийн дүгнэлт (assessments of the origin)-ийг холбогдох бүх мэдээлэл, бичиг баримтыг гаргаж өгсөн тохиолдолд экспортлогч, импортлогч, эсхүл эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр аль болох богино хугацаанд, гэхдээ тийнхүү хүсэлт гаргаснаас хойш 150 хоног өнгөрөхөөс өмнө гаргаж өгөх. Ийнхүү дүгнэлт гаргах тухай хүсэлтийг тухайн барааны худалдаа эхлэхээс өмнө хүлээн авах, мөн түүнээс хойш хэзээ ч хүлээн авч болохоор байх. Бодит нөхцөл байдал, мөн гарал үүслийн дүрэм өөрчлөгдөөгүй тохиолдолд уг дүгнэлтийг 3 жилийн хугацаанд хүчинтэйд тооцох. Энэ зүйлийн (j)-д заасны дагуу уг дүгнэлтээс өөр шийдвэр гарсан тохиолдолд уг дүгнэлт энэ тухай холбогдох талуудад мэдэгдсэнээр хүчингүй болох. Уг дүгнэлтийг энэ зүйлийн (k)-д заасныг баримтлан олон нийтийн хүртээл болгох;
- (i) гарал үүслийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл шинэ дүрэм нэвтрүүлэхдээ дотоодын хууль тогтоомж, дүрэм журамд заасныг баримтлан, холбогдох заалтыг хөндөхгүйгээр, нэмэлт өөрчлөлт оруулсан, эсхүл шинэчлэн найруулсан гарал үүслийн дүрмийг буцаан хэрэглэхгүй байх;
- (j) гарал үүслийг тодорхойлохтой холбогдсон захиргааны байгууллагын аливаа шийдвэрийг уг шийдвэр гаргасан байгууллагаас өөр, бие даасан ажиллагаатай иргэний, эрүүгийн, арбитрын, эсхүл захиргааны шүүхийн байгууллага, эсхүл түүний журмын дагуу нэн даруй хянан үзэх, улмаар уг шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох боломжтой байх;
- (k) нууцын зэрэглэлд хамаарах, эсхүл гарал

үүслийн дүрмийг мөрдөх зорилгоор нууц журмаар гаргаж өгсөн бүх мэдээллийг эрх бүхий холбогдох байгууллагууд нууцлан хамгаалах. Эдгээр мэдээллийг шүүх хуралдааны явцад тодорхой хэмжээгээр задруулах шаардлага гарахаас бусад тохиолдолд түүнийг гаргаж өгсөн этгээд буюу засгийн газрын тусгай зөвшөөрөлгүйгээр үл задлах.

Хэлэлцээрийн 3 дугаар зүйл (Шилжилтийн хугацаа дууссаны дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээ)-д дараах зүйлс заагдсан байна:

- (a) гарал үүслийн дүрмийг 1 дүгээр зүйлд заасан бүх тохиолдолд (for all purposes) адил тэгш зарчмаар (equally) мөрдөх;
- (b) тодорхой нэг барааны гарал үүслийн улс нь тухайн барааг бүхэлд нь үйлдвэрлэсэн улс (the country where the goods has been wholly obtained), эсхүл тухайн барааг нэгээс дээш улсад үйлдвэрлэсэн бол хамгийн сүүлчийн үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улс (the country where the last substantial transformation has been carried out) байна гэж тодорхойлох;
- (c) импорт, экспортын бараанд мөрдөх гарал үүслийн дүрэм нь аливаа бараа дотоодын бараа мөн эсэхийг тодорхойлоход мөрддөг гарал үүслийн дүрмээс илүү хатуу биш бөгөөд холбогдох барааны үйлдвэрлэгч аль улсын харъяат болохыг үл харгалзан, Гишүүн орнуудыг алагчлаагүй байх;
- (d) гарал үүслийн дүрмийг зөрчилдөөнгүй, нэгдмэл, шударга (хэн нэгний талыг барихгүйгээр) болон ухаалаг байдлаар (in a consistent, uniform, impartial and reasonable manner) хэрэгжүүлэх;
- (e) гарал үүслийн дүрэмтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, шүүхийн шийдвэр болон нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрийг 1994 оны ТХЕХ-ийн Х зүйлийн 1 дэх хэсэг (Худалдааны зохицуулалтын арга хэмжээг шуурхай хэвлэн нийтлэх)-т хамааруулан, түүний дагуу хэвлэн нийтлэх;
- (f) тодорхой барааны гарал үүслийн дүгнэлт (assessments of the origin)-ийг холбогдох бүх мэдээлэл, бичиг баримтыг гаргаж өгсөн тохиолдолд экспортлогч, импортлогч, эсхүл эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр аль болох богино хугацаанд, гэхдээ тийнхүү хүсэлт гаргаснаас хойш 150 хоног өнгөрөхөөс өмнө гаргаж өгөх. Ийнхүү дүгнэлт гаргах тухай хүсэлтийг тухайн барааны худалдаа эхлэхээс өмнө хүлээн

авах, мөн түүнээс хойш хэзээ ч хүлээн авч болохоор байх. Бодит нөхцөл байдал, мөн гарал үүслийн дүрэм өөрчлөгдөөгүй тохиолдолд уг дүгнэлтийг 3 жилийн хугацаанд хүчинтэйд тооцох. Энэ зүйлийн (h)-д заасны дагуу уг дүгнэлтээс өөр шийдвэр гарсан тохиолдолд уг дүгнэлт энэ тухай холбогдох талуудад мэдэгдсэнээр хүчингүй болох. Уг дүгнэлтийг энэ зүйлийн (i)-д заасныг баримтлан олон нийтийн хүртээл болгох;

- (g) гарал үүслийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл шинэ дүрэм нэвтрүүлэхдээ дотоодын хууль тогтоомж, дүрэм журамд заасныг баримтлан, холбогдох заалтыг хөндөхгүйгээр, нэмэлт өөрчлөлт оруулсан, эсхүл шинэчлэн найруулсан гарал үүслийн дүрмийг буцаан хэрэглэхгүй байх;
- (h) гарал үүслийг тодорхойлохтой холбогдсон захиргааны байгууллагын аливаа шийдвэрийг уг шийдвэр гаргасан байгууллагаас өөр, бие даасан ажиллагаатай иргэний, эрүүгийн, арбитрын, эсхүл захиргааны шүүхийн байгууллага, эсхүл түүний журмын дагуу нэн даруй хянан үзэх, улмаар уг шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох боломжтой байх;
- (i) нууцын зэрэглэлд хамаарах, эсхүл гарал үүслийн дүрмийг мөрдөх зорилгоор нууц журмаар гаргаж өгсөн бүх мэдээллийг эрх бүхий холбогдох байгууллагууд нууцлан хамгаалах. Эдгээр мэдээллийг шүүх хуралдааны явцад тодорхой хэмжээгээр задруулах шаардлага гарахаас бусад тохиолдолд түүнийг гаргаж өгсөн этгээд буюу засгийн газрын тусгай зөвшөөрөлгүйгээр үл задлах.

Мөн Хэлэлцээрийн IV хэсэг (Гарал үүслийн дүрмийг уялдуулах)-ийн 9 дүгээр зүйл (Зорилт, зарчим)-д дараах зүйлийг заасан:

- (a) гарал үүслийн дүрмийг 1 дүгээр зүйлд заасан бүх тохиолдолд (for all purposes) адил тэгш зарчмаар (equally) мөрдөх;
- (b) тодорхой нэг барааны гарал үүслийн улс нь тухайн барааг бүхэлд нь үйлдвэрлэсэн улс (the country where the goods has been wholly obtained), эсхүл тухайн барааг нэгээс дээш улсад үйлдвэрлэсэн бол хамгийн сүүлчийн үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улс (the country where the last substantial transformation has been carried out) байна гэж тодорхойлох;

(c) гарал үүслийн дүрэм нь бодитой, ойлгомжтой, ил тод байх;

(d) гарал үүслийн дүрмийг худалдааны зорилгод хүрэх шууд буюу шууд бус арга хэрэгсэл болгон ашиглахгүй байх. Гарал үүслийн дүрэм нь өөрөө олон улсын худалдааг хязгаарлах, гажуудуулах, эсхүл тасалдуулах үр нөлөөгүй байх. Гарал үүслийн улсыг тодорхойлох угтвар нөхцөл болгон үндэслэл муутай хатуу шаардлага тавихгүй байх, эсхүл үйлвэрлэл, боловсруулалтад хамааралгүй болзол нөхцөл тулган биелүүлэхийг шаардахгүй байх. Гэхдээ, үйлдвэрлэл, боловсруулалтанд шууд хамааралгүй зардлыг үнийн дүнгээс хувиар тооцох шалгуур мөрдөх зорилгоор тусгаж болно;

(e) гарал үүслийн дүрмийг зөрчилдөөнгүй, нэгдмэл, шударга (хэн нэгний талыг барихгүйгээр) болон ухаалаг байдлаар (in a consistent, uniform, impartial and reasonable manner) хэрэгжүүлэх;

(f) гарал үүслийн дүрэм нь учир утгатай (coherent) байх;

(g) гарал үүслийн дүрэм гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох стандарт (a positive standard - эерэг стандарт)-т үндэслэгдсэн байх. Эерэг стандартыг тодотгох зорилгоор, эсхүл гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох шаардлагагүй онцгой тохиолдолд, тодорхой нэг улсын гарал үүсэлтэй гэж үзэхгүй байх тохиолдлууд (negative standard - сөрөг стандарт буюу гарал үүслийг сөрөг талаас нь тодорхойлох явдал) байж болно.

Хэлэлцээрээр ДХБ-ын дэргэд Гарал үүслийн дүрмийн Хороо, ДГБ-ын дэргэд Гарал үүслийн дүрмийн Техникийн хороо тус тус байгуулагдсан (4 дүгээр зүйл). ДГБ-ын Гарал үүслийн дүрмийн Техникийн хороо Хэлэлцээрийн IV хэсэг болон Хавсралт I-д заасан техникийн шинжтэй ажил үүргийг хийж гүйцэтгэнэ.

Гишүүн орнууд ДХБ байгуулах тухай Хэлэлцээр тэдгээрийн хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор тухайн өдөр хүчин төгөлдөр мөрдөж буй гарал үүслийн дүрэм, мөн гарал үүсэлтэй холбоотой шүүхийн шийдвэр, нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрийг ДХБ-ын Нарийн бичгийн даргын газарт хүргүүлэх ёстой. Үүнийг хайхралгүй өнгөрсөн Гишүүн орнууд энэ тухай мэдмэгцээ нэн даруй хүргүүлнэ (5.1 заалт). Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан шилжилтийн хугацаанд гарал үүслийн дүрэмдээ

томоохон өөрчлөлт оруулсан, эсхүл шинэчилсэн бол ямар зорилгоор тэгснийг сонирхогч бусад талуудад ойлгуулах үүднээс энэ талаар уг өөрчлөлт, эсхүл шинэдүрэм хүчин төгөлдөр болохоос 60 хоногийн өмнө мэдэгдэнэ. Онцгой байдал буюу аюул тохиолдсон үед энэ хугацаа хамаарахгүй бөгөөд аль болох богино хугацаанд мэдэгдэнэ (5.2 заалт).

Энэ Хэлэлцээрийн дээр дурдсан заалтууд бүгд зөвхөн преференц олгохоос бусад худалдааны бодлогын асуудалд хамаарах гарал үүслийн дүрэм (non-preferential rules of origin)-ийн талаар өгүүлсэн бол Хэлэлцээрийн Хавсралт II-т 1994 оны ТХЕХ-ийн I зүйлийн 1 дэх заалт (үндэсний нэн тааламжтай нөхцөл - the most favoured nation treatment)-д зааснаас давсан (илүү хөнгөлөлттэй) худалдааны дэглэм (trade regimes)-д хамаарах, өөрөөр хэлбэл, тарифын преференц (tariff preferences)-д хамаарах Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм (preferential rules of origin)-ийн тухай Хамтарсан Тунгахлалыг оруулж өгсөн. Уг Тунхаглалаар зарим Гишүүн орон Гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм (preferential rules of origin) мөрддөг болохыг хүлээн зөвшөөрч (Тунхаглалын заалт 1) ДХБ-ын Гишүүн орнууд дараах зүйлийг тохирсон (Тунхаглалын заалт 3):

- (a) нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэр гаргахдаа, биелүүлэх ёстой шаардлагуудыг тодорхой заах. Ялангуяа дараах зүйлсийг тодорхой заах:
 - (i) тарифын ангилал өөрчлөгдөх шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэмд хамаарах, эсхүл үл хамаарах БТКУС-ийн зүйл, мөрийг тодорхой зааж өгөх;
 - (ii) үнийн дүнгээс хувиар тооцох шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэмд уг хувийг тооцох аргачлалыг зааж өгөх;
 - (iii) үйлдвэрлэл буюу боловсруулалтын түвшингийн шалгуур тогтоохдоо, холбогдох гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэмд үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын шат дамжлагыг нарийвчлан зааж өгөх;
- (b) гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох стандарт (a positive standard - эерэг стандарт)-т үндэслэгдсэн байх. Эерэг стандартыг тодотгох зорилгоор, эсхүл гарал үүслийг эерэг талаас нь тодорхойлох шаардлагагүй онцгой тохиолдолд, тодорхой нэг улсын гарал үүсэлтэй гэж

үзэхгүй байх тохиолдлууд (negative standard - сөрөг стандарт буюу гарал үүслийг сөрөг талаас нь тодорхойлох явдал) байж болно;

- (c) гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэмтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм журам, шүүхийн шийдвэр болон нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрийг 1994 оны ТХЕХ-ийн X зүйлийн 1 дэх хэсэг (Худалдааны зохицуулалтын арга хэмжээг шуурхай хэвлэн нийтлэх)-т хамааруулан, түүний дагуу хэвлэн нийтлэх;
- (d) тодорхой барааны гарал үүслийг хөнгөлөлттэй дүрмээр тодорхойлсон дүгнэлт (assessments of the preferential origin)-ийг холбогдох бүх мэдээлэл, бичиг баримтыг гаргаж өгсөн тохиолдолд экспортлогч, импортлогч, эсхүл эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр аль болох богино хугацаанд, гэхдээ тийнхүү хүсэлт гаргаснаас хойш 150 хоног өнгөрөхөөс өмнө гаргаж өгөх. Ийнхүү дүгнэлт гаргах тухай хүсэлтийг тухайн барааны худалдаа эхлэхээс өмнө хүлээн авах, мөн түүнээс хойш хэзээ ч хүлээн авч болохоор байх. Бодит нөхцөл байдал, мөн гарал үүслийн дүрэм өөрчлөгдөөгүй тохиолдолд уг дүгнэлтийг 3 жилийн хугацаанд хүчинтэйд тооцох. Энэ заалтын (f)-д заасны дагуу уг дүгнэлтээс өөр шийдвэр гарсан тохиолдолд уг дүгнэлт энэ тухай холбогдох талуудад мэдэгдсэнээр хүчингүй болох. Уг дүгнэлтийг энэ заалтын (g)-д заасныг баримтлан олон нийтийн хүртээл болгох;
- (e) гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл хөнгөлөлттэй шинэ дүрэм нэвтрүүлэхдээ дотоодын хууль тогтоомж, дүрэм журамд заасныг баримтлан, холбогдох заалтыг хөндөхгүйгээр, нэмэлт өөрчлөлт оруулсан, эсхүл шинэчлэн найруулсан гарал үүслийн дүрмийг буцаан хэрэглэхгүй байх;
- (f) гарал үүслийг хөнгөлөлттэй дүрмээр тодорхойлохтой холбогдсон захиргааны байгууллагын аливаа шийдвэрийг уг шийдвэр гаргасан байгууллагаас өөр, бие даасан ажиллагаатай иргэний, эрүүгийн, арбитрын, эсхүл захиргааны шүүхийн байгууллага, эсхүл түүний журмын дагуу нэн даруй хянан үзэх, улмаар уг шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох боломжтой байх;

(g) нууцын зэрэглэлд хамаарах, эсхүл гарал үүслийн хөнгөлөлттэй дүрмийг мөрдөх зорилгоор нууц журмаар гаргаж өгсөн бүх мэдээллийг эрх бүхий холбогдох байгууллагууд нууцлан хамгаалах. Эдгээр мэдээллийг шүүх хуралдааны явцад тодорхой хэмжээгээр задруулах шаардлага гарахаас бусад тохиолдолд түүнийг гаргаж өгсөн этгээд буюу засгийн газрын тусгай зөвшөөрөлгүйгээр үл задлах.

ДХБ байгуулах тухай Хэлэлцээр тухайн Гишүүн орны хувьд хүчин төгөлдөр болсон өдөр хүчин төгөлдөр мөрдөж буй гарал үүслийн хөнгөлөлттэй дүрэм, түүнтэй холбоотой шүүхийн шийдвэр, нийтээр дагаж мөрдөх захиргааний шийдвэрийг, преференц үзүүлэх арга хэмжээний жагсаалтын хамт ДХБ-ын Нарийн бичгийн даргын газарт нэн даруй хүргүүлнэ. Түүнээс хойш түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт, эсхүл хөнгөлөлттэй шинэ дүрмийг аль болох богино хугацаанд хүргүүлнэ (Тунхаглалын заалт 4).

Гарал үүслийн дүрэм. Монгол Улсын гааль олон улсын Конвенцид заасны дагуу гарал үүслийн улсыг тодорхойлох 2 шалгуур ("Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс" - барааг нэг улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх, "Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх" - барааг хоёр буюу түүнээс дээш улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх)-ыг мөрдөхөөр 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль (ГТГТХ)-д тусгасан.

ГТГТХ-нд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар "4.5.Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох баримт бичигтэй байна." гэж заасан байгаа. Мөн хуулиар барааны нотлох бичиг баримт нь дараах хэлбэртэй байна гэж заасан байгаа (31.7):

- барааны гарал үүслийн мэдүүлэг (declaration of origin) буюу үйлдвэрлэгч, худалдагч, экспортлогчоос барааны гарал үүслийн талаар тусгасан мэдээлэл бүхий үнийн нэхэмжлэх, тээврийн баримт бичиг;
- барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлэг (certified declaration of origin) буюу тухайн улсын эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлэг;
- барааны гарал үүслийн гэрчилгээ (certificate of origin) буюу барааны гарал үүслийг гэрчилж, тухайн улсын эрх бүхий байгууллагаас тусгай маягтаар баталгаажуулан олгосон гэрчилгээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар "31.8.Гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батална." гэж заасан байна.



15. Татаас болон нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Subsidies and Countervailing Measures
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по субсидиям и компенсационным мерам
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1994-04-15. Марокко Улсын Марракеш хот (Marrakesh, Morocco)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1995-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 164
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05 (Хэлэлцээрт нэгдэн орсон) 1996-12-26 (Протокол соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-12-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-01-29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрч тэдгээрт нэгдэн орох тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль: Тариф, худалдааны тухай 1994 оны Ерөнхий хэлэлцээр болон 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээрийг тус тус хүлээн зөвшөөрч, тэдгээрт нэгдэн орсугай; - Протокол соёрхон батлах тухай Монгол Улсын 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль: Монгол Улс, дэлхийн худалдааны байгууллагын хооронд 1996 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан “Дэлхийн худалдааны байгууллага байгуулах Марракешийн Хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орох тухай Протокол” (The Protocol for the Accession of Mongolia to the Marrakesh Agreement Establishing the WTO Done at Geneva on 18 July 1996)-ыг соёрхон баталсугай; - ДХБ-д гишүүнээр элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 71 дүгээр тогтоол; - Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орж буйтай холбогдуулан авах арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоол - Ерөнхий сайдын захирамж -1997, №6

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

1. Худалдааны гажуудлыг арилгах арга хэрэгсэл (Trade Remedies):
 - Чөлөөт худалдаа үргэлж шударга явагдаггүй.
 - Олон улсын худалдаан дахь гажуудал (distortions in international trade):
 - Демпингийн шинжтэй (экспортлогч орны дотоодын зах зээлийн үнээс бага үнэтэй) экспортын бараа (dumped exports) импортоор орж ирэх;
 - Экспортоор гаргахад нь татаас (дэмжлэг) үзүүлсэн экспортын бараа (subsidized exports) импортоор орж ирэх.
 - Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах дараах 3 арга хэрэгсэл байна (ДХБ байгуулах тухай хэлэлцээрийн “Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл”-ийн “3. Дэлхийн худалдааны байгууллага” гэсэн хэсгийн “Худалдааны бодлогын тоглоомын дүрэм”-ийг үзнэ үү):

- Импортын барааны хувьд демпингийн шинжтэй болох нь тогтоогдсон бол (Dumping): Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ;
- Импортын барааны хувьд түүнийг экспортлоход татаас (дэмжлэг) олгосон нь тогтоогдсон бол (Subsidization): Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ;
- Тодорхой нэг барааны импорт огцом өссөн бол (Import surge): Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ.

Хэлэлцээрийн бүтэц:

I ХЭСЭГ: ЕРӨНХИЙ ЗААЛТ (GENERAL PROVISIONS)

1 дүгээр зүйл. Татаасын тодорхойлолт (Definitions of a Subsidy)

2 дугаар зүйл. Онцгойлсон шинж (Specificity) (Татаас авах боломж зөвхөн цөөн тооны үйлдвэр буюу тодорхой салбараар хязгаарлагдах)

II ХЭСЭГ: ХОРИГЛОСОН ТАТААС (PROHIBITED SUBSIDIES) - Энэ нь бараа экспортлох, эсхүл импортын барааны оронд дотоодын бараа хэрэглэх ганц нөхцөл, эсхүл хэд хэдэн нөхцлийн нэг болон хуульчлагдсан, эсхүл бодит амьдралд тийнхүү тогтсон татаас. Ийм татаасыг аль нэг Гишүүн орон олгож, эсхүл байлгаж болохгүй. Хэлэлцээрийн Хавсралт I-д заасан бүх татаас ийм нөхцлөөр экспортын гүйцэтгэлтэй холбогдсон учир хориглосон татаасын жишээ болно. ХАА-н Хэлэлцээрт заасан татаас үүнд хамаарахгүй.

3 дугаар зүйл. Хориглох (Prohibition)

4 дүгээр зүйл. Эрх зүйн хамгаалалтын хэрэгсэл (Remedies)

III ХЭСЭГ: (Энэ Хэлэлцээрийн дагуу) НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ БУЮУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТАТААС (ACTIONABLE SUBSIDIES) - Бусад Гишүүн орны эрх ашигт харш буюу сөрөг нөлөөтэй, хор хохирол ихтэй татаас.

5 дугаар зүйл. Сөрөг нөлөө (Adverse Effects) - Энэ заалт ХАА-н Хэлэлцээрийн 13 дугаар зүйлд заасан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний татааст хамаарахгүй.

6 дугаар зүйл. Ноцтой хор хохирол (Serious Prejudice)

7 дугаар зүйл. Эрх зүйн хамгаалалтын хэрэгсэл (Remedies)

IV ХЭСЭГ: (Энэ Хэлэлцээрийн III болон V хэсгийн заалтыг үл харгалзан) НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ БУЮУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮНДЭСЛЭЛГҮЙ ТАТААС (NON-ACTIONABLE SUBSIDIES) - Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасан онцгойлсон шинжгүй, эсхүл тийм шинжтэй боловч Хэлэлцээрийн 8.2-т заасан нөхцлийг хангасан татаас. Үүнд шинжилгээ, судалгааны ажил, хөгжлийн бэрхшээлтэй бүс нутаг, мөн байгаль орчныг хамгаалах шинэ шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэлийг өөрчлөн шинэчлэх төсөлд үзүүлэх татаас хамаарна.

8 дугаар зүйл. Нэхэмжлэл гаргах буюу арга хэмжээ авах үндэслэлгүй татаас (Identification of Non-Actionable Subsidies)

9 дүгээр зүйл. Зөвлөлдөх, Эрх зүйн хамгаалалтын хүлээн зөвшөөрөгдсөн хэрэгсэл (Consultations and Authorized Remedies)

V ХЭСЭГ: СААРМАГЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ (COUNTERVAILING MEASURES)

10 дугаар зүйл. 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг мөрдөх (Application of Article VI of GATT 1994)

11 дүгээр зүйл. Тандан судах ажлыг санаачлах/эхлүүлэх ба явуулах (Initiation and Subsequent Investigation)

12 дугаар зүйл. Нотлох баримт (Evidence)

13 дугаар зүйл. Зөвлөлдөх (Consultations)

14 дүгээр зүйл. Татаасын хэмжээг бодит ашиг тус (унц)-аар тооцон гаргах (Calculation of the Amount of a Subsidy in Terms of the Benefit to the Recipient)

15 дугаар зүйл. Хохирлыг тодорхойлох (Determination of Injury)

16 дугаар зүйл. Үндэсний үйлдвэрлэл (үйлдвэрлэгч)-ийн тодорхойлолт (Definition of Domestic Industry)

17 дугаар зүйл. Түр арга хэмжээ авах (Provisional Measures)

18 дугаар зүйл. Үүрэг амлалт авах (Undertakings)

19 дүгээр зүйл. Нөхөн төлөөсийн/саармагжуулах татвар ногдуулах, хураан авах (Imposition and Collection of Countervailing Duties)

20 дугаар зүйл. Хэлэлцээрийн заалтыг буцаан хэрэглэх (Retroactivity)

21 дүгээр зүйл. Нөхөн төлөөсийн/саармагжуулах татвар төлөх болон үүрэг амлалтаа биелүүлэх хугацаа, хэрэгжилтийг хянан үзэх (Duration and Review of Countervailing Duties and Undertakings)

22 дугаар зүйл. Тандалт судалгааны ажлын эхлэл, үр дүн, шийдвэрийн талаар нийтэд мэдээлэх, тайлбарлах (Public Notice and Explanation of Determinations)

23 дугаар зүйл. Захиргааны байгууллагын шийдвэрийг шүүхийн журмаар хянах (Judicial Review)

VI ХЭСЭГ: Хэлэлцээрээр байгуулагдсан байгууллагууд - Тогтолцоо (INSTITUTIONS)

24 дүгээр зүйл. Субсид (татаас) болон Нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээний асуудалд эрхэлсэн Хороо, түүний туслах байгууллагууд (Committee on Subsidies and Countervailing Measures and Subsidiary Bodies)

VII ХЭСЭГ: Татаас байгаа, тандалт судалгаа хийж байгаа, мөн ямар арга хэмжээ авсан талаар холбогдох Гишүүн орон, түүнчлэн ДХБ-д мэдэгдэх, тэдгээрийн явцыг хянан ажиглах (NOTIFICATION AND SURVEILLANCE)

25 дугаар зүйл. Мэдэгдэх (Notifications)

26 дугаар зүйл. Хянан ажиглах (Surveillance)

VIII ХЭСЭГ: Хөгжиж буй Гишүүн орнууд (DEVELOPING COUNTRY MEMBERS)

27 дугаар зүйл. Хөгжиж буй Гишүүн орнуудад зориулсан тусгай ба ялгавартай нөхцөл (Special and Differential Treatment of Developing Country Members)

IX ХЭСЭГ: Шилжилтийн үеийн арга хэмжээ (TRANSITIONAL ARRANGEMENTS)

28 дугаар зүйл. Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд (Existing Programmes)

29 дүгээр зүйл. Зах зээлийн эдийн засагт шилжих (Transformation into a Market Economy)

X ХЭСЭГ: Маргаан шийдвэрлэх (DISPUTE SETTLEMENT)

30 дугаар зүйл. (-)

XI ХЭСЭГ: Төгсгөлийн заалт (FINAL PROVISIONS)

31 дүгээр зүйл. Зарим заалтыг мөрдөх тодорхой хугацаа (Provisional Application)

32 дугаар зүйл. Төгсгөлийн бусад заалт (Other Final Provisions)

ХАВСРАЛТ I: Экспортын татаасыг жишээлэн үзүүлсэн жагсаалт (ILLUSTRATIVE LIST OF EXPORT SUBSIDIES)

ХАВСРАЛТ II: Экспортын барааны үйлдвэрлэлийн орцод (тухайн үйлдвэрлэлд ашигласан бараа, материалд) хамаарах татаасыг хэрхэн тооцох тухай заавар (GUIDELINES ON CONSUMPTION OF INPUTS IN THE PRODUCTION PROCESS)

ХАВСРАЛТ III: Импортын барааг орлох дотоодын бараа ашиглан үйлдвэрлэсэн барааг экспортлоход импортын татвар буцаан олгох системийг экспортын татаас гэж үзэх тухай заавар (GUIDELINES IN THE DETERMINATION OF SUBSTITUTION DRAWBACK SYSTEMS AS EXPORT SUBSIDIES)

ХАВСРАЛТ IV: Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 1(а) -д зааснаар, нийт татаас аливаа бүтээгдэхүүний үнийн дүнгийн 5%-иас хэтэрсэн байх тохиолдолд уг хэмжээг тооцон гаргах (CALCULATION OF THE TOTAL AD VALOREM SUBSIDIZATION (PARAGRAPH 1(a) OF ARTICLE 6))

ХАВСРАЛТ V: Ноцтой хор хохирол учруулсан тухай мэдээлэл бэлдэх журам (PROCEDURES FOR DEVELOPING INFORMATION CONCERNING SERIOUS PREJUDICE)

ХАВСРАЛТ VI: Хэлэлцээрийн 12 дугаар зүйлийн 6-д зааснаар, тандалт судалгааг газар дээр нь явуулах журам (PROCEDURES FOR ON-THE-SPOT INVESTIGATIONS PURSUANT TO PARAGRAPH 6 OF ARTICLE 12)

ХАВСРАЛТ VII: Хэлэлцээрийн 27 дугаар зүйлийн 2(а)-д хамаарах хөгжиж буй Гишүүн орнуудын жагсаалт (DEVELOPING COUNTRY MEMBERS REFERRED TO IN PARAGRAPH 2(a) OF ARTICLE 27)

Татаасын тодорхойлолт:

1.1. Хэлэлцээрийн зорилгоор, дараах тохиолдолд “татаас” (subsidy) байна гэж үзнэ:

(a)(1) аль нэг засгийн газар, эсхүл төрийн аливаа нэг байгууллага (цаашид “засгийн газар” гэх) аль нэг Гишүүн орны нутаг дэвсгэрийн хүрээнд санхүүгийн туслалцаа (financial contribution) үзүүлсэн, өөрөөр хэлбэл:

(i) засгийн газрын үйл ажиллагааны практикт мөнгөн хөрөнгө шууд гуйвуулсан (direct transfer of funds)(жишээ нь: төрөөс мөнгөн тусламж үзүүлсэн - grants, зээл олгосон - loans, эсхүл хувьцаа худалдан авсан - equity infusion), мөнгөн хөрөнгө шууд гуйвуулах зам нээгдсэн (potential direct transfer of funds), эсхүл өр үүсгэсэн (liabilities)(жишээ нь: зээлийн баталгаа гаргасан - loan guarantees) тохиолдол байгаа;

(ii) засгийн газрын (улсын төсвийн) орлого алдагдсан буюу татвар гүйцэд хураагдаагүй (жишээ нь: татварын өр зээл бий болгох г.м.-ээр татварын хөнгөлөлт эдлүүлсэн - fiscal incentives such as tax credits);

(iii) засгийн газар улсын хэрэгцээнд хамааралгүй бараа, үйлчилгээ (goods or services other than general infrastructure) нийлүүлдэг, эсхүл бараа худалдан авдаг;

(iv) засгийн газар аль нэг сангийн тогтолцоо (a funding mechanism)-нд төлбөр хийдэг, эсхүл засгийн газар ерөнхийдөө өөрөө хийх байсан бөгөөд энэ заалтын (i)-(iii)-т үзүүлсэн нэг буюу хэд хэдэн төрлийн ажил үүргийг засгийн газруудын практик ажиллагааны хэвийн жишгээс үл ялгарах нөхцлөөр хувийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр итгэмжилсэн, эсхүл тийм чиглэл өгсөн;

эсхүл

(a)(2) 1994 оны ТХЕХ-ийн XVI зүйлд зааснаар орлого буюу үнэ төлбөрийн асуудал дээр аливаа хэлбэрээр дэмжлэг туслалцаа (any form of income or price support) үзүүлсэн;

мөн

(b) дээрх арга хэмжээнээс ашиг тус хүртсэн (a benefit is thereby conferred).

1.2. Дээр заасан татаасыг зөвхөн 2 дугаар зүйлд заасны дагуу онцгойлсон татаас гэж үзэх тохиолдолд:

- II хэсгийн заалтыг; эсхүл
- III буюу V хэсгийн заалтыг мөрдөнө.

ОХУ –ын мэргэжилтнүүдийн дүгнэлтээс:

Засгийн газрууд худалдааны янз бүрийн бодлого хэрэгжүүлэх үүднээс өөрсдийн үндэсний үйлдвэрлэлд татаас өгч болно гэдгийг ДХБ-аас хүлээн зөвшөөрч байгаа. Харин энэ Хэлэлцээрээр зөвхөн олон улсын худалдаанд өрсөлдөх нөхцлийг гажуудуулах байдлаар татаас өгч буй тохиолдлуудыг зохицуулж байгаа. Түүнчлэн энэ Хэлэлцээр зөвхөн аж үйлдвэрийн бараанд үзүүлж буй татааст хамааралтай. Хөдөө аж ахуйн бараанд татаас үзүүлэх журмыг Хөдөө аж ахуйн тухай Хэлэлцээрт заасан. Засгийн газруудаас үзүүлж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүний татаасыг энэ Хэлэлцээрээр хориглосон, зөвшөөрсөн гэж хоёр хуваан авч үзсэн. Замын гэрлээр авч үзвэл засгийн газраас аж үйлдвэрийн экспортын бараанд олгосон татаасыг дараах маягаар ойлгож болно:

Улаан татаас: хориглосон татаас (үүнд экспортын татаас, мөн импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодын бүтээгдэхүүн ашиглах явдлыг урамшуулсан татаас хамаарна. Ийм татаасын жишээг Хэлэлцээрийн Хавсралт I-д үзүүлсэн: жишээлбэл, шууд экспортын татаас, валютын ханшийг тогтоон барих хөтөлбөрүүд, эсхүл үүнтэй ижилтгэх урамшуулалт экспорт (currency retention schemes or any similar practices which involve a bonus on exports), экспортын барааг дотоодод тээвэрлэх тарифыг дотоодын бусад тээвэртэй харьцуулахад хэт хөнгөлөлтэй нөхцлөөр тогтоосон байх, г.м.

1947 оны ТХЕХ-ээр аж үйлдвэрийн бараанд экспортын татаас олгох явдлыг

зөвхөн хөгжингүй орнуудын хувьд хориглосон байжээ. Уругвайн үе шатны хэлэлцээний дараа уг заалт мөн хөгжиж байгаа орнуудад хамааралтай болсон. Тэдэнд татаас олгох системээ өөрчлөх 8 жилийн хугацаа өгөгдсөн. Хөгжиж буй орнууд энэ хугацаанд өөрсдийн экспортын татаасын хэмжээг нэмэгдүүлж болохгүй. Харин буурай хөгжилтэй орнууд (нэг хүнд ногдох ДНБ 1000 ам. доллараас доош байгаа) экспортын татаас олгож болно.)

Шар татаас: хориглоогүй боловч, тухайн татаас бүхий экспорт улс орны эрх ашигт хор хохирол учруулсан тохиолдолд холбогдох шийтгэлийн арга хэмжээ авбал зохих татаас (Холбогдох татаас импортлогч орны худалдаанд сөрөг нөлөө үзүүлсэн байх ёстой. Энэ тохиолдолд авах хариу арга хэмжээ болгож нөхөн төлөөсийн буюу саармагжуулах татвар ногдуулж болно. Гол нь тийнхүү татаас олгосон импортын бараа үндэсний үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл тийм хохирол учруулах аюултай гэдгийг тогтоосон бодит баримт байх ёстой. Түүнээс гадна, тухайн импортлогч орон уг асуудлыг Худалдааны маргаан шийдвэрлэх байгууллагад тавьж, холбогдох экспортлогч орны татаасыг өөрчлүүлэх, эсхүл болиулах хүртэл арга хэмжээ авахуулж болно)

Ногоон татаас: хориглоогүй, мөн Хэлэлцээрийн дагуу ямар нэгэн шийтгэлийн арга хэмжээ авах шаардлагагүй татаас (Бодит байдал дээр хүлээн зөвшөөрөгдсөн татаас. Үүнд хамаарах татаасын талаар өмнө, Хэлэлцээрийн IV хэсгийн тайлбарт дурдсан).


Хориглоогүй татаасыг шар, ногоон төлөвөөр ангилахын тулд Хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасны дагуу онцгойлсон шинжтэй эсэхийг тогтоох ёстой. Аливаа татаас дараах хүрээнд олгогдсон бол онцгойлон авч үзсэн шинжтэй болно:

- зөвхөн нэг үйлдвэрийн газарт, эсхүл нэг хэсэг үйлдвэрийн газарт олгогдсон
- үйлдвэрлэлийн тодорхой нэг салбарт, эсхүл нэг хэсэг салбарт олгогдсон
- газар зүйн тодорхой нэг бүсэд олгогдсон.


Энэ үүднээс, ОХУ эрчим хүч тээгчийн дотоодын зах зээлийн үнийг доогуур тогтоон барьж байгаа нь татаас мөн, харин ийм татаасыг ОХУ-ын бүх үйлдвэр нэгэн адил эдэлж байгаа учир тэр нь онцгойлсон шинжтэй биш гэнэ.

Нөхөн төлөөсийн/саармагжуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд үндэсний үйлдвэрлэлд учирсан бодит хохирол, эсхүл тийм хохирол учирах аюулыг тогтоох үүднээс тандалт судалгаа хийгдсэн байх ёстой. Тандалт судалгааны ажлыг Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд үндэсний үйлдвэрлэгчдийн зүгээс, эсхүл тэдний нэрийн өмнөөс бичгээр гаргасан албан ёсны өргдөл/хүсэлтийг үндэслэн эхлүүлнэ/ санаачилна (11.1 заалт).

Зураг 14. Экспортлогч улсад ногдуулсан саармагжуулах арга хэмжээний тоо (1995.01.01-2016.12.31, нийт 240)



Зураг 15. Тайлан мэдээ ирүүлсэн улс орнуудаас авч хэрэгжүүлсэн саармагжуулах арга хэмжээний тоо (1995.01.01-2016.12.31, нийт 240)





16. Худалдааг хөнгөвчлөх тухай Хэлэлцээр

1.а. Гэрээний нэр англиар:	Agreement on Trade Facilitation
1.б. Гэрээний нэр оросоор:	Соглашение по упрощению процедур торговли
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	2013-12-7. Индонези Улсын Бали арал (Bali, Indonesia)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2017-02-22 (энэ өдөр ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол хүчин төгөлдөр болсноор түүний хавсралт болох Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр хүчин төгөлдөр болсон)
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 137 (Монгол Улс - 100 дахь улс)
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2016-11-24 (ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколыг соёрхон баталсан)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2016-11-28
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2017-02-22
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	I хэсгийн 12 зүйлийн заалтуудыг А, В, С ангилалд хамааруулан заасан.
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол (Женев хот, 2014 оны 11 дүгээр сарын 27)-оор Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр нь энэхүү Марракешийн хэлэлцээрийн 1А хавсралт болох Барааны худалдааны тухай олон талт Хэлэлцээрүүдийн 13 дахь хэлэлцээр нь болсон.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протоколд нэгдэн орох тухай 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хууль

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Худалдаа эрхлэгч нарын хувьд барааг хилээр оруулж, гаргахад хүнд суртал маш их саад болдог.

Худалдааг хөнгөвчлөх гэдэг нь экспорт, импортын горим журмыг хялбарчлах, өөрчлөн шинэчлэх, уялдуулах явдал юм. Энэ хэлэлцээрт барааны, түүний дотор дамжин өнгөрөх барааны хөдөлгөөн, олголт болон бүрдүүлэлтийг түргэн шуурхай болгох тухай заалтууд тусгагдсан.

Хэлэлцээрийн бүтэц:

I ХЭСЭГ

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЭВЛЭН НИЙТЛЭХ БОЛОН МЭДЭЭЛЛИЙГ ХҮРТЭЭЛТЭЙ БОЛГОХ (PUBLICATION AND AVAILABILITY OF INFORMATION)

1. Хэвлэл нийтлэх (Publication)
2. Интернетээр дамжуулан авах боломжтой мэдээлэл (Information Available Through Internet)
3. Лавлах цэг (Enquiry Points)
4. Мэдэгдэл (Notification)

2 ДУГААР ЗҮЙЛ. САНАЛ ӨГӨХ БОЛОМЖ ОЛГОХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХООС ӨМНӨ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, ЗӨВЛӨГӨӨН (OPPORTUNITY TO COMMENT, INFORMATION BEFORE ENTRY INTO FORCE, AND CONSULTATIONS)

1. Санал өгөх боломж олгох, хүчин төгөлдөр болохоос өмнө мэдээлэл өгөх (Opportunity to Comment and Information before Entry into Force)
2. Зөвлөгөөн (Consultations)

3 ДУГААР ЗҮЙЛ. УРЬДЧИЛСАН ШИЙДВЭР (ADVANCE RULINGS)

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДАВЖ ЗААЛДАХ БУЮУ ХЯНАН ҮЗЭХ ЖУРАМ (PROCEDURES FOR APPEAL OR REVIEW)

5 ДУГААР ЗҮЙЛ. ҮНЭНЧ ШУДАРГА АЖИЛЛАХ, ҮЛ ЯЛГАВАРЛАХ БОЛОН ИЛ ТОД БАЙХ ЯВДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ БУСАД АРГА ХЭМЖЭЭ (OTHER MEASURES TO ENHANCE IMPARTIALITY, NON-DISCRIMINATION AND TRANSPARENCY)

1. Хяналт шалгалтыг чангатгах талаар мэдэгдэл хүргүүлэх (Notifications for enhanced controls or inspections)
2. Бараа саатуулах (Detention)
3. Шинжилгээний журам (Test Procedures)

6 ДУГААР ЗҮЙЛ. БАРАА ОРУУЛАХ, ГАРГАХ ҮЕД, ЭСХҮЛ ТҮҮНТЭЙ ХОЛБОГДУУЛАН НОГДУУЛАХ ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ТУХАЙ, МӨН ТОРГУУЛЬ ШИЙТГЭЛИЙН ТУХАЙ ЖУРАМ (DISCIPLINES ON FEES AND CHARGES IMPOSED ON OR IN CONNECTION WITH IMPORTATION AND EXPORTATION AND PENALTIES)

1. Бараа оруулах, гаргах үед, эсхүл түүнтэй холбогдуулан ногдуулах төлбөр, хураамжийн ерөнхий журам (General Disciplines on Fees and Charges Imposed on or in Connection with Importation and Exportation)
2. Бараа оруулах, гаргах үед, эсхүл түүнтэй холбогдуулан ногдуулах гаалийн бүрдүүлэлтийн төлбөр, хураамжийн тусгай журам (Specific disciplines on Fees and Charges for Customs Processing Imposed on or in Connection with Importation and Exportation)
3. Торгууль шийтгэлийн тухай журам (Penalty Disciplines)

7 ДУГААР ЗҮЙЛ: БАРАА ОЛГОЛТ БА БҮРДҮҮЛЭЛТ (RELEASE AND CLEARANCE OF GOODS)

1. Бичиг баримтын бүрдүүлэлтийг бараа ирэхээс өмнө хийлгэх (Pre-arrival Processing)
2. Цахим төлбөр (Electronic Payment)
3. Бараа олгох ажиллагааг гаалийн болон бусад татварыг, мөн төлбөр, хураамжийг эцэслэн тодорхойлох ажиллагаанаас ялган салгах (Separation of Release from Final Determination of Customs Duties, Taxes, Fees and Charges)
4. Эрсдэлийн удирдлага (Risk Management)
5. Бүрдүүлэлтийн дараах шалгалт (Post-clearance Audit)
6. Бараа олгох дундаж хугацааг тогтоож, хэвлэн нийтлэх (Establishment and Publication of Average Release Times)
7. Итгэмжлэгдсэн операторуудад зориулсан худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ (Trade Facilitation Measures for Authorized Operators)
8. Түргэвчилсэн бүрдүүлэлт хийлгэх ачаа (Expedited Shipments)
9. Түргэн мууддаг бараа (Perishable Goods)

8 ДУГААР ЗҮЙЛ. ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА (BORDER AGENCY COOPERATION)

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ИМПОРТЫН БАРААГ ГААЛИЙН ХЯНАЛТЫН ДОР ТЭЭВЭРЛЭХ (MOVEMENT OF GOODS INTENDED FOR IMPORT UNDER CUSTOMS CONTROL)

10 ДУГААР ЗҮЙЛ. БАРАА ОРУУЛАХ , ГАРГАХ, ДАМЖУУЛАН ӨНГӨРҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ЁС ЖУРМЫН АЖИЛЛАГАА (FORMALITIES CONNECTED WITH IMPORTATION, EXPORTATION AND TRANSIT)

1. Ёс журмын ажиллагаа, бичиг баримт бүрдүүлэлтийн шаардлага (Formalities and Documentation Requirements)
2. Хуулбарыг хүлээн зөвшөөрөх (Acceptance of Copies)
3. Олон улсын стандарт ашиглах (Use of International Standards)
4. Нэг цонхны систем (Single Window)
5. Ачилтын өмнөх шалгалт (Preshipment Inspection)
6. Гаалийн зуучлагч ашиглах (Use of Customs Brokers)
7. Хилийн хяналтын нийтлэг журам ба бичиг баримт бүрдүүлэлтийн нэгдсэн шаардлага (Common Border Procedures and Uniform Documentation Requirements)
8. Барааг оруулахаас татгалзах (Rejected Goods)
9. Барааг түр хугацаагаар оруулах, дотоодод болон гадаадад боловсруулах (Temporary Admission of Goods and Inward and Outward Processing)

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДАМЖИН ӨНГӨРӨХ ЭРХ ЧӨЛӨӨ (FREEDOM OF TRANSIT)

12 ДУГААР ЗҮЙЛ. ГААЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА (CUSTOMS COOPERATION)

1. Хамтын ажиллагаа болон хууль дүрэм сахиулах арга хэмжээ (Measures Promoting Compliance and Cooperation)
2. Мэдээлэл солилцох (Exchange of Information)
3. Үнэн мөнийг шалгах (Verification)
4. Хүсэлт гаргах (Request)
5. Мэдээлэл, бичиг баримтыг хамгаалах болон нууцлах (Protection and Confidentiality)
6. Мэдээлэл гаргаж өгөх (Provision of Information)
7. Хүсэлт биелүүлэхийг хойшлуулах, эсхүл биелүүлэхээс татгалзах (Postponement or Refusal of a Request)
8. Харилцан адил байх (Reciprocity)
9. Захиргааны зардал (Administrative Burden)
10. Эрхийн хязгаарлалт (Limitations)
11. Мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглах буюу задруулах (Unauthorized Use or Disclosure)
12. Хоёр талт болон бүс нутгийн хэлэлцээрүүд (Bilateral and Regional Agreements)

II ХЭСЭГ. ХӨГЖИЖ БУЙ ГИШҮҮН ОРНУУД БОЛОН БУУРАЙ ХӨГЖИЛТЭЙ ГИШҮҮН ОРНУУДАД ЗОРИУЛСАН ТУСГАЙ БОЛОН ЯЛГАВАРТАЙ НӨХЦӨЛ БҮХИЙ ЗААЛТУУД (SPECIAL AND DIFFERENTIAL TREATMENT PROVISIONS FOR DEVELOPING COUNTRY MEMBERS AND LEAST-DEVELOPED COUNTRY MEMBERS)

13 ДУГААР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ (GENERAL PRINCIPLES)

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОЛБОГДОХ ЗААЛТУУДЫН АНГИЛАЛ (CATEGORIES OF PROVISIONS)

15 ДУГААР ЗҮЙЛ. А АНГИЛЛЫН ЗААЛТУУДЫН ТАЛААР МЭДЭГДЭХ, МӨН ТЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ (NOTIFICATION AND IMPLEMENTATION OF CATEGORY A)

16 ДУГААР ЗҮЙЛ. В БОЛОН С АНГИЛЛЫН ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ЭЦЭСЛЭН ТОГТСОН ӨДРҮҮДИЙГ МЭДЭГДЭХ (NOTIFICATION OF DEFINITIVE DATES FOR IMPLEMENTATION OF CATEGORY B AND CATEGORY C)

17 ДУГААР ЗҮЙЛ. ЭРТНЭЭС АНХААРУУЛАХ МЕХАНИЗМ: В БОЛОН С АНГИЛЛЫН ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦААГ СУНГАХ (EARLY WARNING MECHANISM: EXTENSION OF IMPLEMENTATION DATES FOR PROVISIONS IN CATEGORIES B AND C)

18 ДУГААР ЗҮЙЛ. В БОЛОН С АНГИЛЛЫН ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ (IMPLEMENTATION OF CATEGORY B AND CATEGORY C)

19 ДҮГЭЭР ЗҮЙЛ. В БОЛОН С АНГИЛЛЫН ЗААЛТУУДЫГ ХООРОНД НЬ ШИЛЖҮҮЛЭХ (SHIFTING BETWEEN CATEGORIES B AND C)

20 ДУГААР ЗҮЙЛ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ДҮРЭМ, ЖУРМЫН ТУХАЙ ТОХИРОЛЦООГ МӨРДӨХӨД БАРИМТЛАХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХУГАЦАА (GRACE PERIOD FOR THE APPLICATION OF THE UNDERSTANDING ON RULES AND PROCEDURES GOVERNING THE SETTLEMENT OF DISPUTES)

21 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ (PROVISION OF ASSISTANCE AND SUPPORT FOR CAPACITY BUILDING)

22 ДУГААР ЗҮЙЛ. ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГИЙН ТАЛААР ХОРООНД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ (INFORMATION ON ASSISTANCE AND SUPPORT FOR CAPACITY BUILDING TO BE SUBMITTED TO THE COMMITTEE)

III ХЭСЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ (INSTITUTIONAL ARRANGEMENTS AND FINAL PROVISIONS)

23 ДУГААР ЗҮЙЛ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ (INSTITUTIONAL ARRANGEMENTS)

1. Худалдааг хөнгөвчлөх хороо (Committee On Trade Facilitation)
2. Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (National Committee On Trade Facilitation)

24 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ (FINAL PROVISIONS)

ХАВСРАЛТ 1: 22 ДУГААР ЗҮЙЛИЙН 1 ДЭХ ХЭСГИЙН ДАГУУ МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ЗАГВАР (FORMAT FOR NOTIFICATION UNDER ARTICLE 22.1)

Хэлэлцэн тохирогч Талууд энэ хэлэлцээрт нэгдэн орохдоо хэлэлцээрийн I хэсгийн 12 зүйл, тэдгээрийн заалтуудыг А, В, С гэсэн ангиллаар ангилна. А ангилалд хамааруулсан зүйл, заалтыг энэ хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. В ангилалд хамааруулсан зүйл, заалтыг тэдгээрийг дагаж мөрдөх нөхцөл бүрдсэн үеэс эхлэн дагаж мөрдөнө. Харин С ангилалд хамааруулсан зүйл, заалтыг чадавхийг бэхжүүлэх чиглэлээр техникийн туслалцаа авч, тэдгээрийг дагаж мөрдөх нөхцөл бүрдсэн үеэс эхлэн дагаж мөрдөнө.



НҮБ-ын Байгаль орчны Хөтөлбөр

The United Nations Environment Programme

Программа ООН по окружающей среде (ЮНЕП)

(Кени Улсын Наироби хот, 1972)

III БҮЛЭГ

**НҮБ-ЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ХӨТӨЛБӨРӨӨС ХЯНАЛТ ТАВИН
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАРИМТ БИЧГҮҮД**



17. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенц (Вашингтоны Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora (Washington Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о международной торговле видами дикой фауны и флоры, находящимися под угрозой исчезновения
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1973-03-03. АНУ-ын Вашингтон хот (Washington, The USA)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1975-07-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 183
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1995-05-04 (Их Хурал)
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-01-05 (CITES)
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1996-40-04
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - CITES-ийн Талуудын Бага хурлын 2002 оны 12 дугаар хуралдаанаар энэ конвенцийн 1, 2 дугаар хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон.	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - Конвенцид нэгдэн орох тухай 1995 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн хууль - Конвенцийн хавсралтад орсон нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хууль	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц 3 хавсралттай. Энэ 3 хавсралтад заасан амьд ба үхсэн амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, эд зүйлийг хилээр нэвтрүүлэхэд экспорт, импортын зөвшөөрөл, ре-экспортын гэрчилгээ шаардлагатай. Талууд нь Конвенцийн IX зүйлд заасны дагуу Удирдан зохицуулах зөвлөл (нэг буюу хэд хэдэн зөвлөл), мөн Шинжлэх ухааны зөвлөл (нэг буюу хэд хэдэн зөвлөл) байгуулах бөгөөд Шинжлэх ухааны зөвлөл (a Scientific Authority)-ийн дүгнэлтийг үндэслэн Удирдан зохицуулах зөвлөл (the Management Authority)-өөс уг зөвшөөрөл, гэрчилгээг олгоно. Тус конвенцийг хэрэгжүүлэх Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны зөвлөлүүд Байгаль очны сайдын тушаалаар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.



18. Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенц (Венийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	Vienna Convention for the Protection of the Ozone Layer (Vienna Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Венская Конвенция об охране озонового слоя
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1985-03-22, Австри Улсын Вена хот (Vienna, Austria)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1988-09-22
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 197
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1995-10-16
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-03-07
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1996-06-05
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн 1987 оны протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - 1995 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар “Озоны үе давхаргыг хамгаалах тухай” Венийн 1985 оны конвенц, түүнд засвар, залруулга, нэмэлт, өөрчлөлт оруулсан “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” Монреалийн 1987 оны протоколд тус тус нэгдэн орсон.	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:


Конвенцийн болон холбогдох протокол (Монреалийн протокол)-ын Хэлэлцэн тохирогч Талууд дараах үүрэг хүлээсэн:

1. Хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хүний үйл ажиллагаанаас хамааралтай сөрөг нөлөөнөөс хамгаалах - озоны давхаргад нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас үе шаттайгаар татгалзах;
2. Харилцан итгэлцэж, хамтран ажиллах - хүний үйл ажиллагаанаас озоны давхаргад нөлөөлөх нөлөөллийг ойлгож, үнэлэх, тийм үйл ажиллагаанд тавих хяналтыг уялдуулах арга хэмжээ авах, холбогдох олон улсын байгууллагатай хамтран ажиллах.

Озоны давхарга (Ozone layer) гэж юу вэ?

Озоны давхарга давхраат мандлын 35 км-ийн бүсэд маш сийрэг нимгэн тархсан байдаг. Озоны давхарга нарны хэт ягаан туяа дэлхийн гадаргад хүрэхээс хамгаалж, түүнийг өөртөө шингээх шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Зураг 15. Earth - Дэлхий



Altitude of most clouds - Үүл (Дэлхийн гадаргуугаас ~10 км-ээс доош)


Troposphere and tropospheric ozone - Орчих/орчил мандал ба орчих мандлын озон (Дэлхийн гадаргуугаас ~0-12 км)

Stratosphere and Natural Protective Ozone Layer (Ozone shield) - Давхраат мандал (Дэлхийн гадаргуугаас ~12-50 км) ба озоны хий бүхий байгалийн хамгаалалтын хуяг/давхарга (Дэлхийн гадаргуугаас ~35 км)

Mesosphere - Цэнэгт мандал (Дэлхийн гадаргуугаас ~50 - 480 км)

Озон нь хүчилтөрөгчийн 3 атом агуулсан тунгалаг хий юм байна. Нэг талаар, нарны энерги нь озонг шинээр тасралтгүйгээр "үйлдвэрлэж" байдаг боловч нөгөө талаар озоны молекулууд нь устөрөгч, азот, хлор зэргийг агуулсан агаар мандлын байгалийн хийн нэгдлүүдээр тасралтгүйгээр "устан сүйтгэгдэж" байдаг гэнэ.

Зураг 16. Ozone Production - Озоны үйлдвэрлэл (Зураг 1-4),
Ozone Destruction - Озоны устлал (задрал) (Зураг 5-8)




Хэт ягаан туяа (Ultraviolet radiation) гэж юу вэ?

Нар бидэнд цацраг туяагаа илгээж, халуун, дулаан, гэрэл гэгээг бэлэглэдэг. Нарны энэхүү цацраг туяаг хэт ягаан туяа, өдрийн гэрэл, нил ягаан (нил улаан) туяа гэж гурав ангилдаг. Тэдгээрээс хамгийн богино долгионтой, хүний эрүүл мэндэд хортой нь хэт ягаан туяа юм. Озоны давхарга гэмтээд байгаа өнгөрсөн 50 гаруй жилийн хугацаанд нарны хэт ягаан туяа бидэнд хүрч, наранд түлэгдэхээс өгсүүлээд арьсны хорт хавдар, нүдний болор цайх (нүдний болорын тунгалаг багасах, ингэснээр хүний харах чадвар

алдагдаж, эмчлэхгүй бол сохрох аюултай) өвчин дэлгэрч, цаашлаад дархлалын систем сулрах аюул учраад байна.

Хэт ягаан туяа зөвхөн хүн амын эрүүл мэндэд аюул учруулаад зогсохгүй бас байгаль орчинд сөрөг нөлөөтэй байдаг байна. Тухайлбал, хэт ягаан туяаны уршгаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ялангуяа ургац буурах, уг туяа загасанд нөлөөлснөөр далайн амьтдын хүнс тэжээлийн гинжин холбоо устах аюултай гэнэ. Озоны давхарга гэмтээгүй байхад багахан хэмжээний хэт ягаан туяа дэлхийн гадаргад хүрдэг байсан байна.

Зураг 17. Regions of The Atmosphere - Агаар Мандлын Бүс




Зураг дээр: REGIONS OF THE ATMOSPHERE - АГААР МАНДЛЫН БҮС

- UV (Ultraviolet radiation)/visible sunlight - Хэт ягаан туяа/Нүдэнд үзэгдэх нарны гэрэл
- Infrared radiation - Нил улаан туяа
- MESOSPHERE - Цэнэгт мандал (Дэлхийн гадаргуугаас ~50-480 км-т) (0°F, -18°C)
- STRATOSPHERE - Давхраат мандал (Дэлхийн гадаргуугаас ойролцоогоор ~12-50 км-т) (-80°F, -62°C)
- TROPOSPHERE - Орчих/орчил мандал (Дэлхийн гадаргуугаас ~12 км-ийн дотор) (60°F, 16°C)
- Ozone layer - Озоны давхарга
- Mt Everest - Гималайн нурууны Эверестийн оргил (~9 км өндөр)
- Plane - Онгоц (~8 км өндөрт ниснэ)


Харамсалтай нь озоны давхаргын гэмтэл (цоорхой) жил ирэх тусам томорсоор байна. Одоогоор Антарктид (**Өмнөд туйл**) дээр томоохон, Арктик (Хойд туйл) дээр багахан хэмжээний цоорхойг

илрүүлээд байна. Антаркид дээрх цоорхой 28 сая ам. дөрвөлжин метр буюу БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гурав дахин том байна. Арктик дээрх цоорхой үе үе илэрч, алга болдог.

Зураг 18. Өмнөд туйл дээрх озоны цоорхой



Зураг 19. Озоны цоорхойн нөхөлт




Озоны цоорхой (ozone hole) гэж юу вэ?

Энэ нь яг үнэндээ цоорхой нүх биш, харин озоны давхарга улам нимгэрч байгаа (ozone depletion) гэсэн үг юм байна. Энэ нь хүн төрөлхтөн химийн бодсуудыг агаарт алдсаны сөрөг үр дагавар юм. Бидний өдөр тутмын амьдралд ашиглаж байгаа зарим химийн бодис озоны давхаргыг гэмтээдэг (озоны хийн химийн нэгдлийг задалдаг) болохыг эрдэмтэд 1970-аад оноос илрүүлсэн. Ийм химийн бодисуудаас дурдвал:

- хлортфторт нүүрстөрөгч - ХФН (**chlorofluorocarbons - CFCs**) буюу хөргөх бодис болох фреон - freon (түүнийг автомашин болон тасалгааны агааржуулалтын систем, хөргөгч, хөлдөөгч, агаар цэвэршүүлэгч (**aerosol propellants**), хөөсөнцөр бүтээгдэхүүн, мөн матраст ашигладаг);
- галоны хий (**halon gases**) (гал сөнөөхөд ашигладаг бодис);
- метил бромид (**methyl bromide**) (хортон шавьж устгахад ашигладаг бодис).

Зураг 20. Озоны давхарга нөхөн төлжих боломж



Дээрх зураг: edge of atmosphere (агаар мандлын/ агаарын төгсгөл), reflected (ойсон туяа), absorbed (агаар мандалд шингэсэн туяа), absorbed by atmosphere and Earth (агаар мандал болон газарт шингэсэн туяа), escaping radiation (гадагш алдагдсан туяа), radiation absorbed by greenhouse gases (хүлэмжийн хийд шингэсэн туяа), deforestation (ой мод огтолж түлэх/устгах, ойгүйдэл), CFCs (ХФН), oil and petrol engines (шингэн түлшээр ажилладаг автомашины хөдөлгүүр), greenhouse gases and fossil fuels (хүлэмжийн хий ба чулуужсан түлш)

Хэрэв улс бүр озоны давхаргыг хамгаалах асуудалд ухаалгаар хандаж, озон задлагч химийн бодисын хэрэглээг багасгаж, улмаар зогсоож чадвал, озоны давхарга нөхөн төлжих боломжтой юм байна.

Озоны давхаргыг хамгаалах олон улсын өдөр ба Монгол Улсын Озоны алба:

9 дүгээр сарын 16: Хүн төрөлхтнийг агшин зуур “шорлог” болгох нарны нарны хэт ягаан туяаг өөртөө шингээж, хэдэх зуун сая жилийн турш эх дэлхийн амьтай бүхнийг ивээсээр буй озоны давхаргыг хамгаалах олон улсын өдөр.

Монгол Улсын Озоны алба 1999 онд байгуулагджээ. Түүний үүрэг нь озоны давхаргыг задалдаг бүх бодисыг хяналтад авах, тэдгээрийн хэрэглээг шат дараалан бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал болно. Үүний зэрэгцээ, Байгаль орчны яамтай хамтран озоны давхаргад ээлтэй бүтээгдэхүүний тухай ойлголтыг хүн амд түгээн дэлгэрүүлэх ажил хийдэг байна.



19. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протокол (Монреалийн протокол)

1.а. Гэрээний нэр англиар:	Montreal Protocol on Substances That Deplete the Ozone Layer (a Protocol to the Vienna Convention for the Protection of the Ozone Layer) (Montreal Protocol)
1.б. Гэрээний нэр оросоор:	Монреальский протокол по веществам, разрушающим озоновый слой
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1987-09-16, Канад Улсын Монреал хот (Montreal, Canada)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1989-01-01
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 197
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1995-10-16
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1996-03-07
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1996-06-05
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	<ul style="list-style-type: none"> - 1990 онд Лондон, 1991 онд Наироби, 1992 онд Копенгаген, 1993 онд Бангкок, 1995 онд Вена, 1997 онд Монреал, 1998 онд Австрали, 1999 онд Бээжин, 2016 онд Кигали хотноо тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Хамгийн сүүлийнх нь хүчин төгөлдөр болоогүй байгаа.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - 1995 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар “Озоны үе давхаргыг хамгаалах тухай” Венийн 1985 оны конвенц, түүнд засвар, залруулга, нэмэлт, өөрчлөлт оруулсан “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай” Монреалийн 1987 оны протоколд тус тус нэгдэн орсон.

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Протокол Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенцыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан. Уг Венийн Конвенц, озоны давхарга, озон задалдаг бодис, холбогдох бусад сэдвийн талаар Венийн Конвенцийн хэсгээс уншина уу.

Уг Протокол нь озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, улмаар зогсоход чиглэгдсэн. Түүний Хэлэлцэн тохирогч Талууд озоны давхаргын гэмтлийг 2050 он гэхэд 1980 оноос өмнөх хэмжээнд буцаан хүргэх зорилт тавьсан.

Протоколын бүтцийг үзүүлбэл:

- Зүйл 1: Тодорхойлолт
- Зүйл 2: Хяналтын арга хэмжээ
- Зүйл 2A: Хлортфторт нүүрстөрөгч - ХФН (Chlorofluorocarbons - CFCs)
- Зүйл 2B: Галон (Halons)
- Зүйл 2C: Бүрэн галогенжуулсан бусад ХФН (Other fully halogenated CFCs)
- Зүйл 2D: Дөрвөн хлорт нүүрстөрөгч (Carbon tetrachloride)
- Зүйл 2E: Гурван хлорт этан (1,1,1-Trichloroethane) буюу Метилхлороформ - Methyl chloroform)
- Зүйл 2F: Гидрохлортфторт нүүрстөрөгч (Hydrochlorofluorocarbons)
- Зүйл 2G: Гидробромтфторт нүүрстөрөгч (Hydrobromofluorocarbons)
- Зүйл 2H: Метил бромид (Methyl bromide)
- Зүйл 2I: Бромтхлорт метан (Bromochloromethane)
- Зүйл 3: Хяналтын түвшинг тооцох Calculation of control levels
- Зүйл 4: Протоколын Хэлэлцэн тохирогч Тал биш улстай хийх худалдааг хянах (Control of trade with non-Parties) (Хавсралтуудад заасан бодисыг эдгээр улсаас импортлохоо зогсоох тодорхой хугацааг бодис тус бүрээр заасан)
- Зүйл 4A: Протоколын Хэлэлцэн тохирогч Талтай хийх худалдааг хянах (Control of trade with Parties)
- Зүйл 4B: Импорт, экспортын зөвшөөрөл олгох систем нэвтрүүлэх (Licensing)
- Зүйл 5: Хөгжиж буй орнуудын онцлог байдал (Special situation of developing countries)
- Зүйл 6: Хяналтын арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэх, үнэлэх (Assessment and review of control measures)
- Зүйл 7: Нарийн бичгийн даргын газарт мэдээлэл өгөх (Reporting of data)
- Зүйл 8: Протоколын заалт зөрчих (Non-compliance)
- Зүйл 9: Судалгаа хийх, боловсруулах, нийтэд ойлгуулах, мэдээлэл солилцох (Research, development, public awareness and exchange of information)
- Зүйл 10: Санхүүгийн механизм (Financial mechanism)
- Зүйл 10A: Технологи шилжүүлэх (Transfer of technology)
- Зүйл 11: Талуудын уулзалт (Meetings of the parties)
- Зүйл 12: Нарийн бичгийн даргын газар (Secretariat)
- Зүйл 13: Санхүүгийн асуудал (Financial provisions)
- Зүйл 14: Энэ Протокол Конвенцтойгоо холбогдох нь (Relationship of this Protocol to the Convention)
- Зүйл 15: Гарын үсэг зурахад нээлттэй байх хугацаа (Signature)
- Зүйл 16: Протокол хүчин төгөлдөр болох (Entry into force)
- Зүйл 17: Протокол хүчин төгөлдөр болсны дараа нэгдсэн орсон улсууд (Parties joining after entry into force)
- Зүйл 18: Тайлбар хийх (Reservations)
- Зүйл 19: Протоколыг цуцлах (Withdrawal)
- Зүйл 20: Эх бичвэрүүд адил хүчинтэй байх (Authentic texts).

Хүснэгт 20. Монреалийн Протоколын хавсралт А, В, С, Е-д хамрагдсан бодисууд

Олон улсын нэршил (ОЗЧ)	Химийн нэршил	Томьёо	БТКУС-ийн код	ASHRAE #	Хөгжингүй орны амлалт	Протоколын 5 дугаар зүйлд хамаарах хөгжиж буй орны амлалт
Хавсралт А: Хяналтанд орсон бодисууд (Controlled Substances) I бүлэг (Group I): Хлортфторт нүүрстөрөгч - ХФН (Chlorofluorocarbons - CFCs) (Протоколын Зүйл 2A)						
CFC-11 (1.0)	3 хлорт, фторт метан (Трихлорфторметан)	CFCl_3	2903.41.00	R-11	1994: 75% ↓ 1996: (xx)	2005 : 50% ↓ 2007 : 80% ↓ 2010 : (үз/xx)
CFC-12 (1.0)	2 хлорт, 2 фторт метан (Дихлордифторметан)	CF_2Cl_2	2903.42.00	R-12		
CFC-113 (0.8)	3 хлорт, 3 фторт этан (Трихлортрифторэтан)	$\text{C}_2\text{F}_3\text{Cl}_3$	2903.43.00	R-113		
CFC-114 (1.0)	2 хлорт, 4 фторт этан (Дихлорттетрафторэтан)	$\text{C}_2\text{F}_4\text{Cl}_2$	2903.44.10	R-114		
CFC-115 (0.6)	Хлорт, 5 фторт этан Хлорпентафторэтан	$\text{C}_2\text{F}_5\text{Cl}$	2903.44.20	R-115		
II бүлэг (Group II): Галон (Halons) (Протоколын Зүйл 2B)						
Halon-1211 (3.0)	Бромт хлорт 2 фторт метан (Бромхлордифторметан)	CF_2BrCl	2903.46.10	R-12B1	1994 : (xx)	2005 : 50% ↓ 2010 : (үз/xx)
Halon-1301 (10.0)	Бромт 3 фторт метан (Бромтрифторметан)	CF_3Br	2903.46.20	R-13B1		
Halon-2402 (6.0)	2 бромт 4 фторт этан (Дибромтетрафторэтан)	$\text{C}_2\text{F}_4\text{Br}_2$	2903.46.30	R-114B2		
Хавсралт В: Хяналтанд орсон бодисууд (Controlled Substances) I бүлэг (Group I): Бүрэн галогенжуулсан бусад ХФН (Other fully halogenated CFCs) (Протоколын Зүйл 2C)						
CFC-13 (1.0)	Хлорт, 2 фторт метан (Хлордифторметан)	CF_3Cl	2903.45.11	R-13	1993: 20% ↓ 1994: 75% ↓ 1996: (xx)	2003 : 20% ↓ 2007 : 85% ↓ 2010 : (үз/xx)
CFC-111 (1.0)	5 хлорт, фторт метан (Пентахлорфторэтан)	C_2FCl_5	2903.45.31	R-111		
CFC-112 (1.0)	4 хлорт, 2 фторт этан (Тетрахлордифторэтан)	$\text{C}_2\text{F}_2\text{Cl}_4$	2903.45.21	R-112		
Энэ бүлэгт өшөө 7 CFC орно: (CFC-211 - C_3FCl_7), (CFC-212 - $\text{C}_3\text{F}_2\text{Cl}_6$), (CFC-213 - $\text{C}_3\text{F}_3\text{Cl}_5$), (CFC-214 - $\text{C}_3\text{F}_4\text{Cl}_4$), (CFC-215 - $\text{C}_3\text{F}_5\text{Cl}_3$), (CFC-216 - $\text{C}_3\text{F}_6\text{Cl}_2$), (CFC-217 - $\text{C}_3\text{F}_7\text{Cl}$). Эдгээрийн ОЗЧ нь бүгд 1.0 байна.						
II бүлэг (Group II): Дөрвөн хлорт нүүрстөрөгч (Carbon tetrachloride) (Протоколын Зүйл 2D)						
Tetrachloro-ethane буюу Carbon tetrachloride (1.1)	4 хлорт этан буюу 4 хлорт нүүрстөрөгч (Тетрахлорт нүүрстөрөгч)	CCl_4	2903.14.00		1995: 85% ↓ 1996: (xx)	2005: 85% ↓ 2010: (үз/xx)
III бүлэг (Group III): Гурван хлорт этан (1,1,1-Trichloroethane) буюу Метилхлороформ - (Methyl chloroform) (Протоколын Зүйл 2E)						

Олон улсын нэршил (ОЗЧ)	Химийн нэршил	Томьёо	БТКУС-ийн код	ASHRAE #	Хөгжингүй орны амлалт	Протоколын 5 дугаар зүйлд хамаарах хөгжиж буй орны амлалт
1,1,1-trichloro ethane буюу methyl chloroform (0.1)	Метилхлороформ	$C_2H_3Cl_3$	2903.19.10	R-140a	1994: 50% ↓ 1996: (хх)	2005: 30% ↓ 2010: 70% ↓ 2015: (үз/хх)
Хавсралт С: Хяналтад орсон бодисууд (Controlled Substances) I бүлэг (Group I): Гидрохлорфторт нүүрстөрөгч (Hydrochlorofluorocarbons) (Протоколын Зүйл 2F)						
Энэ бүлэгт 40 нэрийн Гидрохлорфторт нүүрстөрөгч (Hydrochlorofluorocarbons) орно. Эдгээр нь CFC бодисын орлуулагч бөгөөд HCFC-22, HCFC-123, HCFC-124, HCFC-141, HCFC-141b, HCFC-142, HCFC-142b г.м.-ээр нэрлэгдэнэ. ОЗЧ нь 0.001-0.52 хооронд байна.			2903.49.10	R- 22 R- 123 R- 124 R- 141b R- 142b г.м.	2004: 35% ↓ 2010: 65% ↓ 2015: 90% ↓ 2030: (зүз)	2016: (үз) 2040: (хх)
II бүлэг (Group II): Гидробромфторт нүүрстөрөгч (Hydrobromofluorocarbons) (Протоколын Зүйл 2G)						
(HBFC-22B1) (0.1 - 14.0)	Бромдифторметан (Энэ бүлэгт 34 нэрийн HBFC хэмээх бодис орсон)	CHF_2Br	2903.49.20		1996: (хх)	1996: (үз/хх)
III бүлэг (Group III): Бромтхлорт метан (Bromochloromethane) (Протоколын Зүйл 2I)						
Bromo chloro methane (0.12)	Бромтхлортметан	CH_2BrCl	2903.49.10		2002: (хх)	2002: (үз/хх)
Хавсралт Е: Хяналтанд орсон бодисууд (Controlled Substances) I бүлэг (Group I): Метил бромид (Methyl bromide) (Протоколын Зүйл 2H)						
methyl bromide буюу bromo methane (0.6)	Бромт метил	CH_2BrCl	2903.30.10		1999: 25% ↓ 2001: 50% ↓ 2004: 75% ↓ 2005: (хх)	2005: 20% ↓ 2015: (үз/хх)

Тайлбар:

- ОЗЧ - озон задлах чадвар (ozone-depleting potential).
ОЗЧ-ыг тогтмол хугацаанд хянан үзэж, өөрчилдөг.
- ↓ - үйлдвэрлэл, хэрэглээг бууруулах
- (хх) - хэрэглээнээс хасах
- (үз) - үйлдвэрлэлийг зогсоох
- (зүз) - хөргөх болон агааржуулах хэрэгслийн засвар, үйлчилгээг зогсоох
- ASHRAE - The American Society of Heating, Refrigerating and Air-Conditioning Engineers
(Халаалт, хөргөлт, агааржуулалтын инженерийн Америкийн холбоо)

Протоколын Хавсралт D*:

Хүснэгт 21. Монреалийн Протоколын Хавсралт D* Хавсралт А-д заасан бодис агуулдаг бүтээгдэхүүний** жагсаалт:

Бүтээгдэхүүн	Product	Гаалийн ангиллын код (Customs Code Number)
1. Суудлын болон ачааны автомашины агааржуулалтын систем (автомашинд суурилуулсан эсэхээс үл хамаарна)	1. Automobile and truck air conditioning units (whether incorporated in vehicles or not)	
2. Гэр ахуйн болон худалдааны зориулалттай хөргөлт, агааржуулалт, халаалтын насосон хэрэгсэл***: Жнь: Хөргөгч Хөлдөөгч Чий шингээгч Ус хөргөгч Мөсний машин Агааржуулагч, халаагч насос	2. Domestic and commercial refrigeration and air conditioning/heat pump equipment***: e.g. Refrigerators Freezers Dehumidifiers Water coolers Ice machines Air conditioning and heat pump Units	
3. Шүршигч (Эмнэлгийн зориулалттай шүрхэгч үүнд хамаарахгүй)	3. Aerosol products, except medical aerosols	
4. Гал сөнөөгч зөөврийн хэрэгсэл	4. Portable fire extinguisher	
5. Тусгаарлагч хавтан, төмөр хоолойн дулаалга	5. Insulation boards, panels and pipe covers	
6. Хөөсөнцрийн түүхий эд	6. Pre-polymers	

* Хэлэлцэн тохирогч Талууд энэ Хавсралтыг Протоколын 4 дүгээр зүйлийн 3-т заасан шаардлагын дагуу 1991 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Наироби хотод хуралдсан 3 дугаар хуралдаанаараа баталсан.

** Хувийн хэрэглээний бараа буюу гэр ахуйн хэрэгсэл бүхий ачаа тээшинд байгаа бүтээгдэхүүн, эсхүл түүнтэй ижилтгэх арилжааны бус шинжтэй бүтээгдэхүүн ерөнхийдөө гаалийн байгууллагын хараа хяналтанд байна.

*** Хавсралт А-аар хяналтанд орсон бодисууд хөргөгч, мөн/эсхүл тухайн бүтээгдэхүүний дулаан хадгалах, дуу чимээ тусгаарлах материалд агуулагдсан тохиолдолд.

Монреалийн Протоколын хэрэгжилтийн өнөөгийн байдал

Олон улсын тавцан дээр Монреалийн Протоколыг хамгийн амжилттай хэрэгжиж байгаа олон улсын гэрээ гэж дүгнэдэг. Озоны давхаргад сөргөөр нөлөөлж буй бодисын үйлдвэрлэл, хэрэглээг зохистой хэмжээнд бууруулж чадсан нь хүн төрөлхтний агуу их ололт амжилт юм. Ийнхүү үр дүнд хүрсэн амжилтын үндэс нь уг Протоколд нэгдэн орсон талуудын нягт хамтын ажиллагаа зайлшгүй мөн билээ. Хавсралт AI, AII, BI, BII, CII, CIII-д 2011 оны байдлаар орсон бодисын хэрэглээг бүрэн зогсоосны зэрэгцээ эдгээр бодисын экспорт, импортыг хориглосон гэсэн ойлголттой байгаа.

Озон задалдаг бодис нь зөвхөн озоны давхаргад сөргөөр нөлөөлөөд зогсохгүй хүлэмжийн хий үүсгэж агаарын дулааралд шууд нөлөөлж байгааг эрдэмтэд тогтоожээ. Манай

орны тухайд гэвэл: Монгол Улс гишүүний хувьд авсан амлалтаа амжилттай биелүүлж байгаа. Манайд гол төлөв Озон задалдаг бодисыг хөргөх төхөөрөмж цэнэглэх, машины болон тасалгааны агааржуулагчид ашигладаг. Сүүлийн үед хуванцрын түүхий эдийн зориулалтаар оруулах болсон. 2011 онд дараах төрлийн бодисыг импортлох зөвшөөрөл олгоод байна: R22, R404A, R410A, R600a, R134A, R407C, R406, R507.

Сүүлийн үеийн хандлагыг ажиглахад ОЗБодисыг орлох, хүрээлэн буй орчинд хоргүй бодис нээх эрэл хайгуулын ажил эрчимтэй явагдаж байгаа. Нэг жишээ дурдахад: R22 бодисыг орлогч R134A гэгч бодисыг нээсэн нь озон задлах чадвараар бага хэдий ч дулаарлын потенциал нь R22-ынхоос 1600 дахин их байгааг эрдэмтэд нотолжээ. Иймээс цаашид шинэ нэр төрлийн аюулгүй бодис нээх шаардлага тулгараад байна.



20. Аюултай хог хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенц (Базелийн Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	The Basel Convention on the Control of Transboundary Movements of Hazardous Wastes and Their Disposal (The Basel Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Базельская Конвенция о контроле за трансграничной перевозкой опасных отходов и их удалением (Базельская Конвенция)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	1989-03-22. Швейцарь Улсын Базел хот (Basel, Switzerland)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1992-05-05
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 186
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1996-12-05
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1997-04-15
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1997-07-14
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	<ul style="list-style-type: none"> - Хавсралт I-ийн төгсгөлд (a), (b), (c), (d) гэсэн 4 заалтыг Талуудын Бага хурлын 4 дугаар хуралдаанаар баталж нэмсэн нь 1998 оны 11 дүгээр сарын 6-нд хүчин төгөлдөр болсон . - Хавсралт VII-г Талуудын Бага хурлын 3 дугаар хуралдаанаар (1995 онд) баталж нэмсэн нь хүчин төгөлдөр болоогүй байна. - Хавсралт VIII-г Талуудын Бага хурлын 4 дугаар хуралдаанаар баталж нэмсэн нь 1998 оны 11 дүгээр сарын 6-нд хүчин төгөлдөр болсон. Энэ хавсралтад 6, 7 дугаар хуралдаанаар дахин хоёр нэмэлт оруулсан нь 2003 оны 11 дүгээр сарын 20, 2005 оны 10 дугаар сарын 8-ны өдрүүдэд тус тус хүчин төгөлдөр болсон. - Хавсралт IX-г Талуудын Бага хурлын 4 дугаар хуралдаанаар баталж нэмсэн нь 1998 оны 11 дүгээр сарын 6-нд хүчин төгөлдөр болсон. Энэ хавсралтад 6, 7 дугаар хуралдаанаар дахин хоёр нэмэлт оруулсан нь 2003 оны 11 дүгээр сарын 20, 2005 оны 10 дугаар сарын 8-ны өдрүүдэд тус тус хүчин төгөлдөр болсон.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	<ul style="list-style-type: none"> - Конвенц соёрхон батлах тухай 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хууль

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Уг Конвенц нь хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах үүднээс улс хооронд тээвэрлэж буй аюултай хог хаягдал (хорт хаягдал)-ын хөдөлгөөнийг, ялангуяа хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнууд руу чиглэн шилжих хөдөлгөөнийг багасгах зорилготой. Мөн хорт хаягдлын хэмжээ, хорыг багасгах, энэ чиглэлээр хөгжиж буй орнуудад туслалцаа үзүүлэх зорилготой.

Конвенцийн бүтэц:

1 дүгээр зүйл. Конвенцийн үйлчлэх хүрээ (Scope of the Convention): Хавсралт I болон Хавсралт III-т хамаарах хаягдал, мөн эдгээр хавсралтад хамаарахгүй боловч экспортлогч, импортлогч, эсхүл дамжуулан өнгөрүүлэгч улсын дотоодын хууль тогтоомжоор хорт хаягдал гэж үзэх хаягдлыг хил давуулан тээвэрлэх хөдөлгөөн хамаарна. Харин энэ Конвенцид радио идэвхт бодисын хөдөлгөөн зэрэг өөр бусад олон улсын Конвенцоор зохицуулагдсан харилцаа хамааралгүй болно.

2 дугаар зүйл. Тодорхойлолт (Definitions): Зарим нэг тодорхойлолтоос дурдвал:

- “хаягдал” (wastes) гэдэгт үндэсний хууль тогтоомжоор захиран зарцуулах, захиран зарцуулах гэж байгаа, эсхүл захиран зарцуулах ёстой бодис, объектийг ойлгоно;
- “Хил дамнасан хөдөлгөөн/хил давуулан тээвэрлэх” (transboundary movement) гэдэгт хорт хаягдал, эсхүл бусад хаягдлыг нэг Улсын харьяанд байдаг нутаг дэвсгэрээс нөгөө Улсын харьяаны нутаг дэвсгэр рүү чиглэсэн, эсхүл түүгээр дамжих, эсхүл аливаа нэг Улсын харьяалалгүй нутаг дэвсгэр рүү чиглэсэн, эсхүл түүгээр дамжих хөдөлгөөнийг ойлгоно. Гэхдээ, уг хөдөлгөөнд наад зах нь хоёр Улс хамааралтай байна;
- “захиран зарцуулах/зайлуулах” (disposal) гэдэгт Конвенцийн Хавсралт IV-т заасан аливаа ажиллагааг ойлгоно;
- “үйлдвэрлэгч” (generator) гэдэгт хорт хаягдал, эсхүл бусад хаягдал үйлдвэрлэгч этгээдийг ойлгоно. Хэрэв тэр нь тодорхойгүй бол тэдгээр хаягдлыг эзэмшиж байгаа, мөн/эсхүл хяналтандаа байлгаж байгаа этгээдийг ойлгоно;
- “хууль бус хөдөлгөөн” (illegal traffic) гэдэгт хорт хаягдал, эсхүл бусад бусад хаягдлын 9 дүгээр зүйлд заасан хил дамнасан хөдөлгөөнийг ойлгоно.

3 дугаар зүйл. Хорт хаягдлын үндэсний тодорхойлолт (National Definitions of Hazardous Wastes): Талууд Хавсралт I болон III-т заагдаагүй хорт хаягдлын асуудлыг зохицуулсан үндэсний хууль тогтоомж, тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийн талаар Конвенцийн Нарийн бичгийн даргын газарт хүргүүлнэ.

4 дүгээр зүйл. Нийтлэг үүрэг (General Obligations): Зарим нэг үүргээс дурдвал:

- хорт хаягдал, эсхүл бусад хаягдал импортлохыг хориглосон тухай бусад Улсуудад (Конвенцийн Нарийн бичгийн даргын газраар дамжуулан) 13 дугаар зүйлийн дагуу мэдэгдэх;
- хаягдал импортлохыг хориглосон тухайгаа тийнхүү мэдэгдсэн Улс руу хаягдал экспортлохыг хориглох, эсхүл экспортлохыг үл зөвшөөрөх. Импортыг хориглоогүй ч гэсэн нөгөө Улс тийнхүү импортлохыг бичгээр зөвшөөрөөгүй бол уг Улс руу экспортлохыг хориглох, эсхүл үл зөвшөөрөх;
- хорт хаягдал, эсхүл бусад хаягдлыг Хэлэлцэн тохирогч Тал биш Улс руу экспортлох, эсхүл тэндээс импортлохыг хориглох;
- хил дамнасан хөдөлгөөнд хамаарах хорт хаягдал, эсхүл бусад хаягдлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн дүрэм, стандарт, практикийн дагуу савлаж, шошголож, тээвэрлэх
- хил дамнасан хөдөлгөөнийг уг хөдөлгөөн эхлэхээс захиран зарцуулах газар хүртэл холбогдох тээврийн бичиг баримт дагалдана.

5 дугаар зүйл. Эрх бүхий нэг буюу хэд хэдэн байгууллага (Засаг захиргаа), мөн үндэсний мэдээллийн нэг байгууллагыг томилох (Designation of Competent Authorities and Focal Point): Дамжин өнгөрөх Улсад мэдэгдэл хүлээн авах эрх бүхий нэг байгууллага байна.

6 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондох хил дамнасан хөдөлгөөн (Transboundary Movement between Parties).

7 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч Талаас Хэлэлцэн тохирогч Тал бус Улсын нутаг дэвсгэрээр дамжих хил дамнасан хөдөлгөөн (Transboundary Movement from a Party through States which are not Parties).

8 дугаар зүйл. Буцаан оруулах үүрэг (Duty to Re-import)

9 дүгээр зүйл. Хууль бус зөөвөр (Illegal Traffic): Хил дамнасан тээвэр нь дараах тохиолдолд хууль бус болно:

- энэ Конвенцийн дагуу холбогдох бүх Улсуудад мэдэгдээгүй
- энэ Конвенцийн дагуу холбогдох Улсаас зөвшөөрөл аваагүй
- холбогдох Улсаас луйврийн замаар зөвшөөрөл авсан
- материаллаг талаасаа бичиг баримтад дурдсантай таарч тохирохгүй байх
- хил дамнуулан тээвэрлэсэн хорт хаягдал, эсхүл бусад хаягдлыг энэ Конвенц болон олон улсын эрх зүйн нийтлэг зарчмыг зөрчин зориудаар захиран зарцуулсан (жнь: хог хаягдлаа албаар асгасан).

Дээрх тохиолдлуудад болж өгвөл холбогдох хорт хаягдал, эсхүл бусад хаягдлыг экспортлогч Улс руу нь буцаана.

- | | |
|-----------------|--|
| 10 дугаар зүйл. | Олон улсын хамтын ажиллагаа (International Co-operation) |
| 11 дүгээр зүйл. | Хоёр талт, олон талт болон бүс нутгийн Хэлэлцээрүүд (Bilateral, Multilateral and Regional Agreements): Талууд энэ Конвенцийн 4.5-д заасныг үл харгалзан хоёр талт, олон талт, эсхүл бүс нутгийн Хэлэлцээр байгуулж болно. Тэдгээрт энэ Конвенцид зааснаас дутуугуй нөхцлийг заана. |
| 12 дугаар зүйл. | Үүрэг хариуцлагын талаар зөвлөлдөх (Consultations on Liability) |
| 13 дугаар зүйл. | Мэдээлэл дамжуулах (Transmission of Information) |
| 14 дүгээр зүйл. | Санхүүгийн асуудал (Financial Aspects) |
| 15 дугаар зүйл. | Талуудын Бага хурал (Conference of the Parties): Уг Бага хурал энэ Конвенцоор байгуулагдсан. |
| 16 дугаар зүйл. | Нарийн бичгийн даргын газар (Secretariat) 17 дугаар зүйл. Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулах (Amendment of the Convention) |
| 18 дугаар зүйл. | Хавсралтуудыг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах (Adoption and Amendment of Annexes): 17 дугаар зүйлийн 2, 3, 4-т заасны дагуу явагдана. Хавсралтууд нь Конвенцийн салшгүй хэсэг болно. |
| 19 дүгээр зүйл. | Энэ Конвенцид заасан үүргээ биелүүлэхгүй байгаа байдлыг Нарийн бичгийн даргын газарт мэдэгдэж, шалгуулах (Verification) |
| 20 дугаар зүйл. | Маргаан шийдвэрлэх (Settlement of Disputes) |
| 21 дүгээр зүйл. | Гарын үсэг зурахад нээлттэй байх хугацаа (Signature) |
| 22 дугаар зүйл. | Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, албан ёсоор нотлох буюу сайшаан дэмжих (Ratification, Acceptance, Formal Confirmation or Approval) |
| 23 дугаар зүйл. | Конвенцид нэгдэн орох (Accession) |
| 24 дүгээр зүйл. | Санал өгөх эрх (Right to Vote): Хэлэлцэн тохирогч Улсууд тус бүрдээ саналын нэг эрхтэй байна. Харин улс төр, эдийн засгийн цогц байгууллага энэ Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох өөрийн Гишүүн орнуудын тоотой тэнцэх саналын эрхтэй байна (Гишүүд нь тусдаа санал өгөөгүй тохиолдолд). Гишүүд нь тусдаа саналаа өгвөл холбогдох байгууллага саналын эрхгүй болно. |
| 25 дугаар зүйл. | Конвенц хүчин төгөлдөр болох (Entry into Force) |
| 26 дугаар зүйл. | Конвенцид тайлбар хийх, тунхаглал, мэдэгдэл гаргах (Reservations and Declarations): Энэ Конвенцийн аль ч заалтад тайлбар хийхгүй. Харин Конвенцийн заалтад хохирол учруулалгүйгээр тунхаглал, мэдэгдэл хийж болно. |
| 27 дугаар зүйл. | Конвенц дагаж мөрдөх явдлыг цуцлах (Withdrawal) |
| 28 дугаар зүйл. | Конвенцийн эх хадгалагч (Depositary) |
| 29 дүгээр зүйл. | Аль ч хэл дээр үйлдсэн эх хувь ижил хүчинтэй байна. (Authentic texts) |

Хавсралтууд:

Хавсралт I: Хяналтад байх хог хаягдлын ангилал (Categories of wastes to be controlled)

Хог хаягдал (Waste Streams)

- Y1. Клиник, поликлиник болон бусад нэгдсэн эмнэлгээс өвчтөнг эмчлэх, сувилах явцад гарах хаягдал (Clinical wastes from medical care in hospitals, medical centers and clinics)

- Y2. Эмийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах болон үйлдвэрлэснээс гарах хаягдал (Wastes from the production and preparation of pharmaceutical products)
- Y3. Хэрэгцээгүй болсон эм бэлдмэл болон эмийн бүтээгдэхүүн (Waste pharmaceuticals, drugs and medicines)
- Y4. Биологийн болон ургамлын гаралтай бэлдмэл үйлдвэрлэх, хэрэглэснээс гарах хаягдал (Wastes from the production, formulation and use of biocides and phytopharmaceuticals)
- Y5. Модны үйлдвэрт хэрэглэх химийн бодисыг үйлдвэрлэх, болон түүний хэрэглээнээс гарах хаягдал (Wastes from the manufacture, formulation and use of wood preserving chemicals)
- Y6. Органик уусгагчийг хэрэглэдэг болон гарган авдаг үйлдвэрийн хаягдал (Wastes from the production, formulation and use of organic solvents)
- Y7. Цианид агуулсан материалыг цэвэрлэх болон дулааны боловсруулалтаас гарах хаягдал (Wastes from heat treatment and tempering operations containing cyanides)
- Y8. Хэрэгцээгүй болсон буюу хэрэглэхэд тохиромжгүй эрдэс тос (Waste mineral oils unfit for their originally intended use)
- Y9. Тос-ус, нүүрс-устөрөгч-усны хольц болон эмульс байдалтай хаягдал (Waste oils/water, hydrocarbons/water mixtures, emulsions)
- Y10. Олон хлорт бифенил, олон хлорт терфенил, олон хлорт бромт бифенил болон тэдгээрийн хольцыг агуулсан хэрэгцээгүй болсон бодис, бүтээгдэхүүн (Waste substances and articles containing or contaminated with polychlorinated biphenyls (PCBs) and/or polychlorinated terphenyls (PCTs) and/or polybrominated biphenyls (PBBs))
- Y11. Нэрэх, цэвэрлэх болон бусад пиролизын боловсруулалтын явцад үүсэх хэрэгцээгүй болсон давирхайлаг хаягдал (Waste tarry residues arising from refining, distillation and any pyrolytic treatment)
- Y12. Будаг, лак, маажин, пигмент, бэх хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал (Wastes from production, formulation and use of inks, dyes, pigments, paints, lacquers, varnish)
- Y13. Нийлэг давирхай, каучук, уяруулагч, цавуу, холбогч бодис зэргийг хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал (Wastes from production, formulation and use of resins, latex, plasticizers, glues/adhesives)
- Y14. Эрдэм шинжилгээ, сургалтын явцад буй болсон, шинж чанар нь судлагдаагүй, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хэрхэн нөлөөлөх нь тогтоогдоогүй, хэрэгцээгүй болсон химийн бодис (Waste chemical substances arising from research and development or teaching activities which are not identified and/or are new and whose effects on man and/or the environment are not known)
- Y15. Бусад хууль тогтоомжоор зохицуулагдахгүй тэсрэх аюул бүхий бодисын хаягдал (Wastes of an explosive nature not subject to other legislation)
- Y16. Фотоматериал боловсруулах зориулалттай фотохимийн бодис, материалыг хэрэглэдэг болон тэдгээрийг гарган авдаг үйлдвэрийн хаягдал (Wastes from production, formulation and use of photographic chemicals and processing materials)
- Y17. Металл болон пласмасс боловсруулалтаас гарсан хаягдал (Wastes resulting from surface treatment of metals and plastics)
- Y18. Үйлдвэрийн хаягдлыг зайлуулснаас гарах үлдэгдэл (Residues arising from industrial waste disposal operations)

Дараах бодис, нэгдлийг агуулсан хог хаягдал (Wastes having as constituents):

- Y19. Металлын карбонил нэгдлүүд (Metal carbonyls)
- Y20. Бериллий, түүний нэгдлүүд (Beryllium; beryllium compounds)
- Y21. 6 валенттай хромын нэгдлүүд (Hexavalent chromium compounds)
- Y22. Зэсийн нэгдлүүд (Copper compounds)
- Y23. Цайрын нэгдлүүд (Zinc compounds)
- Y24. Хүнцэл, түүний нэгдлүүд (Arsenic; arsenic compounds)
- Y25. Селен, түүний нэгдлүүд (Selenium; selenium compounds)

- Y26. Кадмий, түүний нэгдлүүд (Cadmium; cadmium compounds)
- Y27. Сурьма, түүний нэгдлүүд (Antimony; antimony compounds)
- Y28. Теллур, түүний нэгдлүүд (Tellurium; tellurium compounds)
- Y29. Мөнгөн ус, түүний нэгдлүүд (Mercury; mercury compounds)
- Y30. Таллий, түүний нэгдлүүд (Thallium; thallium compounds)
- Y31. Хар тугалга, түүний нэгдлүүд (Lead; lead compounds)
- Y32. Фторт кальциас бусад фторын органик бус нэгдлүүд (Inorganic fluorine compounds excluding calcium fluoride)
- Y33. Органик бус цианидууд (Inorganic cyanides)
- Y34. Шингэн буюу хатуу хүчлүүд (Acidic solutions or acids in solid form)
- Y35. Шүлтийн нэгдлүүд ба хатуу сууриуд (Basic solutions or bases in solid form)
- Y36. Асбест (нунтаг, ширхэглэг) (Asbestos (dust and fibres))
- Y37. Фосфорын органик нэгдлүүд (Organic phosphorus compounds)
- Y38. Органик цианидууд (Organic cyanides)
- Y39. Фенол, фенолын нэгдлүүд, хлорфенолууд (Phenols; phenol compounds including chlorophenols)
- Y40. Эфирүүд (Ethers)
- Y41. Галогенжуулсан органик уусгагчууд (Halogenated organic solvents)
- Y42. Галогенжуулснаас бусад органик уусгагчууд (Organic solvents excluding halogenated solvents)
- Y43. Дибензфураны төрлийн бүх материал (Any congener of polychlorinated dibenzo-furan)
- Y44. Полихлордибензопидиоксины төрлийн бүх материал (Any congener of polychlorinated dibenzo-p-dioxin)
- Y45. Энэ хавсралтад заасан (тухайлбал, Y39, Y41, Y42, Y43, Y44-т заасан) бодисуудаас бусад органик галогент нэгдлүүд (Organohalogen compounds other than substances referred to in this

(Дараах дөрвөн заалт 1998 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон)

- (a) Энэ Конвенцийг мөрдөхөд тус дөхөм болох үүднээс, мөн дор дурдсан (b), (c), (d)-д заасныг харгалзан, Хавсралт VIII-д жагсаасан хог хаягдлыг энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (a)-д зааснаар аюултай гэж үзнэ. Харин Хавсралт IX-д жагсаасан хог хаягдал энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (a)-д хамаарахгүй.
- (b) Аливаа хог хаягдлыг Хавсралт VIII-д оруулах нь тодорхой тохиолдолд аливаа хог хаягдал энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (a)-д зааснаар аюултай биш болохыг нотлон харуулах зорилгоор Хавсралт III-г ашиглахад саад болохгүй.
- (c) Аливаа хог хаягдлыг Хавсралт IX-д оруулах нь тодорхой тохиолдолд аливаа хог хаягдал Хавсралт III-т заасан шинж чанарыг илэрхийлэх хэмжээгээр Хавсралт I-д заасан материал агуулж байвал түүнийг энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (a)-д зааснаар аюултай гэж тодорхойлоход саад болохгүй.
- (d) Хавсралт VIII болон IX нь хог хаягдлын шинж чанарыг тодорхойлох зорилгоор энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (a) заалтыг мөрдөхөд нөлөө үзүүлэхгүй.

Хавсралт II: Онцгойлон авч үзэх хаягдлын ангилал (Categories of wastes requiring special consideration)

- Y46. Ахуйн хог хаягдал (Wastes collected from households)
- Y47. Ахуйн хог хаягдлыг шатааснаас гарах үлдэгдэл (Residues arising from the incineration of household wastes)

Хавсралт III: Аюултай шинж чанарын жагсаалт (List of hazardous characteristics)

НҮБ-ын ангилал	Код	Шинж чанар (Characteristics)
1	H1	Тэсрэх бодис (Explosive) Тэсрэх бодис буюу хаягдал. Температур, даралт, хурдны нөлөөгөөр химийн урвалд орж өөрөө тэсэрч орчны юмсыг гэмтээдэг хатуу, шингэн байдалтай бодис буюу хаягдлууд
3	H3	Галын аюултай шингэнүүд (Flammable liquids) “Галын аюултай” гэдэг нь “хялбар шатамхай” гэсэнтэй ижил утгатай. Галын аюултай шингэн гэдэг нь уусмал буюу суспензид /будаж, лак г.м/ аюултай шинж чанар бүхий хатуу бодисыг агуулсан, задгай саванд 60.5-аас дээш хэмд, битүү саванд 65.6-аас дээш хэмд галын аюултай уур ялгаруулдаг, аюултай шинж чанараар нь ангилсан бодис буюу хаягдлаас бусад шингэн болон шингэний хольцууд.
4.1	H4.1	Галд аюултай хатуу бодисууд (Flammable solids) Тэсрэх бодисын ангилалд хамаарагдахгүй, тээвэрлэх үед үрэлтээс гал авалцаж хялбархан асдаг хатуу бодис буюу хатуу хаягдлууд.
4.2	H4.2	Өөрөө шатдаг бодис буюу хаягдлууд (Substances or wastes liable to spontaneous combustion) Ердийн нөхцөлд тээвэрлэхэд өөрөө халдаг буюу агаартай шүргэлцэхэд халж өөрөө шатдаг бодис буюу хаягдлууд
4.3	H4.3	Устай харилцан үйлчилж галын аюултай хий ялгаруулдаг бодис буюу хаягдлууд (Substances or wastes which, in contact with water emit flammable gases) Устай харилцан үйлчлэхэд өөрөө шатамхай болон хялбар шатамхай хийг аюул учруулах хэмжээгээр ялгаруулдаг бодис буюу хаягдлууд
5.1	H5.1	Исэлдүүлэгч бодисууд (Oxidizing Substances) Өөрөө заавал шатдаг бус, харин хүчилтөрөгчийг ялгаруулж бусад материалын шаталтыг тэтгэдэг бодисууд
5.2	H5.2	Органик хэт ислүүд (Organic Peroxides) Хоёр валенттай бүлэг (-O-O-) -ийг агуулсан дулаанд тэсвэргүй буюу дулаан ялгаруулах урвалд орж өөрөө түргэн задардаг шим бодисууд
6.1	H6.1	Хортой бодисууд (Poisonous (Acute) Substances) Амьсгалын зам, хоол боловсруулах эрхтэн, арьсаар дамжин хүний организмд орвол үхэлд хүргэх буюу хүчтэй хордуулдаг бодис буюу хаягдлууд
6.2	H6.2	Халдвартай бодисууд (Infectious substances) Амьд бичил биет буюу тэдгээрийн хорыг агуулсан хүн, амьтанд өвчин үүсгэдэг бодис буюу хаягдлууд
8	H8	Идэмхий бодисууд (Corrosives) Химийн үйлчлэл шууд харилцан явагдсанаас болж амьд эд эсэд хүчтэй гэмтэл үүсгэдэг, гоожих болон асгарч алдагдахад бусад ачаа, тээврийн хэрэгслийг гэмтээдэг бодис буюу хаягдлууд
9	H.10	Агаар, устай харилцан үйлчилснээс хортой хий ялгаруулдаг бодисууд (Liberation of toxic gases in contact with air or water) Агаар, устай харилцан үйлчилснээс аюул учруулах хэмжээний хортой хий ялгаруулдаг бодис буюу хаягдлууд
9	H11	Хортой бодисууд (архаг өвчин үүсгэх) (Toxic (Delayed or chronic)) Амьсгалын зам, хоол боловсруулах эрхтэн, арьс салстаар дамжин хүний организмд ороход архаг өвчин үүсгэж улмаар хорт хавдар үүсгэх бодис буюу хаягдлууд
9	H12	Экологт хортой бодисууд (Ecotoxic) Хүрээлэн буй орчинд байх тохиолдолд хоромхон зуур биоидэвх үүсгэж аюул учруулдаг буюу биосистемд хортой нөлөөлөл үзүүлдэг бодис буюу хаягдлууд
9	H13	Зайлуулсны дараа ямар нэг байдлаар (жнь: шүлтлэг болох г.м) дээрх шинж чанарыг агуулсан бусад материалыг үүсгэдэг бодисууд

ШАЛГУУР

Зарим төрлийн хаягдлын аюулын тодорхойлолт нь бүрэн гүйцэд баримтжаагүй, аюулын хэмжээг нь тооцоолон үнэлэх арга зүй одоогоор байхгүй байна. Эдгээр бодисоос хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулж болзошгүй аюулыг судлах арга зүйг боловсруулах шаардлагатай байна. Стандарт шалгуурын аргуудыг цэвэр бодис, материалд зориулан боловсруулсан байдаг. Олонхи гишүүн орнуудад нэгдүгээр хавсралтад заасан хаягдлуудын шинж чанарыг тодорхойлоход хэрэглэх үндэсний шалгуурын арга зүйг боловсруулсан байна.

Хавсралт IV: Захиран зарцуулах/зайлуулах ажиллагаа (Disposal operations)

А. Хог хаягдлыг цэвэршүүлэх, дахин боловсруулах, сэргээн засах, шууд дахин хэрэглэх, эсхүл өөр бусад байдлаар хэрэглэх явдлыг боломжгүй болгох ажиллагаа (A. Operations which do not lead to the possibility of resource recovery, recycling, reclamation, direct re-use or alternative uses)

А хэсэгт хаягдал зайлуулах практикт тохиолдож буй бүх төрлийн ажиллагаа орно.

D1	Газарт (жнь: хогийн цэгт, г.м.) булшлах буюу асгах	Deposit into or onto land, (e.g., landfill, etc.)
D2	Хөрс боловсруулах (жнь: хөрсөн дахь шингэн буюу лаг зэрэг хаягдлыг биохимийн аргаар задлах г.м)	Land treatment, (e.g., biodegradation of liquid or sludgy discards in soils, etc.)
D3	Газрын гүнд хаях (өрөмдлөгийн цооног, байгалийн тогтоц бүхий гүн хонгил, нүхэнд г. м.)	Deep injection, (e.g., injection of pumpable discards into wells, salt domes of naturally occurring repositories, etc.)
D4	Ил задгай усанд хаях (шингэн ба лаг шаварлаг хаягдлыг цөөрөм, тунгаах усан сан г.м)	Surface impoundment, (e.g., placement of liquid or sludge discards into pits, ponds or lagoons, etc.)
D5	Тусгай тоногдсон хогийн цэгт хаях (хүрээлэн буй орчноос нь болон өөр хооронд нь тусгайлах, хамгаалалт хашилт хийх, бүтээх г.м)	Specially engineered landfill, (e.g., placement into lined discrete cells which are capped and isolated from one another and the environment, etc.)
D6	Тэнгис, далайгаас бусад усан санд хаях	Release into a water body except seas/oceans
D7	Тэнгис, далайд хаях, далайн ёроолд булшлах	Release into seas/oceans including sea-bed insertion
D8	Энэ хавсралтын бусад хэсэгт дурдаагүй, биологийн боловсруулалт хийсэн эцсийн нэгдэл буюу хольцыг А хэсэгт дурдсан аль нэг аргаар зайлуулах	Biological treatment not specified elsewhere in this Annex which results in final compounds or mixtures which are discarded by means of any of the operations in Section A
D9	Энэ хавсралтын бусад хэсэгт дурдаагүй, физик-химийн боловсруулалт хийсэн эцсийн нэгдэл буюу хольцыг А хэсэгт дурдсан аль нэг аргаар зайлуулах (ууршуулах, хатаах, шатаах, саармагжуулах, тунадасжуулах г.м)	Physico chemical treatment not specified elsewhere in this Annex which results in final compounds or mixtures which are discarded by means of any of the operations in Section A, (e.g., evaporation, drying, calcination, neutralization, precipitation, etc.)
D10	Хуурай газарт шатаах	Incineration on land
D11	Тэнгист шатаах	Incineration at sea
D12	Булшлах (чингэлгийг уурхайд булшлах г.м)	Permanent storage (e.g., emplacement of containers in a mine, etc.)
D13	А хэсэгт дурдсан аливаа ажиллагааг эхлэхийн өмнө нэг төрлийн буюу нэг төрлийн бус хольцыг гарган авах	Blending or mixing prior to submission to any of the operations in Section A
D14	А хэсэгт дурдсан ажиллагааг эхлэхийн өмнө дахин боох буюу савлах	Repackaging prior to submission to any of the operations in Section A
D15	А хэсэгт дурдсан ажиллагааг хүлээж хадгалах	Storage pending any of the operations in Section A

В. Хог хаягдлыг цэвэршүүлэх, дахин боловсруулах, сэргээн засах, шууд дахин хэрэглэх, эсхүл өөр бусад байдлаар хэрэглэх боломжтой ажиллагаа

(B. Operations which may lead to resource recovery, recycling reclamation, direct re-use or alternative uses)

В хэсэгт аюултай хог хаягдал буюу аюултай гэж үзэж хууль эрхийн хүрээнд тодорхойлогдсон материалуудтай харьцах бүх төрлийн ажиллагаа хамрагдах бөгөөд А хэсэгт дурдсан үйл ажиллагааны эсрэг тохиолдолд хэрэглэнэ.

R1	Түлшний хэлбэрээр (шууд шатахаас бусад) буюу эрчим хүчийг гарган авах бусад хэлбэрээр ашиглах	Use as a fuel (other than in direct incineration) or other means to generate energy
R2	Уусгагчийг сэргээн ашиглах/ангиржуулах	Solvent reclamation/regeneration
R3	Уусгагч байдлаар ашиглагдахгүй органик бодисуудыг дахин боловсруулах/сэргээн ашиглах	Recycling/reclamation of organic substances which are not used as solvents
R4	Металлууд болон тэдгээрийн нэгдлүүдийг дахин боловсруулах/сэргээн ашиглах	Recycling/reclamation of metals and metal compounds
R5	Органик бус бусад материалыг дахин боловсруулах/сэргээн ашиглах	Recycling/reclamation of other inorganic materials
R6	Хүчил, шүлтийг ангиржуулах	Regeneration of acids or bases
R7	Бохирдлыг арилгахад хэрэглэдэг бодисуудыг давтан ашиглах	Recovery of components used for pollution abatement
R8	Катализаторуудыг давтан ашиглах	Recovery of components from catalysts
R9	Нефтийн бүтээгдэхүүнийг дахин нэрэх, урьд ашиглагдсан нефтийн бүтээгдэхүүнийг өөр байдлаар дахин ашиглах	Used oil re-refining or other reuses of previously used oil
R10	Газар тариаланд аятай нөлөөлөх буюу экологийн нөхцөл байдлыг сайжруулах үүднээс хөрсийг боловсруулах	Land treatment resulting in benefit to agriculture or ecological improvement
R11	R1-R10-д заасан аль нэг ажиллагаанаас гарсан хаягдлыг ашиглах	Uses of residual materials obtained from any of the operations numbered R1-R10
R12	R1- R11-д заасан аль нэг ажиллагаанд оруулах хаягдлыг солилцох	Exchange of wastes for submission to any of the operations numbered R1-R11
R13	В хэсэгт заасан ажиллагаанд ашиглах материалыг хуримтлуулах	Accumulation of material intended for any operation in Section B

Хавсралт V А: Мэдэгдэлд байвал зохих мэдээлэл (Information to be provided on notification)

1.	Хаягдал экспортлох шалтгаан	Reason for waste export
2.	Хаягдал экспортлогч (1)	Exporter of the waste (1)
3.	Хаягдал үйлдвэрлэгч/үйлдвэрлэгчид, үйлдвэрлэлийн цэгийн байршил (1)	Generator(s) of the waste and site of generation (1)
4.	Хаягдлыг захиран зарцуулах/зайлуулах ажлыг хариуцагч этгээд, хаягдлыг захиран зарцуулах/зайлуулах газар (1)	Disposer of the waste and actual site of disposal (1)
5.	Хэрэв тодорхой бол, хаягдал тээвэрлэгч, түүний төлөөлөгчид, (1)	Intended carrier(s) of the waste or their agents, if known (1)
6.	Хаягдал экспортлох улс дахь Эрх бүхий байгууллага (Засаг захиргаа) (2)	Country of export of the waste Competent authority (2)
7.	Дамжуулан өнгөрүүлэх улс дахь Эрх бүхий байгууллага (Засаг захиргаа) (2)	Expected countries of transit Competent authority (2)
8.	Хаягдал импортлох улс дахь Эрх бүхий байгууллага (Засаг захиргаа) (2)	Country of import of the waste Competent authority (2)
9.	Ерөнхий буюу нэг удаагийн мэдэгдэл	General or single notification
10.	Хаягдлыг экспортлохоор төлөвлөж буй замын маршрут, орох гарах хилийн боомт, хэзээ тээвэрлэх болон экспортын үргэлжлэх хугацаа (3)	Projected date(s) of shipment(s) and period of time over which waste is to be exported and proposed itinerary (including point of entry and exit) (3)
11.	Төлөвлөж буй тээврийн төрөл (автомашинаар, төмөр замаар, далайн тээврээр, агаараар, дотоодын усан тээврээр)	Means of transport envisaged (road, rail, sea, air, inland waters)
12.	Даатгалд хамаарах мэдээлэл (4)	Information relating to insurance (4)
13.	Хаягдлын тодорхойлолт, биет дүрслэл, түүний дотор Y дугаар болон НҮБ-ын дугаар, хаягдлын бүтэц (5), мөн аюул ослын үед авах арга хэмжээ болон тусгайлан анхаарвал зохих зүйлийн талаарх мэдээлэл	Designation and physical description of the waste including Y number and UN number and its composition (5) and information on any special handling requirements including emergency provisions in case of accidents
14.	Сав боодлын төрөл (жнь: задгай, торхтой, цистерн г.м)	Type of packaging envisaged (e.g. bulk, drummed, tanker)
15.	Тоо хэмжээ, жингээр/эзэлхүүнээр (6)	Estimated quantity in weight/volume (6)
16.	Хаягдлыг үйлдвэрлэсэн процесс (7)	Process by which the waste is generated (7)
17.	Хавсралт I-д жагсаасан хаягдлын хувьд Хавсралт III -т заасан ангилал: аюултай шинж чанар, H дугаар, мөн НҮБ-ын ангиллын дугаар	For wastes listed in Annex I, classifications from Annex III: hazardous characteristic, H number, and UN class
18.	Хавсралт IV-т заасанчилан хаягдлыг захиран зарцуулах/зайлуулах арга	Method of disposal as per Annex IV
19.	Энэ мэдээлэл үнэн зөв болохыг нотлох үйлдвэрлэгчийн болон экспортлогчийн мэдэгдэл/мэдүүлэг	Declaration by the generator and exporter that the information is correct
20.	Хаягдлыг байгаль орчинд халгүйгээр, импортлогч орны норм, дүрмийн дагуу захиран зарцуулах/зайлуулах талаар холбогдох захиран зарцуулагч буюу зайлуулагч этгээдээс экспортлогчид, эсхүл үйлдвэрлэгчид амлалт өгсөн мэдээлэл	Information transmitted (including technical description of the plant) to the exporter or generator from the disposer of the waste upon which the latter has based his assessment that there was no reason to believe that the wastes will not be managed in an environmentally sound manner in accordance with the laws and regulations of the country of import
21.	Экспортлогч болон хаягдал зайлуулах ажиллагааг хариуцагч этгээдийн хооронд байгуулсан гэрээний тухай мэдээлэл	Information concerning the contract between the exporter and disposer

ТАЙЛБАР

- (1) Бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар, мөн холбоо барих этгээдийн бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар.
- (2) Бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар.
- (3) Хэд хэдэн ачилтыг хамарсан ерөнхий мэдэгдэл гаргах тохиолдолд, ачилт тус бүрийг тээвэрлэхээр төвлөсөн хугацаа, хэрэв тэр нь тодорхой бус бол, ачилтын төвлөсөн давтамжийг мэдээлэх шаардлагатай.
- (4) Даатгалын байгууллагаас тавьсан шаардлага, уг шаардлагыг хаягдал экспортлогч, тээвэрлэгч, захиран зарцуулагч этгээд хэрхэн биелүүлэх тухай мэдээлэл.
- (5) Уг хог хаягдалтай харьцах болон түүнийг захиран зарцуулах аргын хувьд учирч болох хор хохирол, өөр бусад аюулын үүднээс онц аюултай бүрдэл хэсгийн мөн чанар, концентрац.
- (6) Хэд хэдэн ачилтыг хамарсан ерөнхий мэдэгдэл гаргах тохиолдолд, нийт ачилтын жин, тоо хэмжээ, мөн ачилт тус бүрийн жин, тоо хэмжээг мэдээлэх шаардлагатай.
- (7) Энэ нь хаягдлын хор хөнөөлийг тогтоох, хаягдлыг захиран зарцуулах/зайлуулах ажиллагаа (арга хэлбэр) хэр зохимжтой болохыг тодорхойлоход шаардлагатай.

Хавсралт V В: Тээврийн бичиг баримтад байвал зохих мэдээлэл (Information to be provided on the movement document)

1.	Хаягдал экспортлогч (1)	Exporter of the waste (1)
2.	Хаягдал үйлдвэрлэгч/үйлдвэрлэгчид болон үйлдвэрлэлийн цэгийн байршил (1)	Generator(s) of the waste and site of generation (1)
3.	Хаягдлыг хариуцагч этгээд, захиран зарцуулах/зайлуулах гэж буй газрын байршил (1)	Disposer of the waste and actual site of disposal (1)
4.	Хаягдал тээвэрлэгч (1) , түүний төлөөлөгч	Carrier(s) of the waste (1) or his agent(s)
5.	Ерөнхий буюу нэг удаагийн мэдэгдэл	Subject of general or single notification
6.	Хаягдлыг хил дамжуулан тээвэрлэж эхэлсэн хугацаа, түүнийг хариуцагч этгээд хүлээн авсан огноо, гарын үсэг	The date the transboundary movement started and date(s) and signature on receipt by each person who takes charge of the waste
7.	Тээврийн төрөл (автомашинаар, төмөр замаар, далайн тээврээр, агаараар, дотоодын усан тээврээр), үүнд экспортлогч, дамжуулан өнгөрүүлэгч болон импортлогч улсууд, мөн орох, гарах хилийн цэг орно.	Means of transport (road, rail, inland waterway, sea, air) including countries of export, transit and import, also point of entry and exit where these have been designated
8.	Хаягдлын ерөнхий бичиглэл (физик шинж чанар, НҮБ-аас гаргасан ачааны нэршил, ангилал, дугаар, Y болон H дугаарын аль байгааг нь бичих)	General description of the waste (physical state, proper UN shipping name and class, UN number, Y number and H number as applicable)
9.	Аюул, ослын зэрэг зарим онцгойлон анхаарал шаардагдах үед авах арга хэмжээний тухай мэдээлэл	Information on special handling requirements including emergency provision in case of accidents
10.	Сав боодлын төрөл, тоо ширхэг	Type and number of packages
11.	Ачааны тоо хэмжээ, эзэлхүүн	Quantity in weight/volume
12.	Энэ мэдээлэл үнэн зөв болохыг нотлох үйлдвэрлэгчийн болон экспортлогчийн мэдэгдэл/мэдүүлэг	Declaration by the generator or exporter that the information is correct
13.	Энэ Конвенцийн Тал болох сонирхогч бүх Улсын Эрх бүхий байгууллагын зүгээс татгалзах зүйлгүйг харуулсан хаягдал үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчийн мэдэгдэл	Declaration by the generator or exporter indicating no objection from the competent authorities of all States concerned which are Parties
14.	Хаягдлыг захиран зарцуулагч/зайлуулагч этгээд тийнхүү захиран зарцуулах буюу зайлуулах газартаа хүлээн авсан байдал, хаягдлыг захиран зарцуулах/зайлуулах арга хэлбэр, огноог гэрчлэх баримт	Certification by disposer of receipt at designated disposal facility and indication of method of disposal and of the approximate date of disposal

ТАЙЛБАР

Тээвэрлэлтийн бичиг баримтад шаардлагатай мэдээлэл тээвэрлэлтийн дүрэм, журмаар шаардагдах ганц бичиг баримтад тусгагдсан байна. Тийнхүү нэг бичиг баримтад тусгах боломжгүй бол уг мэдээллийг тээвэрлэлтийн дүрэм, журмаар шаардагдах бичиг баримттай давхардуулалгүйгээр, түүнд нэмэлт байдлаар тусгана. Уг мэдээллийг хэн өгөх, маягтыг хэн бөглөх талаар тээвэрлэлтийн бичиг баримтад заасан байна.

(1) Бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар, мөн ослын үед холбоо барих этгээдийн бүтэн нэр, хаяг, телефон, телекс, телефаксын дугаар.

Хавсралт VI: Арбитрийн ажиллагаа (Arbitration)

1 дүгээр зүйл

Энэ Конвенцийн 20 дугаар зүйлийг үндэслэн өөрөөр тохиролцоогүй бол арбитрийн ажиллагаа нь дор дурдсан 2-10 дугаар зүйлийн дагуу явагдана.

2-10 дугаар зүйл

Хавсралт VII: [Энэ Хавсралтыг Талуудын Бага хурлын 3 дугаар хуралдаанаар (1995 онд) баталж нэмсэн нь өнөөдөр хүчин төгөлдөр болоогүй байна]

- Энэ Хавсралтад Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд, мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Европын комисс (EC), Лихтенштейн (Liechtenstein)-ы Гишүүн бусад орон хамаарна.

Хавсралт VIII: Жагсаалт А (List A)

A1 Металлын хаягдал болон металл агуулсан хаягдал	A1 Metal and metal-bearing wastes
A1010-A1190 гэсэн дугаартай 19 бүлэг хаягдал багтсан.	
A2 Үндсэндээ органик бус бодис агуулсан, гэхдээ металл болон органик материал агуулж болох хаягдал	A2 Wastes containing principally inorganic constituents, which may contain metals and organic materials
A2010-A2060 гэсэн дугаартай 6 бүлэг хаягдал багтсан.	
A3 Үндсэндээ органик бодис агуулсан, гэхдээ металл болон органик материал агуулж болох хаягдал	A3 Wastes containing principally organic constituents, which may contain metals and inorganic materials
A3010-A3200 гэсэн дугаартай 20 бүлэг хаягдал багтсан.	
A4 Органик бус бодис, органик бодисын аль нэгийг агуулж болох хаягдал	A4 Wastes which may contain either inorganic or organic constituents
A4010-A4160 гэсэн дугаартай 16 бүлэг хаягдал багтсан.	

- Энэ Хавсралтыг Талуудын Бага хурлын 4 дугаар хуралдаанаар баталж нэмсэн нь 1998 оны 11 дүгээр сарын 6-нд хүчин төгөлдөр болсон. Энэ хавсралтад Талуудын Бага хурлын 6, 7 дугаар хуралдаанаар дахин хоёр нэмэлт оруулсан нь 2003 оны 11 дүгээр сарын 20, 2005 оны 10 дугаар сарын 8-ны өдрүүдэд тус тус хүчин төгөлдөр болсон.
- Хавсралт VIII-д жагсаасан хог хаягдлыг энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а)-д зааснаар аюултай гэж үзнэ.
- Аливаа хог хаягдлыг Хавсралт VIII-д оруулах нь тодорхой тохиолдолд аливаа хог хаягдал энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а)-д зааснаар аюултай биш болохыг нотлон харуулах зорилгоор Хавсралт III-г ашиглахад саад болохгүй.
- Хавсралт VIII нь хог хаягдлын шинж чанарыг тодорхойлох зорилгоор энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а) заалтыг мөрдөхөд нөлөө үзүүлэхгүй.

Хавсралт IX: Жагсаалт B (List B)

B1 Металлын хаягдал болон металл агуулсан хаягдал	B1 Metal and metal-bearing wastes
B1010-B1250 гэсэн дугаартай 27 бүлэг хаягдал багтсан.	
B2 Үндсэндээ органик бус бодис агуулсан, гэхдээ металл болон органик материал агуулж болох хаягдал	B2 Wastes containing principally inorganic constituents, which may contain metals and organic materials
B2010-B2130 гэсэн дугаартай 13 бүлэг хаягдал багтсан.	
B3 Үндсэндээ органик бодис агуулсан, гэхдээ металл болон органик материал агуулж болох хаягдал	B3 Wastes containing principally organic constituents, which may contain metals and inorganic materials
B3010-B3140 гэсэн дугаартай 16 бүлэг хаягдал багтсан.	
B4 Органик бус бодис, органик бодисын аль нэгийг агуулж болох хаягдал	B4 Wastes which may contain either inorganic or organic constituents
B4010-B4030 гэсэн дугаартай 3 бүлэг хаягдал багтсан.	

Энэ Хавсралтыг Талуудын Бага хурлын 4 дугаар хуралдаанаар баталж нэмсэн нь 1998 оны 11 дүгээр сарын 6-нд хүчин төгөлдөр болсон. Энэ хавсралтад Талуудын Бага хурлын 6, 7 дугаар хуралдаанаар дахин хоёр нэмэлт оруулсан нь 2003 оны 11 дүгээр сарын 20, 2005 оны 10 дугаар сарын 8-ны өдрүүдэд тус тус хүчин төгөлдөр болсон.

- Хавсралт IX-д жагсаасан хог хаягдал энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а)-д хамаарахгүй.
- Аливаа хог хаягдлыг Хавсралт IX-д оруулах нь тодорхой тохиолдолд аливаа хог хаягдал Хавсралт III-т заасан шинж чанарыг илэрхийлэх хэмжээгээр Хавсралт I-д заасан материал агуулж байвал түүнийг энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а)-д зааснаар аюултай гэж тодорхойлоход саад болохгүй.
- Хавсралт IX нь хог хаягдлын шинж чанарыг тодорхойлох зорилгоор энэ Конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 (а) заалтыг мөрдөхөд нөлөө үзүүлэхгүй.

Энэ Конвенцийн дагуу "Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулах явдлаас үүдэн гарсан хохирлыг хариуцах, нөхөн төлөх тухай" Протокол (Протокол об ответственности и компенсации за ущерб, причиненный в результате трансграничной перевозки опасных отходов и их удаления) байгуулагдсан байдаг.



21. Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын Конвенц (Роттердамын Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	Rotterdam Convention on the Prior Informed Consent Procedure for Certain Hazardous Chemicals and Pesticides in International Trade (Rotterdam Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Роттердамская Конвенция о процедуре предварительного обоснованного согласия в отношении отдельных опасных химических веществ и пестицидов в международной торговле
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1998 оны 9 дугаар сарын 10. Голландын Роттердам хот (Rotterdam, Holland/Netherlands)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2004-02-24
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 158
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1998 оны 9 дүгээр сарын 11-нд гарын үсэг зурсан. 2000-10-05-ны өдөр соёрхон баталсан
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2001-03-08
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2004-02-24
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал:	- Хавсралт III-ын нэмэлтүүд 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос:	- Конвенц соёрхон батлах тухай 2000 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн хууль

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Хэлэлцэн тохирогч Талууд химийн хорт бодисыг импортлохтой холбогдуулан хариуцлагаа хуваалцах, мэдээлэл нээлттэй солилцох үүрэг авсан. Экспортлогч тухайн бодисын шошго/хаягжуулалтыг зөв хийх, түүнтэй аюулгүй байдлаар харьцах зааврыг хавсаргах, хориг, хязгаарлалтын талаар худалдан авагчид мэдэгдэх үүрэгтэй. Хэлэлцэн тохирогч талууд энэ Конвенцид заасан химийн бодисуудыг импортлохыг зөвшөөрөх, эсхүл хориглох асуудлыг өөрсдөө шийднэ. Экспортлогч орнууд өөрсдийнх нь нутаг дэвсгэрт тэдний хууль тогтоомж зөрчигдөөгүй гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Одоогийн байдлаар дараах төрлийн 41 нэр бүхий химийн бодис III хавсралтад орсон байна:

- Пестицид (Pesticide) - 24
- Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн (Severely hazardous pesticide formulation) - 6
- Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис (Industrial) - 11

Конвенцийн бүтэц:

1 дүгээр зүйл. Зорилго (Objective)

2 дугаар зүйл. Тодорхойлолт (Definitions): Энэ Конвенцийн зорилгоор:

- (a) “Химийн бодис” гэж өөрийн үндсэн буюу хольц болон бэлтгэц байдлаар байгаа үйлдвэрлэлийн аргаар буюу байгалиас гаргаж авсан химийн бодисыг хэлэх бөгөөд түүнд ямар нэг амьд биет үл хамаарна. Энэхүү химийн бодис нь пестицидийн /онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг оруулан/ болон үйлдвэрлэлийн гэсэн зориулалтын ангилалтай байна.
- (b) “Хориглосон химийн бодис” гэж хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан арга хэмжээгээр нэг буюу хэд хэдэн зориулалтын ангиллын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалах бодит шаардлагын үүднээс анх удаагийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан буюу дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна.
- (c) “Хатуу хязгаарлалттай химийн бодис” гэж хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эцэслэн журамласан арга хэмжээгээр нэг буюу хэд хэдэн зориулалтын ангиллын хүрээнд бүх төрлийн ашиглалтыг нь хязгаарласан боловч зарим онцгой тохиолдолд ашиглахыг зөвшөөрсөн химийн бодисыг хэлнэ. Түүнд хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчныг хамгаалах бодит шаардлагын үүднээс бараг бүх төрлийн хэрэглээг нь зөвшөөрөөгүй түүнчлэн үйлдвэрлэлийн улмаас дотоодын зах зээлээс хасагдсан буюу дотоодод хэрэглэх асуудлыг цаашид авч хэлэлцэхгүй болсон химийн бодисууд хамаарна.
- (d) “Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн” гэж хөдөө аж ахуйн хортон шавьж устгах зориулалтаар үйлдвэрлэсэн бөгөөд ашиглалтын нөхцөлийн дагуу ганц буюу хэд хэдэн удаа хэрэглэсний дараа богино хугацааны дотор хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчинд онцгой аюул учруулах химийн бодисыг хэлнэ.

3 дугаар зүйл. Конвенцийн хамрах хүрээ (Scope of the Convention): Энэ Конвенцид дараах бодисууд хамаарна:

- (a) Хориглосон болон хатуу хязгаарлалттай химийн бодис
- (b) Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн

Энэ Конвенцид дараах бодисууд үл хамаарна:

- (a) Мансууруулах эмийн зүйлс болон сэтгэцэд нөлөөт бодисууд
- (b) Радио идэвхт материал
- (c) Хог хаягдал
- (d) Химийн зэвсэг
- (e) Хүн болон малын эмийн зүйлсийг оруулсан эмийн бодисууд
- (f) Хоол хүнсэнд нэмж хэрэглэдэг химийн бодисууд
- (g) Хоол хүнс
- (h) Хүний эрүүл мэнд буюу хүрээлэн буй орчинд нөлөөлөхөөргүй тоо хэмжээгээр дараах зорилгоор импортлож буй химийн бодисууд. Үүнд:
 - (i) Судалгаа шинжилгээний зориулалтаар буюу
 - (ii) Хувь хүн өөрийн ахуйн хэрэгцээнд шаардагдах тоо хэмжээгээр импортлох

4 дүгээр зүйл. Эрх бүхий үндэсний алба байгуулах (Designated national authorities)

5 дугаар зүйл. Хориглосон, эсхүл хатуу хязгаарлалттай химийн бодист хамаарах журам (Procedures for banned or severely restricted chemicals)

6 дугаар зүйл. Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнд хамаарах журам (Procedures for severely hazardous pesticide formulations)

- 7 дугаар зүйл. Химийн бодисыг Хавсралт III-т оруулах (Listing of chemicals in Annex III)
- 8 дугаар зүйл. Сайн дураар урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах журамд хамаарах химийн бодисууд (Chemicals in the voluntary Prior Informed Consent procedure)
- 9 дүгээр зүйл. Химийн бодисыг Хавсралт III-аас гаргах (Removal of chemicals from Annex III)
- 10 дугаар зүйл. Хавсралт III-т заасан химийн бодисыг импортлохтой холбогдсон үүрэг (Obligations in relation to imports of chemicals listed in Annex III)
- 11 дүгээр зүйл. Хавсралт III-т заасан химийн бодисыг экспортлохтой холбогдсон үүрэг (Obligations in relation to exports of chemicals listed in Annex III)
- 12 дугаар зүйл. Экспортын мэдэгдэл (Export notification)
- 13 дугаар зүйл. Экспортын химийн бодисыг дагалдах мэдээлэл (Information to accompany exported chemicals)
- 14 дүгээр зүйл. Мэдээлэл солилцох (Information exchange)
- 15 дугаар зүйл. Конвенцийг хэрэгжүүлэх (Implementation of the Convention)
- 16 дугаар зүйл. Техникийн туслалцаа (Technical assistance)
- 17 дугаар зүйл. Конвенцийн заалтыг үл хэрэгжүүлэх явдлыг тодруулах (Non-Compliance)
- 18 дугаар зүйл. Талуудын Бага хурал (Conference of the Parties)
- 19 дүгээр зүйл. Нарийн бичгийн даргын газар (Secretariat)
- 20 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх (Settlement of disputes)
- 21 дүгээр зүйл. Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах (Amendments to the Convention)
- 22 дугаар зүйл. Хавсралтуудыг батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах (Adoption and amendment of annexes)
- 23 дугаар зүйл. Санал өгөх эрх (Voting)
- 24 дүгээр зүйл. Гарын үсэг зурахад нээлттэй байх хугацаа (Signature)
- 25 дугаар зүйл. Конвенцийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, албан ёсоор нотлох буюу сайшаан дэмжих (Ratification, acceptance, approval or accession)
- 26 дугаар зүйл. Конвенц хүчин төгөлдөр болох (Entry into force)
- 27 дугаар зүйл. Конвенцид тайлбар хийх (Reservations)
- 28 дугаар зүйл. Конвенциос гарах (Withdrawal)
- 29 дүгээр зүйл. Конвенцийн эх хадгалагч (Depositary)
- 30 дугаар зүйл. Эх хувиуд ижил хүчинтэй байна. (Authentic texts)
 - Хавсралт I: 5 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл хийхэд шаардлагатай мэдээлэл (Information Requirements for Notifications Made Pursuant to Article 5)
 - Хавсралт II: Хориглосон, эсхүл хатуу хязгаарлалттай химийн бодисыг Хавсралт III-т оруулах шалгуурууд (Criteria for Listing Banned or Severely Restricted Chemicals in Annex III)
 - Хавсралт III: Урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах журамд хамаарах химийн бодисууд (Chemicals Subject to The Prior Informed Consent Procedure)
 - Хавсралт IV: Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүнийг Хавсралт III-т оруулах шалгуурууд ба мэдээлэл (Information and Criteria for Listing Severely Hazardous Pesticide Formulations in Annex III)
 - Хавсралт V: Экспортын мэдэгдэл хийхэд шаардлагатай мэдээлэл (Information Requirements for Export Notification)
 - Хавсралт VI: Маргаан шийдвэрлэх (Settlements of Disputes)

Хавсралт III-т орсон химийн бодисууд

Химийн бодисууд монголоор	Химийн бодисууд англиар	Холбогдох CAS (Chemical Abstract's Servise) дугаар буюу олон улсын код	Зориулалтын ангилал
2.4.5-Т ба түүний давс болон нийлмэл эфирүүд	2,4,5-T and its salts and esters	93-76-5	Пестицид
Альдрин	Aldrin	309-00-2	Пестицид
Бинапакриль	Binapacryl	485-31-4	Пестицид
Каптафол	Captafol	2425-06-1	Пестицид
Хлордан	Chlordane	57-74-9	Пестицид
Хлордимеформ	Chlordimeform	6164-98-3	Пестицид
Хлоробензилат	Chlorobenzilate	510-15-6	Пестицид
ДДТ	DDT	50-29-3	Пестицид
Дильдрин	Dieldrin	60-57-1	Пестицид
Динитро-орто-кресол болон түүний давсууд /аммонийн, калийн, натрийн давс зэрэг/	Dinitro-ortho-cresol (DNOC) and its salts (such as ammonium salt, potassium salt and sodium salt)	534-52-1 2980-64-5 5787-96-2 2312-76-7	Пестицид
Диносив болон түүний давсууд болон нийлмэл эфирүүд	Dinoseb and its salts and esters	88-85-7	Пестицид
1,2-дибромэтан, ЭДВ	1,2-dibromoethane (EDB)	106-93-4	Пестицид
Этилийн дихлорид	Ethylene dichloride	107-06-2	Пестицид
Этилийн исэл	Ethylene oxide	75-21-8	Пестицид
Флуорацитаמיד	Fluoroacetamide	640-19-7	Пестицид
НСН изомерийн холимогууд	HCH (mixed isomers)	608-73-1	Пестицид
Гептахлор (7 хлорт)	Heptachlor	76-44-8	Пестицид
Гексахлорбензол (6 хлорт бензол)	Hexachlorobenzene	118-74-1	Пестицид
Линдан	Lindane	58-89-9	Пестицид
Мөнгөн усны нэгдлүүд, мөнгөн усны органик бус нэгдлүүд, алкил мөнгөн усны нэгдлүүд, алкилоксиалкил буюу мөнгөн усны арил нэгдлүүд	Mercury compounds, including inorganic mercury compounds, alkyl mercury compounds and alkyloxyalkyl and aryl mercury compounds		Пестицид
Нэг кротофос	Monocrotophos	6923-22-4	Пестицид
Паратион	Parathion	56-38-2	Пестицид
5 хлор фенол, түүний давс болон нийлмэл эфир	Pentachlorophenol and its salts and esters	87-86-5	Пестицид
Токсафен	Toxaphene	8001-35-2	Пестицид

Химийн бодисууд монголоор	Химийн бодисууд англиар	Холбогдох CAS (Chemical Abstract's Service) дугаар буюу олон улсын код	Зориулалтын ангилал
Дараах бодисын хосолсон хэлбэр бүхий тоосонцорын бүрэлдэхүүн: - 7 буюу түүнээс дээш %-тай беномил - 10 буюу түүнээс дээш %-тай карбофуран - 15 буюу түүнээс дээш хувьтай тирам	Dustable powder formulations containing a combination of: - Benomyl at or above 7 per cent, - Carbofuran at or above 10 per cent, - Thiram at or above 15 per cent	17804-35-2 1563-66-2 137-26-8	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Монокротофос (600 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	Monocrotophos (Soluble liquid formulations of the substance that exceed 600 g active ingredient/l)	6923-22-4	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Метамидофос (600 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	Methamidophos (Soluble liquid formulations of the substance that exceed 600 g active ingredient/l)	10265-92-6	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Фосфоамидон (1000 гр/литр идэвхт бодис бүхий шингэн хэлбэрт уусмал)	Phosphamidon (Soluble liquid formulations of the substance that exceed 1000 g active ingredient/l)	13171-21-6 ((E) ба (Z) изомерийн холимог) 23783-98-4 ((Z) - изомерт) 297-99-4 ((E)-изомерт)	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Метил-паратион (Эмульсийн концентрац нь 19.5 буюу түүнээс дээш хувийн идэвхт бодис бүхий, мөн 1.5 буюу түүнээс дээш %-ийн идэвхт бодис бүхий тоосонцор агуулсан)	Methyl-parathion (emulsifiable concentrates (EC) at or above 19.5% active ingredient and dusts at or above 1.5% active ingredient)	298-00-0	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Паратион /суспензээс бусад аэрозоль, тоосонцор, эмульс, буурцагт хэлбэртэй/	(1) Parathion (all formulations - aerosols, dustable powder (DP), emulsifiable concentrate (EC), granules (GR) and wettable powders (WP) - of this substance are included, except capsule suspensions (CS)	56-38-2	Онцгой аюултай пестицидийн бүрэлдэхүүн
Асбестос: - Актинолит - Антофилит - Амосит - Кросидолит - Тремолит	Asbestos: - Actinolite - Anthophyllite - Amosite - Crocidolite - Tremolite	77536-66-4 77536-67-5 12172-73-5 12001-28-4 77536-68-6	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис

Химийн бодисууд монголоор	Химийн бодисууд англиар	Холбогдох CAS (Chemical Abstract's Service) дугаар буюу олон улсын код	Зориулалтын ангилал
Олон хлорт бифенилүүд (PBВ) (59080-40-9 ажирЭ 27858-07-7 мисЭ 13654-09-6 бвиЭ)	Polybrominated biphenyls (PBВ)	36355-01-8(hexa-) 27858-07-7 (octa-) 13654-09-6 (deca-)	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис
Олон хлорт бифенилүүд (PCB)	Polychlorinated biphenyls (PCB)	1336-36-3	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис
Олон хлорт терфенилүүд (PCT)	Polychlorinated terphenyls (PCT)	61788-33-8	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис
4 этилт хар тугалга	Tetraethyl lead	78-00-2	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис
4 метилт хар тугалга	Tetramethyl lead	75-74-1	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис
Трис (2, 3-дибромпропил) фосфатууд	Tris (2,3-dibromopropyl) phosphate	126-72-7	Үйлвэрлэлийн зориулалттай химийн бодис

Тайлбар: Энэ Хавсралтын нэмэлтүүд 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.



22. Биологийн төрөл зүйл (олон янз байдал)-ийн тухай Конвенц

1.a. Гэрээний нэр англиар:	Convention on Biological Diversity (Biodiversity Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Конвенция о биологическом разнообразии
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 1992 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Бразил Улсын Рио де-Жанейро хотноо болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалт (Earth Summit)-ын үеэр байгуулагдсан (Rio de Janeiro, Brazil)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	1993-12- 29
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 196
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	1992-06-12-ны өдөр гарын үсэг зурсан. 1993-06-01-ний өдөр соёрхон баталсан.
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	1993-09-30
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	1993-12- 29
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: -	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - Олон улсын конвенц соёрхон батлах тухай 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хууль	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц дараах гурван гол зорилтыг дэвшүүлэн тавьсан:

1. Биологийн төрөл зүйлийг хамгаалах (The conservation of biological diversity - сохранение биологического разнообразия)
2. Биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгүүдийг зүй зохистой, тогтвортой хэлбэрээр ашиглах (The sustainable use of the components of biological diversity - устойчивое использование компонентов биологического разнообразия)
3. Генийн нөөц ашигласны ашиг тусыг шударга, адил тэгш байх зарчмаар хуваарилах (The fair and equitable sharing of the benefits arising out of the utilization of genetic resources - генетические ресурсы)

Биологийн төрөл зүйл (олон янз байдал, Biological diversity - биологическое разнообразие) гэж хуурай газар, далай тэнгисийн болон бусад усны экосистемүүд, экологийн цогцолборууд, өөр бусад бүхий л эх үүсвэрүүдийн амьд организмын төрлүүд юм. Энэ ойлголт нь зүйлийн хүрээнд дэх

төрөл зүйлүүд ба экосистемийн хоорондын төрөл зүйлийг өөртөө агуулна (the variability among living organisms from all sources including, inter alia, terrestrial, marine and other aquatic ecosystems and the ecological complexes of which they are part: this includes diversity within species, between species and of ecosystems);

Биологийн нөөц (Biological resources - биологические ресурсы) гэж генетикийн нөөц, организм эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг, бүлгэмдэл (популяцууд), хүн төрөлхтөнд бодит болон боломжит ашиг, үнэ цэнэ бүхий экосистемийн бусад бүх бүрэлдэхүүн хэсгийг багтаана (genetic resources, organisms or parts thereof, populations, or any other biotic component of ecosystems with actual or potential use or value for humanity);

Биотехнологи (Biotechnology - биотехнология) гэж тодорхой зориулалтаар ашиглах бүтээгдэхүүн гаргаж авах эсхүл сайжруулах, түүнийг гаргаж авах үйл явцыг өөрчлөхөд биологийн тогтолцоо, организм тэдгээрийн бүтээгдэхүүнийг ашиглахтай холбогдсон технологийн аливаа төрөл (any technological application that uses biological systems,

living organisms, or derivatives thereof, to make or modify products or processes for specific use);

Экосистем (Ecosystem - экосистема) гэж амьтан ургамал, бичил организмын бүлгэмдэл болон тэдгээртэй бүхэл бүтэн нэгдмэл байдлаар харилцан үйлчлэгч амьгүй орчны динамик цогцолбор (a dynamic complex of plant, animal, and micro-organism communities and their non-living environment interacting as a functional unit);

Ex-situ хадгалах (Ex-situ conservation - сохранение ex-situ) гэж биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгийг түүний амьдардаг нутаг орны нь гадна хадгалах (the conservation of components of biological diversity outside their natural habitats);

Амьдрах нутаг орон (Habitat - место обитания) гэж аливаа организм, бүлгэмдлийн амьдардаг байгалиас заяасан газар юмуу нутаг орны төрөл (the place or type of site where an organism or population naturally occurs);

Генетикийн материал (Genetic material - генетический материал) гэж ургамал, амьтан, бичил биетний болон удамшлын функционал нэгжийг агуулсан өөр гарлын материал (any material of plant, animal, microbial or other organ containing functional units of heredity);

Генетекийн нөөц (Genetic resources - генетические ресурсы) гэж бодит эсхүл боломжит үнэ цэнэ бүхий генетикийн материал (genetic material of actual or potential value). Уг Конвенцийг баталсан Хүрээлэн буй орчин, хөгжлийн асуудлаарх НҮБ-ын Бага хурал (Дэлхийн хэмжээний дээд уулзалт)-ын бас нэг үр дүн нь Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай Риогийн Тунхаглал (Rio Declaration on Environment and Development - Рио-де-Жанейрская декларация по окружающей среде и развитию)-ыг баталсан явдал болно. Уг тунхаглалд тогтвортой хөгжлийн суурийг тавьж, бэхжүүлэх 27 зарчим тусгагдсан байна.

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын интернэт сайтаас:

Биологийн төрөл зүйл (Biodiversity) гэдэг нь дэлхий дээрх амьдралын олон янз байдал, тэдгээрийн бүрэлдүүлэх олон янз, хэв маягт оноосон нэр томъёо юм. Өнөөдөр бидний харж буй биологийн төрөл зүйлүүд нь хэдэн тэрбум жилийн хувьслын үр дүн бөгөөд байгалийн үйл явц, түүнээс илүүтэйгээр хүний нөлөөн доор бүрэлдэн бий болжээ. Энэ нь биднийг өөрт хамруулах, өөрийн нэг хэсгээ болгох амьдралын хэлхээг бүрдүүлдэг юм. Олон янз байдал нь ургамал, амьтан, бичил биетнүүд гэсэн өргөн

хүрээнд ойлгох нь элбэг. Өнөөдөр 1.75 сая биологийн төрөл зүйл тодорхойлогдоод байгаа бөгөөд ихэнхи нь шавж, жижиг амьтад байна. Эрдэмтэд ойролцоогоор 13 сая төрөл зүйл байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч 3-100 сая байна хэмээн тооцоолж байна. Биологийн төрөл зүйл нь зүйлүүдийн генийн ялгааг мөн өөрт хамруулдаг, жишээ нь, малын үүлдэр болон үр тарианы төрлүүд зэрэг. Хромосом, гене, ДНХ буюу амьдралыг бүрдүүлэгч суурь бүрдлүүд нь төрөл зүйлүүдийн хувийн онцлогийг тодорхойлж байдаг юм.

Биологийн төрөл зүйлүүдийн өөр нэг онцлог тал нь цөл, ой хээр, намаг, уул нуруу, нуур, гол горхи, хөдөө аж ахуйн газар зэрэг үзэмж байдлыг бүрдүүлэх экосистемүүдийн хүрээнд бүх амьд организм тухайлбал хүн, амьд амьтан тэдгээрийн бүлгэмдүүд өөр хоорондоо болон тэднийг хүрээлэн буй хөрс, ус, агаартай харьцдаг харилцаа юм. Энэ нь амьдралын хэлбэрүүдийн хослол бөгөөд тэдний бие биетэйгээ болон хүрээлэн буй орчны бусад иж бүрдлүүдтэй харьцдаг харилцаа нь болж дэлхий ертөнц дээр хүн оршин тогтнох хосгүй орчинг бүрдүүлдэг юм. Биологийн төрөл зүйл нь бидний амьдралыг тэтгэж байдаг олон тооны бүтээгдэхүүн болон үйлчилгээг хангадаг.

Рио де Жанейрод 1992 онд болсон Дэлхийн дээд хэмжээний уулзалтаар Ирээдүй хойч үедээ эрүүл, амьдрах чадвартай дэлхий үлдээх явдлыг баталгаажуулахын зэрэгцээ бидний хэрэгцээнд нийцэх "тогтвортой хөгжил"-ийн цогц стратегийг баталсан. Риод батлагдсан гол Хэлэлцээрүүдийн нэг нь Биологийн төрөл зүйлийн Конвенц байсан юм. Дэлхийн улс орнуудын дийлэнхи олонхийн батламжилсан энэ гэрээ нь эдийн засгийн хөгжлийг чухалчилж буй өнөө үед дэлхийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үүргийг томъёолсон болно.

Монгол улсын Ерөнхий сайд Д. Бямбасүрэн 1992 онд Рио де Жанейро хотод хуралдсан НҮБ-ын Байгаль орчин ба Хөгжил Бага хурлын үеэр уг Конвенцид гарын үсэг зурж, түүнийг Монгол улсын Их Хурлаас 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдөр соёрхон баталсан тухай батламж бичгээ 1993 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар өгснөөр Конвенцийг соёрхон баталсан тухай баримт бичгийг эх хадгалагчид өгсөн 30 дахь орон болсон юм. Өөрөөр хэлбэл, 30 дахь баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дараа уг Конвенц хүчин төгөлдөр болох ёстой бөгөөд ийнхүү манай улс уг Конвенц хүчин төгөлдөр болох нөхцөлийг бүрдүүлжээ.



23. Био аюулгүй байдлын тухай Картагены протокол (Картагены протокол)

1.а. Гэрээний нэр англиар:	The Cartagena Protocol on Biosafety (The Cartagena Protocol)
1.б. Гэрээний нэр оросоор:	Картахенский протокол по биобезопасности (Картахенский протокол)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 2000-5-15. Испани Улсын Картаген (Картахена) хот (Cartagena, Spain)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2003-09-11
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 171
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2002-11-28
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2003-07-22
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2003-10-20
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: -	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - Биоаюулгүй байдлын тухай Картагений протоколыг соёрхон батлах тухай 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хууль	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэхүү Протоколыг Биологийн төрөл зүйлийн тухай Конвенцийн нэмэлт Хэлэлцээр гэж үздэг (An international agreement on biosafety, as a supplement to the Convention on Biological Diversity)

Энэхүү Протокол нь биологийн төрөл зүйлийг орчин үеийн биотехнологийн хөгжлийн үр дүнд бий болсон хувиргасан амьд организмын нөлөөллөөс хамгаалах зорилготой.

Протоколын 3 дугаар зүйл: Тодорхойлолт:

(b) “Битүү системд/хязгаарлагдмал орчинд ашиглах” (Contained use) гэж хувиргасан амьд организмыг гадаад орчинтой харьцах болон түүнд нөлөөлөх явдлыг хүчлэн хязгаарлах тусгайлсан аргаар хянах зорилго бүхий байгууламж, төхөөрөмж, эсхүл бусад биет байгууламжид явагдаж буй аливаа үйл ажиллагаа (any operation, undertaken within a facility, installation or other physical structure, which involves living modified organisms that are controlled by specific measures that effectively limit their contact with, and their impact on, the exter-

nal environment)-г хэлнэ;

g) “Хувиргасан амьд организм” (Living modified organism - живые измененные организмы) гэж орчин үеийн биотехнологийн аргыг хэрэглэж гарган авсан генетик материалын шинэ хослол бүхий аливаа амьд организм (any living organism that possesses a novel combination of genetic material obtained through the use of modern biotechnology)-ыг хэлнэ;

h) “Амьд организм” (Living organism) гэж генетикийн материалыг дамжуулах буюу нийлэгжүүлэх чадвар бүхий аливаа биологийн биетийг, үржих чадваргүй организм, вирусууд, виридууд (any biological entity capable of transferring or replicating genetic material, including sterile organisms, viruses and viroids)-ыг хэлнэ;

i) “Орчин үеийн биотехнологи” (Modern biotechnology) гэж дараах зүйлийг хэлнэ:

a) эрлийз ДНХ болон эс ба эрхтэнцэрт шууд ДНХ тарих зэргийг хамарсан нуклейны хүчлийг in vitro-д ашиглах аргууд (In vitro nucleic acid techniques,

including recombinant deoxyribonucleic acid (DNA) and direct injection of nucleic acid into cells or organelles);

- b) ангилал зүйн хувьд овгоос дээш ялгаатай организмуудын эсийг нийлүүлэхэд тулгуурласан аргууд (Fusion of cells beyond the taxonomic family, that overcome natural physiological reproductive or recombination barriers and that are not techniques used in traditional breeding and selection).

Протоколын 4 дугаар зүйл: Үйлчлэх хүрээ:

Энэ Протоколоор хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийн үүднээс биологийн төрөл зүйлд хортой нөлөө үзүүлэхүйц бүх төрлийн хувиргасан амьд организмыг хил давуулан тээвэрлэх, дамжуулан өнгөрүүлэх, түүнийг хэрэглэх, түүнтэй харьцах (Transboundary movement, transit, handling and use of all LMOs that may have adverse effects on biodiversity, taking also into account risks to human health) асуудлыг зохицуулсан.

Протоколын 5 дугаар зүйл: Эм зүйн бүтээгдэхүүнүүд (Pharmaceuticals):

Олон улсын бусад Хэлэлцээрээр, мөн олон улсын бусад байгууллагын дүрмээр зохицуулагдах, хүмүүс хэрэглэх зориулалттай эм зүйн бүтээгдэхүүнүүд (Pharmaceuticals for humans that are addressed by other international agreements or organisations) энэ Протоколд хамаарахгүй.

Протоколын 6-12 дугаар зүйл:

Улс орнууд хувиргасан амьд организмыг өөрсдийн нутаг дэвсгэрт оруулахыг зөвшөөрөхөөс өмнө шийдвэр гаргах шаардлагатай бүх мэдээллээр урьдчилан хангагдсан байхын тулд урьдчилан мэдээлж, зөвшилцөх журам (advance informed agreement (AIA) procedure - процедура заблаговременного обоснованного согласия)-ыг мөрдөх ёстой. Энэ журам нь зөвхөн импортлогч Талын нутаг дэвсгэрт зориудаар оруулах хувиргасан амьд организм (ХАО)-ыг хил давуулан тээвэрлэх анхны хөдөлгөөн (The first intentional transboundary movement of LMOs for intentional introduction into the environment of the Party of import)-д хамаарна. Энэ хөдөлгөөн дараах үе шатаар явагдана (Procedural steps):

- Экспортлогч Талаас, эсхүл экспортлогчоос ХАО-ыг экспортлох талаар мэдэгдэх (Notification by the Party of export);
- Импортлогч Тал уг мэдэгдлийг хүлээж авсан тухайгаа мэдэгдэх (мэдэгдэл хүлээж авснаас хойш 90 хоногийн дотор) (Acknowledgement of notification by Party of import);
- Импортлогч Тал шийдвэр гаргах (мэдэгдэл хүлээж авснаас хойш 270 хоногийн дотор) - урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эрсдэлийг тооцох, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг авч үзэх (Decision-making - the precautionary approach, risk assessments and socio-economic considerations);
- Шийдвэрээ эргэн хянах (шинэ мэдээлэл авсан/нөхцөл байдал өөрчлөгдсөн бол) (Review of decision (new information/change in circumstances)).

Дээрх журам дараах тохиолдолд хамаарахгүй:

- Дамжин өнгөрөх ХАО (LMOs in transit);
- Битүү системд/хязгаарлагдмал орчинд ашиглах ХАО (LMOs for contained use);
- Хоол, тэжээл болгон шууд хэрэглэх, эсхүл боловсруулах ХАО (LMOs intended for direct use as food or feed or for processing - FFP).

Хоол, тэжээл болгон шууд хэрэглэх, эсхүл боловсруулах ХАО-ыг улсын хилээр нэвтрүүлэхэд уг Протоколын 11, 13 дугаар зүйлийн дагуу хялбарчилсан журам мөрдөнө. Энэ журмын дагуу түүнийг импортлох шийдвэрийг энэ Протоколын зорилгод нийцүүлэн, дотоодын хууль тогтоомжийн дагуу гаргана. Тийм хууль тогтоомж байхгүй хөгжиж буй Талууд, эсхүл шилжилтийн эдийн засагтай Талууд тийм ХАО-ыг уг Протоколд заасан эрсдэлийн тооцоо хийсний үндсэн дээр анх импортлох тухайгаа Биологийн аюулгүй төрөл зүйлийн бүрдүүлэлтийн асуудал хариуцсан зуучлагч байгууллага (the Biosafety Clearing-House)-аар дамжуулан мэдэгдэнэ. Хил давуулан тээвэрлэж болзошгүй ХАО-г дотоодод хэрэглэх тухай шийдвэр гаргасан Тал энэ тухайгаа тийм шийдвэр гаргаснаас хойш 15 хоногийн дотор Биологийн аюулгүй төрөл зүйлийн бүрдүүлэлтийн асуудал хариуцсан зуучлагч байгууллагад мэдэгдэнэ. Ингэхдээ Хавсралт II-т заасныг баримтална.

Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай 1992 оны Риогийн Тунхаглал (Rio Declaration on Environment and Development - Рио-де-Жанейрская декларация по окружающей среде и развитию)-д заасан 27 зарчмын 15 дахь зарчмыг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарчим (the precautionary principle - принцип принятия мер предосторожности) гэх бөгөөд түүнд дараах зүйл тусгагдсан байна: “Улс орнууд хүрээлэн буй орчныг хамгаалах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг өөрсдийн бололцоо нөхцлийнхөө хирээр авч хэрэгжүүлбэл зохино. Ноцтой буюу нөхөгдөшгүй хохирол учирах аюул нөмөрсөн тохиолдолд шинжилгээ судалгааны үр дүн бүрэн төгс гараагүй байх нь хүрээлэн буй орчны доголдлыг зогсоох арга хэмжээг хойшлуулах шалтгаан болохгүй.”

Хувиргасан амьд организмын сөрөг нөлөөний талаар шинжлэх ухааны мэдлэг, мэдээлэл хангалттай бус байснаас шинжилгээ судалгааны үр дүн тодорхой бус байх нь импортлогч Тал хүний эрүүл мэндэд учирах эрсдэлийг харгалзан үзэж, шийдвэр гаргахад саад болохгүй (Протоколын 10.6 ба 11.8).

Протоколын Хавсралт III (Annex III on Risk Assessment)-т заасан нь: Шинжлэх ухааны

мэдлэг хомс байх буюу шинжлэх ухааны түвшинд зөвшилцсөн баталгаа байхгүй байх явдлыг эрсдэл тодорхой түвшинд хүрсэн, эрсдэл байхгүй, эсхүл эрсдэл хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд байна гэдгийг тодорхойлох үндэслэл болгон тайлбарлаж болохгүй (Lack of scientific knowledge or scientific consensus should not necessarily be interpreted as indicating a particular level of risk, an absence of risk, or an acceptable risk.).

Протоколын хавсралтууд:

Хавсралт I: 8, 10, 13 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл өгөхөд шаардагдах мэдээлэл (Information Required In Notifications under Articles 8, 10 and 13);

Хавсралт II: 11 дүгээр зүйлийн дагуу хүнс, тэжээл болгон шууд хэрэглэх, эсхүл боловсруулах хувиргасан амьд организмын талаар шаардагдах мэдээлэл (Information Required Concerning Living Modified Organisms Intended for Direct Use as Food or Feed, or for Processing under Article 11);

Хавсралт III: Эрсдэл тооцох (Risk Assessment).



24. Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенц (Стокгольмын Конвенц)

1.а. Гэрээний нэр англиар:	Stockholm Convention on Persistent Organic Pollutants (Stockholm Convention)
1.б. Гэрээний нэр оросоор:	Стокгольмская Конвенция о стойких органических загрязнителях (Стокгольмская Конвенция)
2. Гэрээ байгуулагдсан огноо, улс, хот:	- 2001-05-23. Швед Улсын Стокгольм хот - (Stockholm, Sweden)
3. Гэрээ хүчин төгөлдөр болсон огноо:	2004-05-17
4. Хэлэлцэн тохирогч Талын тоо:	2018 оны байдлаар: 182
5. Монгол Улс гэрээнд гарын үсэг зурсан, баталсан, соёрхон баталсан, нэгдэн орсон өдөр:	2002-05-17-нд гарын үсэг зурсан 2003-11-07-нд соёрхон баталсан
6. Гэрээ баталсан баримт бичгийг хадгалагч хүлээн авсан огноо:	2004-04-20
7. Монгол Улсын хувьд гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр:	2004-05-17
8. Гэрээнд тайлбар (Reservation) хийсэн байдал:	Тайлбаргүй
9. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан байдал: - Талуудын Бага хурлаас Хавсралт G-г нэмсэн.	
10. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоос: - “Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенци”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай 2003 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хууль	

Гэрээтэй холбогдсон бусад мэдээлэл:

Энэ Конвенц удаан задардаг органик бохирдуулагч (УЗОБ)-ийн үйлдвэрлэл, хэрэглээг зогсоох, хязгаарлах (to eliminate or restrict the production and use of persistent organic pollutants - POPs) зорилготой.

Удаан задардаг бүх органик бохирдуулагч бодисууд нь дараах чанартай байна:

- асар хортой (highly toxic): загас, шувуу, хөхтөн (хүн орно) амьтдын олон төрлийн хүнд архаг өвчлөл (many serious chronic diseases)-тэй холбоотой;
- тэсвэртэй (persistent): хор багатай байдалд шилжихэд маш урт удаан хугацаа шаардагддаг;
- хөдөлгөөнтэй (mobile): агаар, усаар дамжин хол газар тээгдэх чадвартай;
- био хуримтлал үүсгэдэг (bioaccumulating): амьтан, хүний өөхөнд хуримтлагдан үлддэг.

Одоогийн байдлаар дараах 12 төрлийн УЗОБ бодис байна:

- пестицид буюу зориудаар үйлдвэрлэдэг

УЗОБ (Pesticides- intentionally produced POPs (i-POPs)):

- альдрин (Aldrin);
- хлордан (Chlordane);
- ДДТ (DDT);
- дильдрин (Dieldrin);
- эндрин (Endrin);
- гептахлор (Heptachlor);
- токсафен (Toxaphene);
- мирекс (Mirex);
- гексахлорбензол (Hexachloro-benzene (HCB));

- үйлдвэрлэлийн зориулалттай бодис буюу зориудаар үйлдвэрлэдэг УЗОБ (Industrial chemicals - intentionally produced POPs (i-POPs)):

- мирекс (Mirex);
- гексахлорбензол (Hexachloro-benzene (HCB));
- олон хлорт бифенил (Polychlorinated biphenyls (PCBs));

- Зориудын бус дайвар бодис буюу зориуд бусаар үйлдвэрлэдэг УЗОБ (Unintentional by-products - unintentionally produced POPs

(u-POPs):

- гексахлорбензол (Hexachloro-benzene (HCB));
- олон хлорт бифенил (Polychlorinated biphenyls (PCBs));
- диоксин (Dioxin);
- фуран (Furans).

Хавсралт А болон В-д заасан химийн бодисыг зөвхөн байгаль орчинд ээлтэй технологийн дагуу устгах/захиран зарцуулах зорилгоор (for the purpose of environmentally sound disposal), эсхүл Конвенцид үл хамаарах тохиолдолд хэрэглэх зорилгоор (for an exempted use) импортлож болно.

Хавсралт А болон В-д заасан химийн бодисыг дараах гурван тохиолдолд экспортолж болно:

- тэдгээрийг байгаль орчинд ээлтэй технологийн дагуу устгах/захиран зарцуулах зорилгоор (for the purpose of environmentally sound disposal);
- тэдгээрийг Конвенцид үл хамаарах тохиолдолд хэрэглэх Хэлэлцэн тохирогч Тал руу экспортлох (to Party which has an exempted use of the chemical); эсхүл
- Стокгольмын Конвенцийн нөөц, хаягдлын тухай заалтыг дагаж мөрдөх, мөн хяналтанд байгаа бодисын үйлдвэрлэлийг зогсоох буюу багасгах арга хэмжээ авахаа батлан илэрхийлсэн Хэлэлцэн тохирогч бус Тал руу экспортлох (to a non-Party that certifies that it will comply with the stockpile and wastes provisions of the Stockholm Convention and will take necessary measures to prevent or minimize releases).

Энэ Конвенцоор зориудаар үйлдвэрлэдэг УЗОБ бодис (i-POPs)-ыг дараах байдлаар зохицуулсан байдаг:

- үйлдвэрлэх болон хэрэглэхийг хориглосон (no production, no use): эндрин, токсафен;
- үйлдвэрлэхийг хориглосон, хэрэглэхийг зарим тохиолдолд зөвшөөрсөн (no production, some use): альдрин, дильдрин, гептахлор, олон хлорт бифенил;
- үйлдвэрлэх болон хэрэглэхийг зарим тохиолдолд зөвшөөрсөн (some production, some use): хлордан, ДДТ, гексахлорбензол, мирекс.

Хэлэлцэн тохирогч Талууд Конвенцид үл хамаарах тохиолдлыг бүртгэж байх ёстой (must register for a specific exemption) бөгөөд тэр нь дуусгавар болох хугацаатай байна (each exemption

has an expiry date). Тухайлбал:

- олон хлорт бифенил (PCBs):
 - 2025 он гэхэд тоног төхөөрөмжийг бүртгэж, хаягжуулж, хэрэглээнээс хасна;
 - байгаль орчинд ээлтэй технологиор устгах/захиран зарцуулах зорилгоор экспортлоно;
 - хэрэглээнд байгаа бодисын менежментийг боловсруулна;
 - 2028 он гэхэд үйлдвэрлэл, хэрэглээг зогсооно.
- ДДТ (DDT):
 - үйлдвэрлэл, хэрэглээг зогсоох бус, багасгаж, хязгаарлах;
 - халдварт өвчний тархалтыг хянах зорилгоор үйлдвэрлэх, хэрэглэх;
 - түүнийг Конвенцид үл хамаарах тохиолдолд хэрэглэх Хэлэлцэн тохирогч Талууд энэ талаар бүртгэлтэй байх;
 - түүнийг Конвенцид үл хамаарах тохиолдолд хэрэглэх Хэлэлцэн тохирогч Талууд түүнийг өөрийн оронд хэрэглэх хэрэгцээ шаардлага, ашиглалтын байдал, түүний менежментийн талаар мэдээлэл гаргаж өгнө.

Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд дээрх бодисуудтай холбогдуулан дараах үүргийг хүлээнэ:

- одоо байгаа нөөц болон хаягдлын талаар мэдээлэл цуглуулах;
- одоо байгаа нөөцийг зохистой ашиглах менежмент боловсруулах;
- хаягдал устгах менежмент боловсруулах;
- бохирдол үүссэн газар (contaminated sites)-ын талаар мэдээлэл цуглуулах.

Энэ Конвенцоор УЗОБ бодисын зориудын бус үйлдвэрлэлийг (u-POPs) багасгах талаар Хэлэлцэн тохирогч Талууд холбогдох арга хэмжээ авахыг заасан. Үүнд дараах арга хэмжээ байж болно (Хавсралт С):

- хог хаягдлыг ил задгай шатаах (open burning of waste)-гүй байх, шатаах зуух хэрэглэх (incineration);
- ахуйн хэрэглээ (гэр хорооллын утаа)-г (residential combustion) багасгах;
- шингэн түлш хэрэглэдэг тээврийн хэрэгслийн тоог багасгах;
- үхсэн амьтдын сэг зэмийн ялзрал (destruction of animal carcasses)-ыг зайлуулах;
- байгаль орчинд ээлтэй технологи, арга

ажиллагаа (best available techniques - BAT/
best environmental practices - BEP)-ийг
дэмжиж, нэвтрүүлэн ажиллах.

Конвенцийн 7 дугаар зүйлд зааснаар, Хэлэлцэн
тохирогч Талууд Конвенцийг хэрэгжүүлэх
төлөвлөгөө (an implementation plan), мөн түүний
дагуу ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө (ac-
tion plans) боловсруулах ёстой. Мөн Конвенцийн
15 дугаар зүйлд зааснаар, дараах зүйлийн талаар
Талуудын Бага Хуралд тайлагнах (reporting)
үүрэгтэй:

- УЗОБ бодисын импорт, экспорт,
үйлдвэрлэл, хэрэглээний статистик тоо
баримт;
- УЗОБ бодисыг ямар ямар улсаас

импортлосон, ямар ямар улсад
экспортлосон.

Конвенцид мөн дараах асуудлууд тусгагдсан:

- Талуудын хооронд мэдээлэл солилцох;
- олон нийтэд мэдээлэх, ухуулан таниулах,
боловсрол олгох;
- дотооддоо болон олон улсын түвшинд
боловсрол, сургалтын хөтөлбөр
боловсруулан хэрэгжүүлэх;
- судалгаа шинжилгээ, боловсруулалт,
мониторингийн ажил зохион байгуулах;
- хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа
үзүүлэх.

Конвенц нь дараах 7 хавсралттай:

Хавсралт А: Устгах (Elimination - Ликвидация)

I Хэсэг:

Химийн бодис	Үйл ажиллагаа	Конвенцид үл хамаарах тохиолдол (Specific exemption - Конкретное исключение)
Альдрин CAS (Chemical Abstract's servise) № 309-00-2	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Орон нутгийн эктопаразит Инсектицид
Хлорден CAS № 57-74-9	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Орон нутгийн эктопаразитицид Инсектицид Термитицид Байшин барилга, гүүр далангийн термитицид Засмал замын термитицид Наамал банз, сарампайн цавууны нэмэлт
Дильдрин CAS № 60-57-1	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	ХАА-н үйл ажиллагаанд хэрэглэх
Эндрин CAS №72-20-8	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Байхгүй
Гептахлор CAS № 76-44-8	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Термитицид Барилгын хийцийн термитицид Термитицид (хөрсний) Ой модыг арчлах Газар доорх кабель шугамын ашиглалт
Гексахлорбензол CAS №118-74-1	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Завсрын бүтээгдэхүүн Пестицидийн уусгагч Завсрын бүтээгдэхүүнийг хязгаарласан битүү системийн хэсэг
Мирекс CAS№2385-85-5	үйлдвэрлэл	Бүртгэлд орсон Талуудад зөвшөөрөгдсөнөөр
	хэрэглээ	Термитицид
Токсафен CAS№ 8001-35-2	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Байхгүй
Олон хлорт бифенил (PCB)	үйлдвэрлэл	Байхгүй
	хэрэглээ	Энэхүү хавсралтын II хэсэгт заагдсан нөхцөлд хэрэглэнэ

II Хэсэг: Олон хлорт бифенил

Хавсралт В: Хязгаарлалт (Restriction - Ограничение)

I хэсэг

Химийн бодис	Үйл ажиллагаа	Зөвшөөрөгдөх зориулалт буюу Конвенцид үл хамаарах тохиолдол
ДДТ [1.1.1-трихлор -2.2-бис (4-хлорфенил) этан] CAS № 50-29-3	Үйлдвэрлэл	Зөвшөөрөгдөх зориулалт: Энэхүү хавсралтын II хэсэгт заасны дагуу өвчний нян тээгчийн хяналтанд ашиглах Конвенцид үл хамаарах тохиолдол: Дикофолын үйлдвэрлэлд завсрын бүтээгдэхүүн байдлаар Завсрын бүтээгдэхүүн
	Хэрэглээ	Зөвшөөрөгдөх зориулалт: Энэхүү хавсралтын II хэсэгт заасны дагуу өвчний нян тээгчийн хяналт. Конвенцид үл хамаарах тохиолдол: Дикофолын үйлдвэрлэл Завсрын бүтээгдэхүүн

II хэсэг: ДДТ (1.1.1 трихлор-2, 2-бис(4-хлорфенил) этан)

Хавсралт С: Зориудын бус үйлдвэрлэл (Unintentional Production - Непреднамеренное производство)

Хавсралт D: Химийн бодисыг Конвенцийн хавсралт А, В, С-д оруулахад шаардлагатай мэдээлэл, шалгуур үзүүлэлтүүд (Information Requirements and Screening Criteria - Требования в отношении информации и критерии отбора)

Хавсралт E: Эрсдэлийн тодорхойлолт гаргахад шаардлагатай мэдээлэл (Information Requirements For The Risk Profile - Требования в отношении информации, необходимой для характеристики рисков)

Хавсралт F: Нийгэм, эдийн засгийн холбогдолтой мэдээлэл (Information On Socio-Economic Considerations - Информация о социально-экономических соображениях)

Хавсралт G: Арбитрын журмаар болон эвлэрэх журмаар маргаан шийдвэрлэх (Arbitration and Conciliation Procedures for Settlement of Disputes - Процедура арбитражного разбирательства и согласительная процедура для урегулирования споров)

